



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

ЭРДЭМ

ШИНЖИЛГЭЭ



ISSN: 2791-1446

© Sodon Soyod Publishing, Mongolia



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

БОТЬ III

Редакцын зөвлөл:

Доктор (Sc.D)	Д.Бадамдорж	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Чулуунбаатар	(Монгол)
Доктор (Ph.D)	Н.Мягмар	(Монгол)
Доктор (Ph.D)	Л.Хурцбаатар	(Герман)
Доктор (Ph.D)	Л.Хасбаатар	(БНХАУ)
Доктор (Ph.D)	Б.Болд	(Япон)
Доктор (Ph.D)	Залгаабаяр	(БНХАУ)

Ботийг эрхэлсэн: Э.Итгэл



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

VOLUME III

Editorial board:

Doctor (Sc.D)	Badamdorj. D	(Mongolia)
Doctor (Ph.D)	Chuluunbaatar. L	(Mongolia)
Doctor (Ph.D)	Myagmar. N	(Mongolia)
Doctor (Ph.D)	Qurčabaatar. L	(Germany)
Doctor (Ph.D)	Qasbaatar. L	(China)
Doctor (Ph.D)	Bold. B	(Japan)
Doctor (Ph.D)	Zalgaabayar	(China)

Edited by: Itgel. E



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ГАРЧИГ

КАНЬ ХАЙ ИН	1
<i>МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ОРЧУУЛГЫН УТГА ЗОХИОЛЫН ТҮҮХИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ</i>	
АЯС	33
<i>АМЬ АХУЙН УХАМСРЫН ИЛРЭЛ</i>	
ШҮРЭЭ.У, МӨНХСАЙХАН. С, БАТБЯМБА. Т	42
<i>“ӨДРИЙН СОНИН”-Ы ҮГИЙН САНГИЙН ДАВТАМЖИЙГ СУДАЛСАН НЬ</i>	
ЖЯН ЮАНЬ	53
<i>ИХ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН ПРЕСТЕР ЖОНН-ИЙ ТУХАЙ ӨГҮҮЛЭХ НЬ</i>	
ЧАНЖЯН, ШУДАРГА	61
<i>ЛУО РИЖЮН-ИЙ “ШЯНЬ БИНЬ ЛҮ” ЗОХИОЛЫГ ХЯНАХ НЬ</i>	
АМАРТҮВШИН. Б	74
<i>ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ГАЛЫГ ӨӨРТӨӨ ТАТСАН НЬ</i>	
ЧУЛУУНБААТАР. Л	82
<i>ЛАМ НАРЫН СЭТГҮҮЛИЙН ТУХАЙ</i>	
ХАСБААТАР. Л	92
<i>ИЛГЭЭЛТИЙН ШҮЛГИЙН АРГААР ЭНЭ ДЭЛХИЙТЭЙ ХАРИЛЦАЖ БАЙСНЫ УЧИР</i>	
АРИУНБОЛД. А	116
<i>ЧИН УЛСЫН ШИНЭ ЗАСГИЙН БОДЛОГО ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН НЬ</i>	
СОЛОНГОД ХУРЦБААТАР	134
<i>ОРДОСЫН ТЭЛЭНГҮД ОВОГ ХИЙГЭЭД ДУУДАГЧИЙН ТУХАЙ</i>	



СОЁЛЫН ЖИМЭЭР
THE CULTURAL WAY

CONTENT

KAN HAI YING

*ON THE DISSEMINATION OF MONGOLIAN TRANSLATION IN MODERN
CHINESE LITERATURE (1976-2013)*

AYAS

MANIFESTATION OF NATURAL

SHUREE, MUNKHSAIKHAN, BATBYAMBA

STUDIED ON WORD FREQUENCIES OF "DAILY NEWSPAPER" 11.03.2020

YUAN JIANG

RESEARCH OF PRESTER JOHN IN THE PERIOD OF YEKE MONGOL ULUS

CHANGJIANG, XIDUO RIGU

ANALYZING "XIAN BIN LU" OF LUO RIJIONG

AMARTUVSHIN. B

REPRESSION AND AMAR. A

CHULUUNBAATAR. L

JOURNAL OF LAMAS

QASBAATAR. L

WRITING POEMS BY MISSION DISPATCH

ARIUNBOLD. A

*THE IMPLEMENTATION OF THE NEW STATE POLICY OF THE QING
DYNASTY*

QURČABAҮATUR SOLONGGOD

ABOUT THE TELENGGUD OF ORDOS



СОЁЛЫН ЖИМЭЭР THE CULTURAL WAY

ТАЛАРХАЛ

Тус сэтгүүлийн энэ удаагийн дугаарыг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн “Соёлын Жимээр” ССТ-ийн редакцын зөвлөл болон МҮИС-ийн профессор Л.Чулуунбаатар, ШУТИС-ийн багш А.Ариунболд, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Т.Батбямба, ӨМИС-ийн багш Кань Хай Ин, Олон Улсын Монгол Брахми судлалын нийгэмлэгийн тэргүүн Солонгод Л.Хурицаатар нарт онцгойлон талархал илэрхийлье.

Эрхлэн хэвлүүлэгчээс

**МОНГОЛ ҮНДЭСТНИЙ ОРЧУУЛГЫН УТГА ЗОХИОЛЫН ТҮҮХИЙН
СУДАЛГААНЫ ТОЙМ****Кань Хай Ин *****ХУРААНГУЙ**

Монгол хятад утга зохиолын харилцаа холбоог судлах нь одоогийн монгол утга зохиол судлал дахь орчуулгын утга зохиолын түүх судлал, үндэстний утга зохиолын харилцааны түүх судлалд чухал үнэ цэнэтэй байж, энэхүү судлалын цар хүрээ нь харьцуулсан судалгааны өргөн боломжийг хангасан мөртөө энэ хүнд үүргийг харьцуулсан утга зохиол судлал хүлээн авах хэрэгтэй болсон байна. Монгол орчуулгын утга зохиолыг утга зохиолын түүхэн нэг бүрэлдэхүүн болгож судлах нь чухал ач холбогдолтой эрдэм шинжилгээний сэдэв мөн. Дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орон дахь тархалт жич түүний нөлөө тусгалыг гардан судалж, зарим балархай зүйлийг тодруулах нь тулгам үүрэг болж байна. Шинэ эринээс нааш 40-өөд жилийн судалгааны байдлыг ажиглавал, 70 гаруй өгүүлэл шүүмж шинэ зуунаас өмнө нэлээд олон нийтлэгдэж, ойрын хэдэн жилд тоотой хэдхэн өгүүлэл нийтлэгдсэн байна. Голдуу зохиогчийн судалгаа, зохиол бүтээлийн судалгаа, урлагийн судалгаа зэрэгт төвлөрч, Лү Шюнь жич түүний зохиол бүтээлийн судалгааны өгүүлэл шүүмж хамгийн олон нийтлэгдэж, бусад зохиолчдын зохиол бүтээлийн судалгааны өгүүлэл шүүмж дараах байрыг эзэлж байна. Судалгааны өгүүлэл зохиолыг өмнөх үетэй харьцуулбал, судалгааны чиглэл тэлж, харьцуулж судлах, тусгайлан судлах, сэргээн судлах, хураангуйлан судлах ба цөөн хэдэн эмэгтэйчүүдийн уран зохиолын чиглэлийн судалгаа зэрэг нь өргөн хүрээнд гүнзгийрч байна.

Түлхүүр үгс: Монгол үндэстний утга зохиол, орчуулгын утга зохиолын түүхийг судлахын учир, судалгаа

* ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн багш, Ph.D, судалгааны чиглэл-Харьцуулсан уран зохиол ба дэлхийн уран зохиол



THE CULTURAL WAY

Монголчууд орчуулгаар дамжин харь бусдын соёлыг шингээж байсан эртний уламжлалтай билээ. Монгол орчуулгын тухай анхны түүхэн мэдээг Я.Владимирцов “Панчатантарын монгол үлгэрийн цоморлог” (1921) гэх номынхоо оршилд мэдээлжээ¹. Монгол утга зохиолын түүх шинжлэл боловсрон хөгжсөн нь 20 дугаар зууны дунд үе болно. Б.Содном, Ц.Дамдинсүрэн нарын монгол утга зохиолын түүх нийтлэгдсэний дараах хагас зууны турш, холбогдох бүтээл нь бүгд үелсэн түүх бөгөөд түүх бичлэгийн тусгай судлал – “Монгол утга зохиолын түүх зүй” шиг тусгайлан судалсан бүтээл бараг байхгүй. Эдгээр нь монгол утга зохиолын судалгаа шинжилгээг санаачлах эрдэм шинжилгээний урьдач нөхцөл болох бөгөөд монгол утга зохиолын байдлын хуримтлал ба онолын боловсруулалт зохих хүрсэн зайлшгүй хөгжил болох ёстой. С.Урсгал “Хорьдугаар зууны монгол утга зохиолын түүх зүйн судлал” энэ системд орчуулгын утга зохиолын түүхийг олтгойлж болшгүй юм. “Хагас зууны дараах өнөөдөр, хүмүүс мөн үүнийг санаачлан өгүүлсээр л байна”².

Нэг. Судалгааны өгүүлэл

Шинэ эринээс нааш монгол үндэстний эрт, орчин үе, өнөө үеийн шүлэг, туужис, онол шүүмжийн тухай өгүүлэл шүүмж олон нийтлэгдсэнээс биш судлаачдын үзэл дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгад төдий л анхаарсангүй. 40-өөд жилийн судалгааны байдлыг ажиглавал, 70 гаруй өгүүлэл шүүмж шинэ зуунаас өмнө нэлээд олон нийтлэгдэж, ойрын хэдэн жилд тоотой хэдхэн өгүүлэл нийтлэгдсэн байна. Голдуу зохиогчийн судалгаа, зохиол бүтээлийн судалгаа, урлагийн судалгаа зэрэгт төвлөрч, Лү Шюнь жич түүний зохиол бүтээлийн судалгааны өгүүлэл шүүмж хамгийн олон нийтлэгдэж, бусад зохиолчдын зохиол бүтээлийн судалгааны өгүүлэл шүүмж дараах байрыг эзэлж байна. Судалгааны өгүүлэл зохиолыг өмнөх үетэй харьцуулбал, судалгааны чиглэл тэлж, харьцуулж судлах, тусгайлан судлах, сэргээн судлах, хураангуйлан судлах ба цөөн хэдэн эмэгтэйчүүдийн уран зохиолын чиглэлийн судалгаа зэрэг нь өргөн хүрээнд гүнзгийрч байна. Үүнийг төрөлжүүлбэл доорх мэт:

¹ С.Урсгал: “Монгол шүлэг зүйн түүхэн тогтолцоо”, ӨМСХХХ, 2000 т 64.

² 谢天振: 《中国翻译文学史: 实践与理论》, 《中国比较文学》, 1998年第二期, 第19页。



1. Зохиогчийн судалгаа

(1) Тусгай судалгаа

Оюунцэцэгийн өгүүллүүд нь Лү Шюнь-ий үзэл санаанд системтэй судалгаа хийхээр хичээсэн байна. Тэрээр “Соёл сэтгэлгээний талаар А Q-ийн зориг санааны эх сурвалжийг шинжлэх нь” (УХДСЭШС.2006.2) хэмээх өгүүлэлдээ, соёл сэтгэлгээний ухааны талаас “төсөөлөн бодохоор ялгах арга” жич түүний судлан мэдсэн зан суртлыг задалж, А Q-ийн зориг санааны эх сурвалж бол бичгийн сургаал ба бумбын сургаал, шагжамуни шашны гүн ухаан зэргээс бүрэлдсэн “дотоодыг хөөцөлдөх” сэтгэлгээ болон феодалын уламжлалт үзэл санаа ёс суртахуун болохыг өгүүлсэн байна. “Лү Шюнь-ий улс иргэний чанарын шүүмжлэлд зөв хандах тухай” (УХДСЭШС.2006.4) гэх өгүүлэлд, Лү Шюнь-ий улс иргэний чанарын шүүмжлэлд авч байгаа зарим хүмүүсийн буруу үзлийг дурдсаны дараа, энэ асуудалд зөвөөр хандахад эрхбиш Лү Шюнь-ий улс иргэний чанарын шүүмжлэлийн агуулагдахуун ба түүний зорилго шаардлага жич тухайн үеийн түүхт ахуй байдалтай уялдуулан ойлгох тухай бодитой өгүүлж, Лү Шюнь-ий туужис бүтээлийн онцлогийг хайсан байна. “Лү Шюнь-ий уламжлалын шүүмжлэлийг зөв таних тухай” (УХДСЭШС.2007.1) өгүүлэлд, Лү Шюнь-ий уламжлалын шүүмжлэл нь хурц ширүүн байдгийг зөв танихад заавал түүний уламжлалд авсан сэтгэхүйн арга болоод хэлсэн үг ярианых нь орчин тойрныг зөвөөр ойлгож, түүний хурц ширүүн авир нь дундад улсын хүний зан чанарт чиглүүлж тогтоосон арга бодлого болно. Тэрээр шаарыг нь хаяж содыг нь авч эмхлэн тэглэж залгамжлан шинийг үүдгэх ажлыг хийсэн гэдгийг зөвөөр ойлгох хэрэгтэй гэжээ. “Лү Шюнь-ий соёлын шилжилтийн тухай бүтээлийн ач холбогдол” (УХДСЭШС.2007.3) өгүүлэлдээ, Лү Шюнь гадаадын хөгжсөн соёлд яаж хандах, өрнө дахины боловсон байдлыг хэрхэн сонголттойгоор шингээн авах өрөөсгөлөөр хөгжүүлэхээс зайлсхийж, хүний чөлөөлөлт ба үндэстний зориг санааны дахин байгуулалтыг анхаарах тухай бодолхийлсэн нь тун гүн байж, одоогийн өөрчлөлт гэж чөлөөтэй явах ба “хоёр боловсон”-ы бүтээн байгуулалтыг түлхэн ахиулахад бүгд бодитой ач холбогдолтой гэдгийг хураангуйлсан байна.

Фу Гө-ийн “Хэв дундын үзэл санааны тухай Лү Шюнь-ий шүүмжлэл” (Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл.2002.6) гэх өгүүлэлд, юуны учир бичгийн сургаалтнаас хэв дундын ёсыг эрхэм



THE CULTURAL WAY

болгон үзэж, хүмүүсийн суртал боловсрол, ёс суртахууны үзэл болгож байсан нийгмийн үндэс сурвалжийг эрж хайсан бөгөөд Лү Шюнь-ий зохиол бүтээлд илэрдэг хэв дундын үзэл санааны хоронд гүн автсан нийтлэг дүрийг задлахаар дамжин, хэв дундын үзэл санаа бол хүний оюун санааг хүлээслэн, харалган болгож, үйл ажиллагааг назгайруулж, үнэн худлыг хутгалдуулж, зөв бурууг гажуудуулан, сайн мууг самууруулдаг хэрэггүй зүйл болохыг нотолсон бөгөөд одоогийн нийгмийн бодит байдал, оршиж байгаа асуудлуудтай уялдуулан, хэв дундын үзэл санааг тэвчин хаяхыг санаачилжээ. Чин Лун, Ч.Саруулын “Лү Шюнь-ий орчуулан хэвлүүлэх үзэл санааны тухай” (УХДСЭШС.2006.1) гэх өгүүлэлдээ, Лү Шюнь их хэмжээний орчуулан хэвлүүлэх үйлдлийн суурин дээр тэр нь л онц байдаг орчуулан хэвлүүлэх үзэл санаа болон ажлын зарчмыг бүрэлдүүлэн, хожмын үе олон орчуулан хэвлүүлэгчдийн суралцууштай үлгэр дуурайл болсоор байна гэж үзжээ. Дээрх өгүүллүүд Лү Шюнь-ий зориг санааны эх сурвалжийг зөв талаас хайн сүвэгчлэхээр хичээж, өөр өнцгөөс үнэлсэн өгүүлэл тун цөөн нийтлэгдсэн байна.

Ван Шуо-ийн “Лү Шюнь-ий тухай миний үзэл” (Жиримийн уран зохиол.2001.2) гэх шүүмжид, Лү Шюнь бол их бичгийн хүн, үзэл санааны хошууч, шинэ соёлын хөдөлгөөний гол жанжин, яс нь хамгийн хатуу, бийрээрээ туг, жад буюу хутга болгож, усанд унасан нохойг нэвширтэл цохих, өчүүхэн ч норолгүйгээр аливаа харанхуй харгис хүчтэй байлдах зориг санаатай хэмээн үнэлжээ. Лү Шюнь “Галзуу хүний өдрийн тэмдэглэл”-ээ бичих үедээ өөрийн нэрээр нийтэлсэн ба үүнээс өмнөх бичгийн нэр авсан Чин Лун-ий “Лү Шюнь бичгийн нэр авсан учир” (ӨМҮИСЭШС.1995.4) гэх өгүүлэл бий. “Лү Шюнь-ий тухай халуурлын гурван их онцлог” (Ордос сонин.1998.4.18) хэмээх өгүүлэлд, нэгт Лү Шюнь-ий үзэл санаа нь өнөөгийн соёлын бүтээн байгуулалтын “оюун санааны эх баялаг” болсон ач холбогдлыг шинээр дахин үзэж, хоёрт Лү Шюнь бол “уян хатан чанартай сэхээтэн болох” гэсэн шинэ үзэлтэй болж, гуравт Лү Шюнь ба түүний соёлын маргалдагчийн хоорондох зөв бурууг шинээр үнэлэв.

Ялгуусанбаатарын “Гуо Морую-ийн дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхэн дэх гавьяа зүтгэлийг үнэлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1993.1) гэх өгүүлэлд, Гуо Морую бол дундад улсын



THE CULTURAL WAY

орчин үеийн шинэ утга зохиолын хөдөлгөөний шилдэг зохион байгуулагч бөгөөд ахиулагч, орчин үеийн шинэ шүлгийн үндэслэгч, шинэ түүхт жүжгийг тасралтгүй зохион бүтээж, тухайн үеийн хувьсгалт тэмцлийг ихээр дэмжсэн, чөлөөт үзлийн гарамгай төлөөлөгч гэж өндрөөр үнэлсэн байна. “Мао Дүн-ий дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхэн дэх гавьяа зүтгэлийг үнэлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1997.1) өгүүлэлд, Мао Дүн бол дундад улсын орчин үеийн шинэ утга зохиолын хөдөлгөөний үндэслэгч, шилдэг зохиол бүтээлээрээ орчин үеийн утга зохиолын түүх жич онолын бүтээн байгуулалтад маш их хувь нэмэр үзүүлсэн, орчин үеийн ахуйч үзэл/*марксизм*-ийн утга урлагийн шүүмжийг үндэслэгч, гадаадын утга зохиолыг орчуулах ба танилцуулах талаар аугаа үйл бүтээсэн хэмээн Мао Дүн-ий хийсэн ажил, бичсэн уран зохиол, онол шүүмж, орчуулга зэрэг хэдэн талаас нь гавьяа зүтгэлийг дурсан үнэлжээ.

Чимэгийн “Лао Шө-ийн дундад улсын уламжлалт соёл сэтгэлгээний тухай эргэцүүлэл болон шүүмжлэл” (Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл.2005.3) өгүүлэлд, Лао Шө-ийн зохиол дахь шинэ хуучны солилцол болон дундад өрнөдийн харьцууллаас үндэстнийхээ соёл сэтгэлгээг хайн шинжсэн ба Бээжин хотын ардын нийгмээр чиглэл дэлгэц болгож үндэстний соёл сэтгэлгээг уудалж тунгаасан гэх хоёр талт үзлээ нотолсон байдаг. Т.Баянбулагийн “Ардын уран сайханч Лао Шө” (ӨМҮИСЭШС.1995.3) гэх өгүүлэлд, түүний жүжгийн урлагийн онцлогийг ардын дотоодын зөрчлийг шийдвэрлэхэд зайлшгүй баатар хүмүүс, хүмүүсийн хувиралттай холбогддог гэж Лао Шө-ийн уг үзлийг уламжлан бадруулж, хурц тод хайр хорсолт сэтгэлгээг илтгэж чаддаг онцлогийг задалж, хэллэг нь амьдлаг, өвөрмөц зан чанаржуулсан байдаг гэж хэлний чадамгай бөгөөд олон чадвар авьяастай, кино жүжиг, аялгуут урлаг, туужсын зохиол, найруулал бүгдэд гүн боловсролтой болохыг нотолжээ. Үүнээс гадна “Жан Тянь И-ийн зохион бичих гэрээ” (Алтан түлхүүр.1981.1) өгүүлэлд, арван зурвас гэрээг жагсаажээ. Дээрх өгүүлэлүүд нь зохиогчийн уран зохиолын түүхэн дэх байр суурь, гавьяа зүтгэл, нөлөө үйлдэл зэргийг өндөр үнэлж, зохиогчийн зарим алдаа дутагдлыг нь өөрөөр үнэлж дурдсан өгүүлэл харагдсангүй.

(2) Харьцуулсан судалгаа



THE CULTURAL WAY

Утга зохиолын судалгаа бол хоёр адил бус давхаргаас ялгаж болдог. Нэг давхарга нь утга зохиолын онол, утга зохиолын шүүмжлэл ба утга зохиолын түүх, нөгөө нэг давхарга нь улс ялгалын утга зохиол, харьцуулсан утга зохиол ба ерөнхийлсөн утга зохиолын судалгаа болно³. Чин Лун-ий “Лү Шюнь, Сайчунгаа хийгээд хувьслын онол” (ӨМҮИСЭШС.2002.3) өгүүлэлд, тухайн нийгмийн улс төр, соёл түүхийн үүднээс шинэ соёлын хөдөлгөөний хоёр том – Лү Шюнь хийгээд Сайчунгаагийн Дарвиний хувьслын онолын нөлөөг хүртэж, японд суралцах үеийн сэхээрүүлэх үзэл санааны онолын сууриа болгосон талаар хамтрах онцлог, адилавар ялгаралтай байхыг зохиол бүтээлээр нь жишээлэн харьцуулан шинжлэх аргаар тодорхойлохыг зорив. “Сайчунгаа болон Лү Шюнь-ий японд суралцах үеийн ардчилсан үзэл санааг харьцуулан шинжлэх нь” (Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл.2002.2) гэх өгүүлэлд, Сайчунгаа ба Лү Шюнь-ий японд суралцаж байх үедээ бичсэн өгүүлэл зохиолоор үндсэн баримт болгон тэд нарын тухайн үеийн үзэл санааных нь төсөөтэй онцлогийг харьцуулан шинжлэв. Чин Лун, Д.Булагийн “Сайчунгаа болон Лү Шюнь-ий японд суралцаж байсан үеийн хүмүүнч чанараар голлосон сэхээрүүлэх үзэл санааг харьцуулан шинжлэх нь” (МХУЗ.2003.4) өгүүлэлд, монгол хятад үндэстний шинэ соёлын том илэрхийлэл болсон Сайчунгаа, Лү Шюнь улс үндэстнээ авран, хүнийг сэхээрүүлэхийг тэргүүн чухал асуудал болгон сүвэгчилж, хүнийг босгох, хүнийг сэхээрүүлэх хүмүүнлэг үзэл санаа бол хоёр зохиолчийн үзэл санааны төсөөтэй онцлог болно хэмээн шинжилжээ. “Лү Шюнь, Н.Сайнцогт хийгээд ардын аман зохиол” (ӨМҮИСЭШС.2000.2) гэх өгүүлэлд, Лү Шюнь болон Н.Сайнцогтын ардын аман зохиолоос суралцаж, аман зохиолын өв удамшлыг шүүмжлэлтэйгээр шингээн авч, уран бүтээлдээ хэрхэн бүтээлчээр ашигласан авьяас чадвар ба уран сэтгэхүйг нь жишээ баримттай уялдуулан өгүүлэхээр дамжуулан, харьцуулан дүгнэх аргаар тэдний аман зохиол ба амьд яриан хэлнээс шим тэжээл авч, шинийг үүдэн шилдгийг бүтээсэн талаар хамтрах арга барил, адилсах онцлог шинжтэй байгааг тодорхойлохоор зорив.

Улсын ард иргэний чанарын шүүмжлэлийн онол нь үнэндээ “үндэстний чанар”-ын харьцуулшгүй магадлал, үндэстний оршихуйн

³ 王向远著：《翻译文学导论》，北京师范大学出版社，2004年，第240页。



THE CULTURAL WAY

хэлбэр, байгууламжийн соёлын суртал ба эргэцүүллийг сольж авч ирдэг⁴. Иргэний удам магад чанарын шүүжлэлийн зайлшгүй чанар нь дундад улсын соёлын дотоод эргэцүүлэл, өрнө дахины соёлын өргөжилт түрэлтийн шахалт доор, өрнө дахины колоничлолын ноёрхол их хэмжээний гүнзгийрсэн хэлэхүйн орчинд буй болсон байна⁵. Дорнотэнгэрийн “Шинэ соёлын манлай баатар – Лү Шюнь ба Сайчунгаа” (МХУЗ.1997.5) гэх өгүүлэлд, иргэний чанар – “Удам муут чанар” хийгээд “муу гэм”, хүмүүнлэг үзэл – “бодгаль хүн” хийгээд “бүрэн хүн” гэх хоёр талаас нь задлан өгүүлжээ. Энэ өгүүлэл нь Лү Шюнь-ий зохиолын утга сэдэв үзэл санааны байдалд хүчтэй задлал хийсэн хүндтэй өгүүлэл болсон байна.

Б.Мөнхдалайн “Лү Шюнь болон Д.Нацагдоржийн зохиол бүтээлийн харьцуулал” (Зуу-үдийн монгол үндэстний тусгай мэргэжлийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1992.4) гэх өгүүлэлд, зохиолд тусгасан тухайн нийгмийн бодит байдлын үзэл санаа, зохион бүтээх хэлбэрийн нийтлэг дүрийг бүтээх ижил талтай гэж хураангуйлан, Лү Шюнь хятад үндэстний утга зохиолын түүхэн дэх нийгмийн амьдралыг дээд хэмжээгээр хураангуйлан амьд дүрслэг хэллэгийг гарамгай хэрэглэдэг, харин Д.Нацагдорж бол нийгмийн үзэгдлийн аль чухал зүйлийг сонгон бичих онцлогтой гэх ижил бус талыг нь дурдсан байна. Бүрэнмэндийн “Лү Шюнь-ий < Үүдний гадаах бичгийн зоог > ба Инжаннашийн < Хөдөөгийн өвгөний оршил > (Монгол хэл утга зохиол.2002.3) гэх өгүүлэлд, хоёр зохиолыг харьцуулан шинжлэхээр дамжуулан, энэ хоёр зохиолч хэдийгээр адил бус хоёр үндэстний бичгийн хүн, адил бус хоёр цаг үе амьдарч, адил бусын боловсролыг эзэмшсэн боловч үзэл санаа, зорилт нь адилавар мөртөө давшингуй талтай тул тэр нь бидний суралцууштай соёлын өв болно гэж дурджээ. С.Тэргэл “Орчин үеийн хоёр их бичгийн хүн Лү Шюнь болон Хадыг харьцуулах нь” (МХУЗ.2008.1) гэх өгүүлэлдээ, Лү Шюнь болон Хадын үзэл зорилт иргэний чанарыг өөрчлөх хэлбэр, иргэний чанарыг өөрчлөх зорилго, үндэстэн угсаатнаа авран тэнхрүүлэх арга зам гэх гурван талаар харьцуулан үзвэл адил бус талтай. Үүнийг буй болгосон

⁴ 乌日斯嘎拉：《蒙古族翻译文学史研究述评》，内蒙古师范大学学报，哲学社会科学版，2003年第4期，第12页。

⁵ 乐黛云：《帝国霸权，文化自觉，比较文学》，《中国比较文学》，2004年第一期。



THE CULTURAL WAY

нөхцөл шалтгаанд голдуу үндэстэн угсаатны учрал тохиолдол, хувь хүний эзэмшсэн боловсрол зэрэг холбогдоно гэж үзжээ. Бай Шань-ий “Ролгаржавын < Өөрөө тогтнохуй > дурдал ба Лү Шюнь-ий < Хүнийг эрхэмлэхүй > дурдалыг нийгмийн түүхэн нөхцөл, тэдний зохиол бүтээлээс шинийг үүдэн бүтээх зориг санааг хөөцөлдсөн нь тодорхой гэж харьцуулан өгүүлжээ. Чин Лун-ий “Тэмээт болон Лү Шюнь-ий найруулан хэвлүүлэх үйлсэд үзүүлсэн хувь нэмрийг харьцуулан шинжлэх нь” (МХУЗ.2005.5) гэх өгүүлэлд, Тэмээт болон Лү Шюнь-ийг нийгэм түүхийн урт урсгалд зэрэгцүүлэн тавьж, ширхэгчлэн харьцуулахаар дамжуулан, тухайн үед тэд нарын сонин сэтгүүлийг идэвхтэй эрхлэн ном бичгийг эрчимтэй орчуулан найруулж, өргөнөөр хэвлүүлэн тархааж, дундадын хүн ардыг сэхээрүүлэх иргэнч чанарыг нь өөрчлөн, үндэстнээ соёлжуулан хөгжүүлэхээр махран зүтгэсэн адилхан үзэл зорилт хамтрах үзэл санаатай байж гэсэн үзлийг дэвшүүлэв. Эдгээр өгүүллүүд нь хоёр зохиогчийг зэрэгцүүлэн харьцуулахаар дамжин, ижил ба ижил бус талыг илрүүлэхээр хичээсэн байхад дараагийн өгүүлэл нь нөлөө судлалын аргыг хэрэглэсэн байна.

Горхийн “Лү Шюнь хийгээд Байрон” (Өвөр монголын үндэстний их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1982.1) гэх өгүүлэлд, Лү Шюнь Байроны нөлөөг харгис хүчнээс эрс хагацан салах “хөмсөг зангидан хүчтэн сүртэнд хүйтнээр хандах”, дарлагдаж байгаа ард түмний “завшаан бус учралд гашуудах бөгөөд тэдний тэмцэл хийхгүйд нь хилэгнэх”, утга урлагийн үзэл санаач чанар ба дайчин чанарыг чухалчилж дан ганц байгалийн үзэмжийг уянгалан магтах ба ноёрхогч ангид эгшиг өргөхийг эсэргүүцэх зэрэг талаас хүртсэн гэж хураангуйлжээ. Сайнзаяагийн “Дундад улсын шинэ соёлын тугч – Лү Шюнь-ээс суралцъя” (Хөлөн буйр дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1995.2) гэх өгүүлэл бий. Н.Сайндэлгэрийн “Мао Зөдун < Халамжил >-ын тухай хувийн сэтгэгдэл” (Өвөр монголын их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1993.4) гэх шүүмжид, эн тэргүүнд Мао Зөдун < Халамжил >-ын бодитой илрэл, үүнд хэвлэлийн этгээд, эрдэм шинжилгээний фронт нийгмийн бүх этгээд зэрэг байж, дараа нь Мао Зөдун < Халамжил > буй болсон шалтгаан, үүнд Мао Зөдун-ийг үгүйсгэх гэсэн үзэл санааны урсгал, Мао Зөдун < Халамжил >-ын улс төрийн шалтгаан, аж ахуйн шалтгаан, хамгийн сүүлд Мао Зөдун < халамжил >-ын идэвхтэй тал ба анхаарууштай тал зэргийг өгүүлсэн байна. Дээрх



THE CULTURAL WAY

өгүүлүүд нь гадаадын буюу хятадын, ар монгол буюу хятадын, ойрх үе буюу орчин үеийн, хятад буюу монголын хоёр нэртэй зохиолчийн үзэл буюу хоёр нэртэй зохиолчийн зохиол бүтээлийг харьцуулан өгүүлж, ижил тал ба ижил бус тал байх жич ямар нөлөө тусгал хүртээсэн зэрэг талаар нийтлэг жишээ баримтаар нотлохыг хичээсэн байна.

2. Зохиол бүтээлийн судалгаа

(1) Тусгайлсан судалгаа

Оюунцэцэгийн “Лү Шюнь-ий туужис бүтээлийн түүхэн байр суурь” (Улаанхадын дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.2007.3) гэх өгүүлэлд, түүний туужсын зохиолыг унших явцад тулгарч мэдэх асуудлын эргэн тойронд, туужсын зохиол бүтээлийн үндсэн гүн аясыг ойлгох тухай, уламжлалт туужист хувьсгалт чанартай эрчимжүүлэлт хийсэн тухай сэдэв материал, оюун сүнсний гүн чанадыг илрүүлсэн, хэлбэрийн талаарх эрчимжүүлэлт хийсэн зэрэг гурван талаар ерөнхийлсөн судалгаа хийсэн байна.

Хангайн “А Q-ийн жинхэнэ намтрын тухай Линь Шинзай-ийн судлалыг өгүүлэх нь” (Өвөр монголын багшийн их сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1990.1) гэх өгүүлэлд, А Q-ийн зан чанар бол нэгэн будлиант систем, төрөлх шинж, үйлдэлч шинж, системч шинж зэрэг талаас задлалт хийж, зарим талаар өнгөрсний судлалыг хялбар цулгүй үгүйсгэсэн хэлбэр цухуйсан, А Q-ийн зан чанарын арван элементийг угсруулан дурдсан төдийгөөс биш тэдгээр элементүүдийн хоорондох бүтэц буюу адил бус дэс давхаргатай байхыг олтгойлсон хэлбэр гарсан, үзэл санааны түүхэн үүднээс ажиглавал, А Q-ийн зан чанар бол Жуан зи-ийн гүн ухаанаас үүдэлтэй гэсэн үзэл А Q-ийн зан чанар лугаа арай нийцэхгүй хөшүүн нотлол болсон, А Q-ийн зан чанарыг боолч чанарын хэв гэж хураангуйлсан нь хүрээ хэмжээгээр даанч өргөн болсон гэж, хүн төрөлхтний өмнөх түүхт цаг үеийн дэлхийн дэмий хоосон шинжийн бэлгэдэл гэсэн нь уламжлалт нийгэм дэх байх ёс бус үзэгдлийг багтаасан хэт өргөн хураангуйлал болсон гэж Линь Шинзай-ийн өгүүллийн хүрэлцэхгүй талыг дүгнэжээ. “Ахуйч үзлийн аугаа ялалт – багш Лү Шюнь-ий мэндэлсний 100 жилийн ойд < Галзуу хүний өдрийн тэмдэглэл >-ийг суралцсан сул тэмдэглэлээс” (ӨМБИСЭШС.1981.2) гэх өгүүлэл нь, галзуу хүн нээрэн солио өвчтэй, тэр бол феодалын дарлалаас болж, өвчинд нэрвэгдэж, өвчилсний дараа мөн үргэлжлэн тэмцээр



THE CULTURAL WAY

ирсэн байлдагч, феодалын нийгмийг үндсээр нь үгүйсгэсэн баатар байлдагч мөн гэж үзжээ. Чэнь Бэйчэнь-ий “А Q-ийн намтраас дахин суралцъя – Лү Шюнь-ий мэндэлсний 100 жилийн ойг дурсах нь” (Алтан түлхүүр.1982.2) өгүүлэлд, Лү Шюнь-ий даамгай байлдах зориг санаа “хөмсөг зангидан хүчтэн сүртэнд хүйтнээр хандаж, хүзүү бөхийн хар тэргүүтэд үхэр мэт зүтгэх” хэв суртал нь хүмүүст нөлөөлж ирснийг өгүүлжээ. Фу Гө-ийн “А Q-ийн жинхэнэ намтар дахь иргэншил чанарын тухай шүүмжлэл” (Өвөр монголын нийгмийн шинжлэх ухааны сэтгүүл.2004.1) өгүүлэлд, А Q-ийн жинхэнэ намтар гэх өгүүллэгийн гол дүр жич түүний нөхвөр дүрээр дамжуулж, ичимхий мунхаг соёл иргэншлийг хэрхэн шүүмжилсэн тухай бодитой задлан өгүүлжээ.

Бай Хунмэй-ийн “Лү Шюнь-ий бийрийн үзүүр дэх Жао Тай Е-г өгүүлэх нь” (ХБДСЭШС.2005.4) гэх өгүүлэлд, А Q-ийн жинхэнэ намтар дахь Вэй жуан тосгоны соёл бол Жао Тай Е-ийн соёл мөн, Вэй жуан тосгоны амьдрал дунд, А Q гэдэг дүрийг бүтээсэн нь тэр чигээрээ Жао Тай Е-ийн Вэй жуан тосгоны соёл юм. Жал Тай Е нар бол Вэй жуан тосгоны толгойлогч хүмүүс, Вэй жуан-ий соёлын дэмжигч, цаашилбал үүдэн бүтээгч мөн, овог нэрийг хэт хүндэтгэх бол Жао Тай Е нарын Вэй жуан-ий соёл дундах тун чухал нэгэн зүйл болох юм, гэвч зөвхөн Жао Тай Е нар сая овог нэрэндээ тэнцэж чадна, А Q-ийн Жао овогтон мөн эсэхийг Жао Тай Е мэднэ. А Q-ийн гунигт жүжиг нь түүний ангийн байр суурьт байхаар барахгүй харин түүний соёл ухамсарт буй, хэдийгээр энэхүү гунигт жүжгийн үүдэн бүтээгч нь тэр цаг үеийн ноёрхогч анги боловч, тэр цаг үед харьяалалгүйгээр, эрдэм мэдлэгээр зэвсэглэн, тэргүүний үзэл санаагаар нийгмийн хөгжлийг түлхэн ахиулж, шинэ зууны үеийн гэгээг угтан авах чухалтай гэжээ.

Бүрэнбаярын “Нөхөр улс цочин хэлмэгдсэн хэмээх зохиолын логик сэтгэмжийг товч задлах нь” (ӨМБИСЭШС.1999.4) өгүүлэлд, нөхөр улс цочин хэлмэгдэв, үүнчлэн үргэлжлүүлбэл намт улс нь улс биш болно гэх гажуу онолыг хүрэлцэхүйц нөхцөл зүйлчлэлийн хойнох гишүүнийг үгүйсгэх хэлбэр болон зайлшгүй нөхцөл зүйлчлэлийн өмнөх гишүүнийг үгүйсгэх хэлбэрийг тус тус хэрэглэн гаргаж хуурамч баримтыг нь Гоминданы засгийн газрын албан хаагч болон сурагчдын алагдаж шархадсан хоёр зүйлийн бодитой хэргээр шууд хураангуйлан гаргажээ гэж логик сэтгэмжийг нь задалсан байна. Олуугийн “Лү Шюнь-



THE CULTURAL WAY

ий < Даатгал > гэх зохиолын тухай” (ӨМҮИСЭШС.1980.1) гэх өгүүлэлд, эрэгтэйчүүдээс эмэгтэйчүүд хүртэл үзэл санаа үйл ажиллагаанд нь эртний уламжлалт нийгмийн “гурван хэлхээ таван үүрд”-ийн шаардлагад нийцсэн “ёс” гэдэг юмыг дүүрэн шингээж байдаг. Ерөөлт хүний гаднах дүрийг зураглан дотоод ертөнцийг дэлгэн үзүүлсэн, орчин тойрныг бичихдээ зохиолын баатрынхаа эмгэнэлтэй байдлыг товойлгосон гэж дурдахад, Төмөрбаганын “Ерөөл ба утга зохиолын хэв шинжлэл – Лү Шюнь-ий зохион бүтээх үзэл санааг суралцсан тэмдэглэл” (ӨМБИСЭШС.1979.1) өгүүлэлд, зан чанарын хэв шинжлэл, орчин ахуйн хэв шинжлэл гэх хоёр талаас нь хураангуйлж, хоёр зохиогчийн судалгааны байдал адилавар болсныг харуулж байна. “Лү Шюнь ба түүний < Хээрийн өвс > (ӨМҮИСЭШС.1994.4) гэх Х.Гуа-ийн өгүүлэлд, Хээрийн өвс гэх задгай шүлгийн түүвэр нь байгалийн үзэмжийг дүрсэлсэн, хүний дүрийг бүтээсэн, үлгэрийн санаагаа тойруугаар илтгэсэн онцлогтой гэжээ. Шулууны “Найраглал < Цас >-ны тухай захидлын хариуд” (ӨМҮИСЭШС.1981.2) гэх өгүүлэлд, дурсан санагалзаж байгаа өмнөд орны цасны үзэмж нь үзэсгэлэн сайхан амь насны амьдрах хүч ба цог жавхааг бэлгэдэж, өөрийн сууж байгаа умард орны цасны үзэмжийн хайр сэтгэлийн тэсгим хүйтэн ахуй орчинд тэсвэр хатуужилтай тэмцэх дайчин омог бахдалаар уянгалсан байна. Гэгээний “кино < Тэмээн Шян зы >-ийн тухай туршин өгүүлэх нь” (Өвөр монголын монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1983, тал 218) хэмээх өгүүлэл байдаг.

Хан сун лин-ий “< Гэр > хэмээх зохиол дахь Жюэ Шинь-ий дүрийг өгүүлэх нь” (ХБДСЭШС.2006.3) гэх шүүмжид, Жюэ Шинь бол Гао овогтын феодалч гэрийн ахмад болон гэрээсээ урвагч залуучуудын хоорондох нэгэн байр суурь өвөрмөц, зан чанар будлиантай дүр мөн. Жюэ Шинь бол феодалын гэр угсааны дүрэм ба феодалын эртний уламжлалын хорыг амсагч билээ. Түүний зан чанарын гол онцлог нь гэвэл: сайн санаатай бөгөөд үнэнч, дорой зөөлөн бөгөөд аялдан дагагч, далайж ирвэл бөхийж хүлээх, алба хашиж аргалж өнгөрөх зэрэг болно. Энэ бол нэгэн өөрийн оюуны зовууриа гүйцэд таних гунигт жүжгийн нийтлэг дүр мөн. Жюэ Шинь-ий гунигт эмгэнэлтэй байгаа нь түүний аюулт түүхийн хувь заяанд бий. Жюэ Шинь-ий зан чанарын гунигт төгсгөл нь гэнэт буй болсон биш, харин тухайн нийгмийн түүхийн зайлшгүй үр дүн болно. Ба Жинь-ий өчиг доорх Жюэ Шинь-ий зан чанар



THE CULTURAL WAY

нь А Q-ийн зан чанартай адил, нэгэнт түүний тус биеийн утга агуулгаас давж, нэг зүйлийн хүн төрөлхтний түгээмэл чанартай гунигт жүжиг болсон байна гэж үзжээ. УХДСЭШС-д Оюунцэцэгийн “Соёл сэтгэлгээний талаар А Q-ийн зориг санааны эх сурвалжийг судлах нь” (2006.2), “Лү Шюнь-ий улс иргэний чанарын шүүмжлэлд зөв хандах тухай” (2007.3) зэрэг тусгайлсан өгүүлэл байна.

Чин Лун, Саруулын “Ба Жинь-ий найруулах ажлын үзэл санааны тухай” (ХБДСЭШС.2007.2) гэх шүүмжид, Ба Жинь бол ажилдаа хариуцлагатай нарийн хянамгай найруулагч болно, тэр тухайн үед хэдийгээр Соёл амьдрал хэвлэлийн хорооны ерөнхий найруулагч байсан боловч эх бичиг элсэх, эх бичиг хянахаас гадна бас харгуулах, дармаллалын газар гүйх мэтийн бодитой ажлыг ч хийдэг. Ба жинь харгуулах янзыг үзэхээс гадна ном бичгийг чимэглэн дэвтэрлэх төлөвлөгөө, нэмэлт зураг болон хэвийг жагсаан байрлуулах хэлбэр хүртэл бүгдийг хамаардаг. Зохиогчийн ажлыг хүндэтгэх үзэл санааг эн тэргүүн, шинэ зохиогчийг илрүүлэн гаргах, дараа нь зохиогчийн зохиол бүтээлийг нандигнан хайрлах, хамгийн сүүлд нь зохиогчийг хүндэтгэх зэрэг талаас нь задалж, цаг ямагт боддог үзэл санаа ба нэн олон ядуу зүдүү уншигчийг унших номтой байлгахын төлөө хүч хөлсөө урсган зүрхний цусаа шавхсан билээ хэмээн үнэлжээ. Ли Чуаньшэнь-ий “Соньхон зүйрлэл сувдын хэлхээ - Гуо Моруо-ийн Анар хэмээх найрууллыг уншаад” (Хун галуу.1985.9) гэх шүүмжид, Гуо Моруо-ийн анарыг зүйрлэсэн зүйрлэл нь шинэ соргог, ойр дотно, эгэлхэн жирийн, гүнзгий цаана байхын төдий биш, харин хайр сэтгэл, одлоо амилуулан нисгэж, шүлгийн бялхам сайхан дүрслэх сэтгэлгээтэй гэжээ. Г.Шаравжамцын орчуулсан Е Лү-ийн “Хүмүүст анхилмал тулган хүртээж эрмэлзэл төрүүлдэг шүлэг – Ай Чин-ий гурван шүлгийг харьцуулан задлах нь” (Хун галуу.1985.12) гэх шүүмжид, Ай Чин шүлгээрээ хүмүүсийн оюун санааг дуудан сэрээж, хүмүүсийн дотоод сэтгэлийн ертөнцийн баялаг шинжийг тодруулан, хүмүүсийг оюуны тэмтрүүлээрээ энгийн хүнд танигдаж ойлгогдоогүй тэдгээр хүрээнд орж чадахаар болгож, амьдрал ба төрсний утга агуулгыг таниулан тухайн хүмүүсийн ухамсрыг гэгээрүүлж байна гэдгийг шүлгийг нь уншигч хэн бүхэн гүн мэдэрч болох юм. Үүний хамт тэрээр мөн шүлгээрээ өрөөсгөл явцуу хар эгэл ойлгогдохуунтай тэмцэл явуулж, хүмүүсийн үзэл сэтгэлгээнд хүмүүжил олгон, оюун санааны ертөнцөд нь боловсрол



THE CULTURAL WAY

хүртээхийг зорьсон хэмээжээ. Мөн Г.Шаравжамцын орчуулсан Ван Юаньже-ийн “Баялаг сайхан дүрслэн бодолт гайхамшигт зүйрлэл – Зү Зычин-ий Лянхуат нуурын сарны туяаг уншаад” (Г.Шаравжамцын шүлэг зохиолын эмхэтгэл.1985) гэх шүүмж бий. Отгонбаярын “Шяо Шуань-ий зургаан удаа ханиаснаас ярих нь” (Ордосын сонин.1984.11) гэх шүүмжид, эхлэлийн нэг зэрэг ханиад нь бүрхэг харанхуй дундад улс эрүүл бус байдалд оршиж байна гэснийг дам байдлаар илрүүлж, хоёр дахь удаагийн ханиад нь үлгэр үйл явдлын хөгжлийг ахиулснаар үл барам, Лао Шуань-ий хувьсгалчдын цусаар найрагдсан эм худалдан авч эмнэхийг зэмлээгүй эргүү мунхаг ажиллагаа бас шүүмжлэл болно. Гурав дахь ханиалга нь үлгэр үйл явдлын нөхвөр, дөрөв дэх ханиалга нь цус нялагдсан мантуу бол ид шидтэй эм биш, үлгэр үйл явдлын нөхвөр байдлыг үзүүлж, Шяо Шуань-ий тав дахь ханиасан нь Кан авга, Лао Шуань-ий хувь заяаг магтан сайшааж, Шя Сань Е, Тай хувьсгалчийг илчлэн заалдаж, 25 лан мөнгө олсон үе билээ. Зургаа дахь удаа ханиасан нь жижиг цайны мухлагт омогшилтой болж, Шяо Шуань-ий амь тэмцэн ханиасан нь зочид Шя Юй-ийн тухай зөв бус, үгүйсгэх яриа хэлэлцээнд оролцохыг хориглов гэжээ. Дээрх өгүүлүүд нь тусгай зохиол бүтээлээр тусгайлан судалгаа хийж, судалгаа нь нягт байхын зэрэгцээ судалгааны байдал арга нь улам нарийн болсон байна.

(2) Харьцуулсан судалгаа

Даяарчлалын орчинд харьцуулсан утга зохиолын уг санаа нь даруй ярилцлага ба ойлголцол болно⁶. Соёлын нэвчил нь түүхээс аваад харилцан шинжтэй байдаг. Тэр нь ихэнхдээ хос чиглэлийн хөгжлийн улбаатай. Иймээс дан ганц талын нөлөө ба хүлээн авах хийгээд нөлөөлөгдөх харьцаа гэж оршихгүй⁷. Цэнгэлтийн “А Q ба Дон кихот-ийг харьцуулан өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1992.3) өгүүлэлд, А Q ба Дон кихот бол феодалын нийгмийн дүрүүд юм. Хамгийн чухал нийтлэг онцлог бол “төсөөлөн бодохоор ялгах арга” болно. Өвөрмөц шинж нь А Q ба Дон кихот нь тус тусын зохиогчийн үзэл сэтгэлгээтэй шууд холбоотой, А Q хэзээд хүмүүсийн өрөвдөлтийг олж чадахгүй байхад, Дон кихот үргэлж бусдын өрөвдөлтийг олж байдаг өвөрмөц шинжтэй

⁶ 杨联芬著：《晚清至五四：中国文学现代性的发生》，北京大学出版社，2003年，第212页。

⁷ 王宁：《全球化，文化研究和中西比较文学研究》，《中国比较文学》，2001年第2期。



THE CULTURAL WAY

гэж ижил ба өвөрмөц шинж гэх талаас нь шинжилсэн байна. Хамгийн сүүлд төсөөлөн бодохоор ялгах аргын дотоод тогтолцоог гурван талаас хураангуйлан, А Q ба Дон кихот-ийн “их төгсгөл”-өөр өөр өөрийн үндэстэн угсаатнаа дуудан сэхээрүүлж, хүн төрөлхтний урагшлалт дэвшилт зүг хөтөлсөн нь баларшгүй гавьяа зүтгэл мөн гэж санаачилсан байна. Дээрх өгүүлэл нь гадаадын сонгодог бүтээлийн дүр ба хятад зохиолын баатрын дүрийг харьцуулж, адил төсөөтэй онцлогийг илрүүлэхэд анхаарсан байна.

Баярын “< Зам >-ыг Лү Шюнь-ий өгүүллэгтэй харьцуулах нь” (Алтан түлхүүр.1987.3) гэх өгүүлэлд, зохиолын баатрыг дүрслэн бичихдээ Лү Шюнь хүний бүх онцлог бүхий зүйлийг атгаж, хялбар байдлаар зурагладаг, орчин тойрныг дүрслэхдээ нийгмийн бодит ахуй болон зохиолын баатрын сэтгэлгээтэй нь нягт уялдуулж, нэг зүйлийн гүн далд санаа ахуйг бүрэлдүүлэн утга сэдвийн илрүүлэлтдээ гүнзгий нөлөө үзүүлдэг хэмээн үзжээ. Ялгуусанбаатарын “< Хашхираан > ба < Эргэлзээ >-ний үзэл санааг өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1990.4) гэх өгүүлэл нь хагас феодал, хагас колони нийгмийг задалж шүүмжилсэн, цагагчин гахай жилийн хувьсгалд толь болгож түүхэн сургамжийг дүгнэсэн гэж хоёр талаас тэдгээрийн үзэл санааг нягтлан, феодалыг түлхэн унагаах шаардлагатай тариачин жич дарлагдаж байгаа ардыг сэхээрүүлэх үүргийг хариуцахыг дурдсан байна. Бай Шань-ий “< Сэтгэлийн хань > хийгээд < Дагина > хоёр шүлгийн түүврийн зарим бодгаль шинжийг харьцуулах нь” (ӨМҮИСЭШС.2006.3) гэх өгүүлэлд, Сайчунгаагийн “Сэтгэлийн хань” хийгээд Гуо Моруо-ийн “Дагина” шүлгийн түүврийн зарим адил бус онцлогийг харьцуулан, үүнд хоёр шүлгийн түүвэр дэх эх оронч үзлийг тус тус Гуо Моруо-ийн хэв маяг ба Сайчунгаагийн хэв маягийг илрүүлж, байгаль ахуй ба хүнийг шүтэлцүүлж шүлэглэсэн арга хэлбэрийн талаараа ч шүлэгчдийн адил бус ертөнцийн үзэл, урлагийн үзэл зорилтыг нь илрүүлсэн байна. Билгүүний “Өнгө булаалдан дэлгэрсэн үндэстний улаан цэцэг – Хө Жинжы-ийн < Хүч мэдэн дуулсаар > хийгээд Н.Сайнцогтын < Баярын дуулал > гэдэг хоёр шүлгийн тухай харьцуулал” (Алтан түлхүүр.1985.2) өгүүлэлд, хоёр шүлгийн бичигдсэн цаг, гарчиг, утга сэдэв, хэв маяг ба хэлбэр, цаашилбал хэсэг бусаг агуулга нь хүртэл тун адилавартай байна гэж үзээд шүлгүүд нь улс төрийн уянгын шүлэг бөгөөд хэлбэрийн талаар шаталсан хэлбэрээр бичигдсэн, агуулгыг нь “нэг, хоёр, гурав, дөрөв, тав” гэх

ISSN: 2791-1446 ~ 14 ~



THE CULTURAL WAY

мэтээр жижиг гарчигт хуваагдсан байжээ. Н.Сайнцогтын шүлэг болон Хө Жинжы-ийн шүлэг үндэстэнчилсэн ба олон түмэнчилсэн талаар тун ялгаатай байхаар барахгүй Н.Сайнцогт энэ талаар илүү давуу бөгөөд амжилттай байжээ. Хувь хүний талаасаа ч мэдэгдэхүйц ялгаатай байж хэмээн үзжээ. Т.Эрдэнэбаганын “Мао Зөдун-ий шүлэг дуулал жич Гуо Моруо-ийн харьцааны тухай” (УХДСЭШС.2013.2) хэмээх өгүүлэлд, Мао Зөдун-ий шүлэг дуулал нь арга билгийн хоёр амьсгал эсрэгцэн нэгдэх мөртөө тэмцэлдэж, эсрэг дээшээ дэвшдэг идэр сайхан хэв маягтай гэж үзэхийн хамт Мао Зөдун болон Гуо Моруо-ийн шүлэг зохиолын харьцаа бол хувьсгалын нөхөрлөлийн “нийлэх-шүүмжлэх-нийлэх” харьцаа мөн гэж үзсэн байна. Ван Фан-ий “Лү Шюнь хийгээд Юй Дафу-ийн зохиол бүтээл дэх гунигт үзлийн тухай” (Бортохой дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.2009.1) гэх шүүмжид, Лү Шюнь хийгээд Юй Дафу-ийн гунигт үзлийн буй болсон үндэс шалтгааныг илрүүлсэн байна. Үүндээс гадна, Хэбэбалжуурын “Удипис ван ба Аянгат бороо дахь гунигт хувь заяаг харьцуулах нь” (УХДСЭШС.2009.3) хэмээх өгүүлэл бий. Дээрх хэдэн өгүүлэл нь гадаад ба хятадын, хятад ба монголын алдартай шүлгийн түүвэр эсвэл хятадын хоёр зохиолын адил, адил бус талыг хооронд нь харьцуулж, өвөрмөц онцлогийг нь илрүүлэхээр хичээсэн байна.

3. Урлагийн судалгаа

(1) Эмэгтэйчүүдийн уран зохиолын чиглэл судалгаа

Эмэгтэйчүүдийн уран зохиол бол эмэгтэйчүүд голлосон зохиол бүтээл жич түүнтэй тохирсон утга зохиолын шүүмжийг заана. Ойрын хэдэн жил эмэгтэйчүүдийн уран зохиолын чиглэл судалгаа хятад монгол туужсын судалгаа ихэд гүнзгийрч, бодитой зохиол бүтээл дэх эмэгтэйчүүдийн дүр төрх, шинжид задлалт хийж, эмэгтэй шинж чанарын үзэлд сүвэгчлэл хийжээ. Б.Мэргэний “Лү Шюнь-ий зохиолын эмэгтэйчүүдийн дүрийн тухай” (ӨМБИСЭШС.1998.1) гэх өгүүлэлд, Ерөөл дэх Шян Линь бэргэн, Ураг салсан дахь Ай Гү, Харуусалт хагацал дахь Зы Жюнь зэрэг эртний уламжлалыг эсэргүүцсэн нь дундад улсын ойрх үеийн хувьсгал өөд хөгжих илэрхийллийн явц дахь бүхийл онцлог шинжийг нь илрүүлжээ.



THE CULTURAL WAY

Юань Чөн-ий “< Аянгат бороо > дахь эмэгтэйчүүдийн дүрийн шийдвэрлэлт” (Дундад улсын монгол судлал.2007.1) гэх өгүүлэлд, бүх жүжгийн амин сүнс болсон Фань И-ийн дүр нь “өөр би” задрах загвараар илэрч, хатуу чийрэг, сайн сайхан нь “нэгдүгээр өөрийн би”, зөөлөн буурай, муу муухай нь “хоёрдугаар өөрийн би”-ээр илэрчээ. Эмэгтэйчүүдийн дүрийн шийдвэрлэлт нь утга сэдвийн гүн бүтэц – хүн төрөлхтний хувь заяаны мөнхийн төөрөгдөл ба оршихуйн түгшүүрийн гүнзгий цөм хэсэгт нэвтрэн орсноос “үгээр илэрхийлэмгүй” урлаг, үзэл санааны гүнд хүрч чадав гэж өвөрмөц өнцгөөс Фань И-ийн дүрийг задлан шинжилжээ.

Ху Шяоянь-ий “Лао Шө-ийн туужис бүтээлээс түүний эмэгтэйчүүдийн тухай үзлийг сүвэгчлэх нь” (ӨМБИСЭШС.2005.4) гэх өгүүлэлд, эмэгтэй шинж чанар болон эмэгтэйчүүдийн асуудал бол Лао Шө-ийн туужсын агуулгын чухал хэсэг, мөн соёл шүүмжлэлийнхэн нэг бүлэг болж бүрэлдэв. Лао Шө-ийн бүтээл дэхь эмэгтэй шинж чанарын үзэл нь эцгийн эрхт уламжлалт ёс жаягийн бүтэц, эцгийн эрхт үзэл ухамсрын үлдэгдэл хийгээд эмэгтэйчүүдийн чөлөөлөлт дэх ухамсарт бодлогошрол зэрэг гурван талаас нь сүвэгчлэв. Эмэгтэйчүүдийн уран зохиолын чиглэл судалгаа нь дундад улсын орчин үеийн утга зохиолын орчуулгын судалгаанд шинэ уур амьсгалыг оруулсан байна.

(2) Урлаг гоо зүйн судалгаа

Оюунцэцэгийн “< А Q-ийн жинхэнэ намтар > болон < Зам >-ын урлагийн онцлогийг харьцуулах нь” (ЗУМУТМДСЭШС.2004.2) гэх өгүүлэлд, хоёр тууж нь үйл явдал, зохиомж, илэрхийлэх арга хэлбэр, өгүүлбэрийн бүтэц, дүрслэн бичих арга зэрэг талаар адил төстэй мөртөө тус тусын үндэстний өвөрмөц онцлогийг илэрхийлсэн гэж үзэв. “А Q-ийн зэрэг дэсийн үзлийн тухай шинжлэх нь” (ӨМҮИСЭШС.2006.3) гэх өгүүлэлд, Лү Шюнь-ий “А Q-ийн жинхэнэ намтар”-ыг бичсэн зорилгыг үндэслэн, А Q-ийн зэрэг дэсийн үзлийг шинжилж, түүний “төсөөлөн бодохоор ялгах арга”-д задлалт хийхээр дамжуулж, феодалын зэрэг дэсийн үзлийн хор нөлөөг илчилжээ. “Хятад монгол А Q маягийн дүрээс утга зохиолын нийтлэг дүр бүтээх ур дүйг шинжлэх нь” (Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан.2008.5)-д, хятад монгол утга зохиол дахь А Q маягийн дүрийн харьцуулан шинжлэхээр дамжуулж, утга зохиолын нийтлэг дүр бүтээхэд гүн ухааны агуулахуун, түүхийн аястай байх, ISSN: 2791-1446 ~ 16 ~



THE CULTURAL WAY

магтаж муулах нотолж үгүйсгэх нь тохиромжтой байх, будлиант зан чанар зориг санааг нь зураглах, “хүний дүр нь нэгдүгээр”-ийг баримтлах зэрэг ур дүйг шинжлэн сүвэгчилсэн байна. “А Q-ийн дүрээс Лү Шюнь-ий улс ардын чанарыг өөрчлөх үзэл санааг шинжлэх нь” (ӨМҮИСЭШС.1993.2) гэх өгүүлэлд, А Q-ийн төсөөлөн бодохоор ялгах арга, феодалын уламжлалт үзэл санаа, зан сурталтай, юу ч хийдэггүй тэнүүлчдийн заль мэх, боолчлох зан чанартай, хувьсгал хийх шаардлагатай гэх хэдэн талаас нь хураангуйлжээ. “А Q маягийн дүрээс феодалын зэрэг дэсийн дүрмийн хор хөнөөлийг үзэх нь” (ЗУМУТМДСЭШС.1990.4) гэх өгүүлэлд, Лү Шюнь А Q-ийн ядуу зүдүү амьдрал ахуй болхи оюун санааны байдлыг дүрслэн бичиж, феодалын зэрэг дэсийн дүрмийн хор уршгийг хүчтэй илчилж, төсөөлөн бодохоор ялгах аргыг задалж, А Q бол феодалын зэрэг дэсийн дүрмийн хүнд ноцтой хордлогод үхэн үхтлээ ухамсаргүй, феодалын үзэл санаа оршиж байгаа газар бүрт А Q-ийн үзэл буй болох бөгөөд оршдог. Энэ бол “А Q-ийн жинхэнэ намтар”-ын бидэнд үлдээсэн гүн гүнзгий үзэл санаа мөн гэж үзжээ. “А Q-ийн нийтлэг дүрийн тухай туршин өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.199.4) ба “А Q-ийн далдлах ба мэхлэх тухай товч ярих нь” (Улаанхадын сурган хүмүүжлийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1997.2) гэх өгүүлэл нь голдуу А Q-ийн нийтлэг дүр бол хөлсний тариачин буюу хоцронгуй тариачны нийтлэг дүр төдий биш харин улс ардын эмзэг чанарын нийтлэг дүр юм. А Q-ийн зан чанарын хамгийн товойм онцлог нь төсөөлөн бодохоор ялгах аргыг зааж гарган, А Q-ийн Жао Тай Е-д цохигдсоны дараа олон жил баярлаж явсан, хуурамч харийн чөтгөрт цохигдсон үе дэх үхээнц дорой байдал, дурлалын гуниг дээрх илрэл, шүүх танхимд илрүүлсэн аймхай дүр зэрэг талаар түүний боолч чанарт задлал хийжээ. А Q-ийн хоцронгуй, ухамсаргүйг төвлөрүүлэн дүрсэлж, А Q-ийн үзэл санаа зан чанарт туйлбартай шүүмжлэл ба үгүйсгэл хийжээ. А Q-ийн зөвхөн төсөөлөн бодохоор ялгах аргын мануул биш, “А Q-ийн жинхэнэ намтар”-ын амилалын хүч нь хөлсний тариачин А Q яг А Q маягаар тэлчлэн амьдарч, уншигчдын сэтгэлийг хөдөлгөдөг нь мөн үүнд буй⁸. Дээрх өгүүллүүд нь А Q-ийн үзэл санааны системийг задалж, түүний үзэл санаанд тогтсон хэв загвар гаргахаар хичээсэн нь үнэн билээ.

⁸ (日) 丸尾常喜著: 《耻辱与恢复-呐喊与野草》, 北京大学出版社, 2009年, 第63页。



THE CULTURAL WAY

Лү Шюнь-ий эдүгээч ухамсарт хүн чанарын бүхийл эргэцүүлэл, хувь хүний бусдач ертөнц дундах элэр балар оршихуйн хатуу туршлага, уйтгарт маягийн горь тасралын гунигт үзэл санаа ч буй⁹. Оюунцэцэгийн “Лү Шюнь-ий өгүүллэгийн гунигт жүжгийн гоо сайхны тухай” (ӨМҮИСЭШС.2000.3) гэх өгүүлэлд, Лү Шюнь-ий өгүүллэгийн гунигт жүжгийн голч үзлээ баруун европын “баатарлаг гунигт жүжиг”-ийн хэлбэрийг үүдгэж, дундад улсын орчин үеийн эгэл жирийн гунигт жүжгийг үүдгэсэн, баруун европын “хувь заяаны гунигт жүжиг” ба “зан чанарын гунигт жүжиг”-ийн хязгаарлалыг давж, дундад улсын орчин үеийн гунигт жүжгийг үүдгэсэн, даруй өр өвдлийн гоо сайхан, гуниг хорслын гоо сайхан, зоригжууллын гоо сайхан, хүсэл эрмэлзлийн гоо сайхан зэрэг талаас гүнзгийрүүлэн задалсан байна. Ч.Жаргал “Лү Шюнь-ий өгүүллэгийн урлагийн өвөрмөц шинж” (ӨМҮИСЭШС.1983.2) гэх өгүүлэлд, дээд хэмжээний үзэл санаат чанар болон төгөлдөр сайхан урлагийн хэлбэр органик нэгдсэн онцлог даруй бодит ахуй болон түүхийг уялдуулан дундад улсын нийгмийн хэв шинжит орчин дахь бүх төрлийн хүмүүсийн хэв шинжит уран дүрийг бүтээсэн, “нүд зурах арга”-аар зохиолын баатрын онцлогийг илрүүлсэн, илрүүлсэн нийгмийн амьдрал, үзэл санааны агуулга нь тодорхой, өргөн дэлгэр, гүн гүнзгий байдаг, хошин инээдмийн болон гуниг нулимсыг нэг хүний бие дээр нэгтгэж, зохиолын баатраа хошин жүжгийн ба гунигт жүжгийн өнгө будагтай болгож байдаг хэмээн үзжээ. Баатарын “Лү Шюнь-ий зарим зохиолын урлагийн сонирхомж” (ӨМҮИСЭШС.1994.4) гэх өгүүлэлд, “Нэг бяцхан явдал” нь нүдний харц хурц гярхай, нээн уудалсан нь гүн, зангилааны газар бийр багсаар өтгөрүүлсэн, орчин тойрны дүрслэлд гүн санаа агуулагдаж байдаг. “Эм” нь дүрслэг сэтгэхүйг хэрэглэсэн, дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг зурагласан онцлогтой. “Зуун увдист цэцэрлэгээс гурван амтат бичгийн бүрх хүртэл”-д гүн зузаан сэтгэлгээтэй, уран санаа ханхалмал, уран дүр ил тодорхой зэрэг онцлогуудыг хураангуйлжээ. “Лү Шюнь-ий гоц зохиолын онцлогийг өгүүлэх нь” (МХУЗ.1999.1) гэх өгүүлэлд, ялгам тод хэв шинжит чанар ба ил тод дүрст чанартай, зохиомж авцалдангуй, логик чанар нягт, ёж хошин бөгөөд ёгт, хэл хэллэг нь хурц сонгодог, дүрслэл оновчтой зэрэг онцлогууд ба Лү Шюнь-ий хожуу үеийн гоц зохиолд агуулсан 21 дүгээр

⁹ 刘志荣著：《潜在写作 1949-1976》，上海复旦大学出版社，2007年，第147页。



THE CULTURAL WAY

зууны дундадын соёлын бүтээн байгуулалтын элбэг баялаг чанар хийгээд гүн гүнзгий эд баялаг нь туйлын үнэ цэнэтэй байдаг хэмээн хураангуйлсан байна.

Ялгуусанбаатарын “Хэв шинжит дүр А Q-ийн нийгмийн ач холбогдлыг өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1995.1) гэх өгүүлэлд, А Q-ийн дүрээр дамжиж, тухайн нийгэм ба феодалын ноёрхлын ял гэм жич иргэдийн оюун санаан дахь хүнд ноцтой байдал, цагаагчин гахай жилийн хувьсгалын ялагдсан шалтгаан, тариачныг аварч чөлөөлөх тулгам асуудал зэргийг тусгаж гаргасан зэрэг ач холбогдлыг өгүүлэв. О.Хангайн “Рүнъ Ту ба түүний хойчис – орчин үеийн туужсын тариачны дүрийн тухай өгүүлэх нь” (ӨМБИСЭШС.1987.5) гэх өгүүлэлд, анхны арван жилд Лү Шюнь-ээр төлөөлүүлсэн зохиолч Рүнъ Ту-ийн дүрийг амжилттай бүтээж, хоёрдугаар арван жилд Мао Дүнъ зэрэг зохиолчид ахмад тариачны дүрийг бүтээхдээ анхны арван жилийн тариачны дүр бүтээх уламжлалыг залгамжилж шинэ тариачны дүрийг амжилттай бүтээсэн боловч, эдгээр тариачны дүр нь амьдлаг бус байсан бол гуравдугаар арван жилд нэлээд амжилттай дүр болсон жич Линь Шинзай системийн онолыг хэрэгжүүлэн А Q-ийн зан чанарыг адил бусын сэтгэлгээний өндөрлөг жич өдий төдий зан чанарын онцлог бүхий органик цогцоор үзсэний улмаас түүнд ерөнхийлсөн задлалт хийж, А Q-ийн зан чанарын элементийн хоорондох харьцааг эрэлхийлэв. Баганын “Лү Шюнь-ий хэдэн өгүүллэг дэх дүрийн тухай” (ЗУМУТМДСЭШС.2004.2) гэх өгүүлэлд, Лү Шюнь-ий “Зуун увдист цэцэрлэгээс гурван амтат бичгийн бүрх хүртэл”, “Ерөөл” зэрэг өгүүллэгийн зохиолд дүр бүтээхдээ эндээс тэнд хүрэх хүний амьдралын загварыг зураглаж, хэв шинжит дүрийг бүтээсэн, Ху Шяоянь-ий “Лү Шюнь-ий өгүүллэг дэх уран дүрийн онцлогийг шинжлэх нь” (ӨМҮИСЭШС.2000.4) гэх өгүүлэлд, Лү Шюнь-ий өгүүллэг дэх уран дүр нь бодит сэрлийн шинж, өвөрмөц онцгой шинж, хураангуй шинжтэй гэжээ. Сарангэрэлийн “Мөнгөний хорхой ба Эм дэх нүдний зураглал” (ӨМҮИСЭШС.1995.2) гэх шүүмжид, ахуй байдлыг харуулсан зураглал, зохиолын баатрын зан чанарыг харуулсан, зохиолын баатрын сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлсэн зураглал гэх мэтээр задалсан байна. Фу Гө-ийн “Лү Шюнь-ий өгүүллэгийн зохиол дахь хошигнох урлаг” (ХБДСЭШС.2000) гэх шүүмжид, хошигнох нь битүү утгатай үгээр хүнийг дайран шоглохыг хэлнэ. Энэ нь утга зохиолын зохион бүтээлт



THE CULTURAL WAY

дундах нэг зүйлийн үргэлж хэрэглэдэг арга болсны хувьд, амьдрал дундах назгай, хоцронгуй, ялзармал, тэрслүү зүйлсийг илчлэн ташуурдаж, зэмлэн буруушаан, үгүйсгэн эсэргүүцэх зорилгодоо хүрдэг. Хошигнол бол Лү Шюнь-ий зохиол бүтээлийн нэг товойсон онцлог болохоор барахгүй мөн түүний түнэр харанхуй нийгмийн байгуулал, феодалын соёлыг илчлэн дайрах жич нигүүлсэнгүй дүр эсгэж, чигчээр авирлагчдын хуурмаг багийг хуу татах багаж болох юм. “Үймээн” дэх эрдэм мэдлэг ихтэй Жао Чилуэ, Гао абугайн хөмсөгний сорви, нэрийн гарал хийгээд түүхийн мэдлэг зэрэг, “А Q-ийн жинхэнэ намтар” дахь Жао овогтны дэнгийн тос, А Q-ийн хөлсний зоос, хямд үнэтэй хуучин юм зэрэг талаас задлан, Лү Шюнь тухайн нийгэм дэх ноёрхогч ангийн бузар жигшмээр дүрийг дүрслэн зураглахдаа бараг л “бор бичиглэл”-ийн аргыг хэрэглэж, ид шидтэй хошигнох авьяасаа бүрэн гүйцэд тод харуулсан хэмээн дүгнэжээ.

Лян Хөүрун-ий “Авчирмал үзлийн гол онолын тухай” (Алтан үндэс.1990.4) гэх шүүмжид, түгжмэл үзэл, хөргөмөл үзэл, авчирмал үзэл хийгээд “хүргэж өгсөн”, “авч ирэх”-ийн ялгаа зөрөөг задалсан бол, Хүрэлдөшийн “Кун И Жи болон архи” (Алтан үндэс.1997.3) гэх өгүүлэлд, Кун И Жи-ийн амьдралд архи чухам ямар шинжийн үйлчлэгч болж өгснийг үзвэл түүний нэрэлхүү сэтгэл, бичгийн хүний нугарамтгай хөвсгөр занг харуулж, түүнийг гунигт төгсгөл зүг дөхүүлэх соронзон хүчдэл болж, тухайн үеийн илүүдмэл хүний хэв шинжит дүр юм. Архи нь мухардлын зам дахь харамсал гэмшлийн гашуун архи, даруй сүйг нь улалзуулж, сүнснийг нь завхруулах хор архи мөн гэжээ. Аргамжийн “Эх нутаг” дахь “би”-ийн цочин гайхшралыг задлах нь” (Алтан үндэс.2002.3) гэх өгүүлэлд, зохиолын баатрын бие махбодын хэв чанарын доройтлоос оюун ухаан ёс суртахууны хэв чанарт илчлэх тийш гүнзгийрсэн, зохиолын баатрын хэв чанарын доройтлоос нийгмийн хэв чанарын доройтлыг илчлэх тийш гүнзгийрсэн, “би”-ийн цочин гайхшралыг нь тус өгүүллэгийн утга санааны илчлэл мөртөө гүнзгийрэл болж хэмээв. Бас Лю Шухэнь-ий “Эм” гэх хичээлийн самбарлалын төсвийн тухай туршин өгүүлэх нь” (Улаанхадын сурган хүмүүжлийн дээд сургуулийн эрдэм шинжилгээний сэтгүүл.1997.2), Одонгийн “Кун И Жи-ийн урлагийн товойсон онцлог” (Алтан үндэс.1996.10), Одонмөчирийн “Лү Шюнь-ий өгүүлэл дэх хөрөг дүрийн дүрслэл ба утга санааны харьцааг өгүүлэх нь” (Алтан үндэс.2001.4), Н.Зоригтын “Лү Шюнь-ий өгүүлэгийн тухай товч



THE CULTURAL WAY

өгүүлэх нь” (Бугатын оч.1983.10) зэрэг хичээл хүмүүжлийн задлалтын маягаар бичигдсэн богино шүүмж бий. Үүнээс гадна, Т.Буянбатын “А Q болон шалиг өвгөний зан чанарын тухай” (Ойрадын судлал, До.Айдайн тууж.1990.12), “Лү Шюнь-ий утга урлагийн шүүмжийн зориг санааг суралцъя” (ХБДСЭШС.1995.3), “Лү Шюнь-ээс Чүй Юань-ий тухай өгүүлсэн нь” (Жиримийн уран зохиол.1978.3), Ү Шюлань-ий “Лү Шюнь-ий дүр бүтээх аргын тухай товч өгүүлэх нь” (Өвөр монголын монгол хэл бичгийн тусгай мэргэжлийн сургуулийн эрдэм шинжилгээний өгүүлэл түүвэр.1983, тал 147) гэх өгүүлэл бий.

Ялгуусанбаатарын “< Шөнө дунд > дахь хүмүүсийн дүрийн тухай өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1991.3) гэх өгүүлэлд, 30-аад оны шарагчиний дүр, тэрслүү үндэстний хөрөнгөтөн ба тэдний жороо нохой, ажилчны хулгайн газрын эзэд, сэхээтэн ба эмэгтэйчүүд зэрэг нийт 90 гаруй хүмүүсийн дүрийг тусгайлан задалж, хувь тусын онцлогийг хайсан байна. “Аянгат борооны урлагийн тухай өгүүлэх нь” (МХУЗ.1993.5) гэх өгүүлэлд, хүмүүсийн дүрийг товойтол бүтээсэн, хурц ширүүн зөрчил мөргөлдөөнийг урлагаар төвлөрүүлж, дээд хэмжээгээр хураангуйлсан зэрэг урлагийн амжилтыг шинжилжээ. “Туниг уйтгартай хэрэгцээнээс гарсан хүн – Юй Дафу-ийн зохиол бүтээлийн өвөрмөц онцлог шинжээс өгүүлэх нь” (ӨМБИСЭШС.1994.3) гэх Хангайн өгүүлэлд, Юй Дафу-ийн зохиол бүтээлд эрин цагийн голлох хөг аяс харагдсангүй, мөрөөдөгч үзлийн зохион бүтээх аргыг хэрэгжүүлсэн жич түүний зохиол дахь “Хэрэгцээнээс гарсан хүн” бол тэр чигээрээ хоёр талаас бүр үзэл санааны түшиггүй хөсөрдсөн дүр болно. “5.4”-ний хөдөлгөөний өрнөлтөөр сэхээрсэн жижиг хөрөнгөтөн ангийн сэхээтэн болно. Нийгэмд орхигдон хаягдсан ба тэрхүү нийгмээс айн салах гэж идэвхгүй эсэргүүцсэн хоёр тал бүхий дүр болно. Тэд Опломоячууд биш, А Q биш, тэдний мөн биеэ бүрэлгэн сүйтгэдэг нь нийгмийн дарлалаас болсон оюуны сондгой хувирал жич эсэргүүцлийн хэлбэр болно. Тэд өөрийгөө сүйтгэж өнгө архинд автдаг, биеэ хорлох буюу нийгмийг зүхэн хараах, нийгмээс зайлсхийхийн төлөө эх байгалийн элгэнд байлцахыг хүсэх нь тэд нарын гуравдугаар хэлбэрийн эсэргүүцэл болох зэрэг онцлогтой гэж үзжээ. Дээрх өгүүллүүд нь дүр судалгаанаас урлагийн судалгаа руу гүнзгийрч, орчин үеийн зохиол бүтээлийн урлагийн гайхамшгийг үзүүлж, нийгмийн ач холбогдол нөлөө үйлдэл зэргийг шинжилжээ.



THE CULTURAL WAY

Наран “Шэнь Цунвэнь-ий туужис дахь хүслэнчилсэн ертөнц” (ЗУМУТМДСЭШС.2000.2) гэх өгүүлэлд, Шэнь Цунвэнь-ий туужис нь Шансы газрын амьдралд суурилж, хүн чанарын охь шүлт, зан чанарын сайн сайхан, ёс суртахууны цэгц ариуныг харуулсан хүслэнчилсэн шинжтэй байдаг. Хүслэнт сайхан дүр дүрслэл, хүүрнэл, уянгаллынх нь цаана бодит ахуйн бузар булайд арга барагдсан гуниг горьдлого ба дургүйцэл, бодлогошрол тунгаалт нэвчсэн байдаг. Энэ бол ард түмний эртний борчууд, сайн сайхан төрөлх хүн чанарын сайхнаар одоо үеийн нийгэм дэх бузар булайг жигшин эсэргүүцсэн явдал юм. Түүний энэхүү эсэргүүцэл нь зохих идэвхтэй байдаг боловч бас бодит ахуйгаас зайдсан, зөрчил тэмцлээс зайлсан назгай байдал болно хэмээн үзжээ.

Ван Гүйрун-ий “< Янь ань-ий утга урлагийн ярилцах хурал дээр хэлсэн үг >-ийн зориг санаа хийгээд монгол уран зохиол” (ӨМБИСЭШС.2010.1) гэх өгүүлэл нь, Янь ань-ий утга урлагийн ярилцах хурал дээр хэлсэн үг нийлэгдсэнээс нааш монгол уран зохиолд үзүүлсэн гол үзэл санааг “Хэлсэн үг”-ийн Өвөр монгол орон дахь уламжлагдал ба нөлөө жич утга урлагийн үндсэн үйлчлэгдэхүүн гэх хоёр талаас нь шинжилсэн байна. Мөнхбуянгийн “< Хэлсэн үг > -ийг дахин судалж, амьдралд гүнзгийрэх ба утга урлагийн шүүмжийг цэцэглүүлэн хөгжүүлэх өрнөлт гаргаасай” (Алтан түлхүүр.1982.3), Хас-Уулын “< Хэлсэн үг > -ийн туяа тал нутгийг гийгүүлнэм” (Цэлгэр тал.1992.2), Жан Юйбинь-ий “< Хэлсэн үг > -ийн зориг санааг нарийн хянамгай гялалзуулан хэрэгжүүлж манай аймгийн нийгэм журамт утга урлагийн үйлсийг цэцэглүүлэн хөгжүүлэхийн төлөө тэмцсүгэй” (Цэлгэр тал.1992.2), Юнь Фужюнь-ий “Мао Зөдун-ий утга урлагийн үзэл санааг баримтлан хөгжүүлсүгэй” (Цэлгэр тал.1992.2), Өлзий-Очирын “Утга урлаг хийгээд улс төрийн харьцааны тухай өгүүлэх нь” (Цэлгэр тал.1992.2), П.Рашнямын “Хувьсгалт утга урлагийн гэгээн цамхаг” (Цэлгэр тал.1992.2), Лигдэнгийн “Амьдрал-Мао тэргүүлэгчийн < Хэлсэн үг >-ийн 50 жилийн ойд” (Цэлгэр тал.1992.2), Цогт-Оргилын “< Янь ань-ий утга урлагийн ярилцах хурал дээр хэлсэн үг >-ийг дахин судлах нь” (Цэлгэр тал.1995.1-2) мөн “< Хэлсэн үг > -ийн 50 жилийн ойг дурсах нь” (Цэлгэр тал.1995.2) гэх Мао Зөдун-ий “Хэлсэн үг”-ийг судалсан хамаарал бүхий шүүмжүүд бий.



THE CULTURAL WAY

Үүнээс гадна, дундад улсын орчин үеийн утга зохиолын хамаа бүхий өгүүлэлд, Сайннямбуугийн “Орчин үеийн хятад утга зохиол дахь янаг амрагийн сэдэвт бүтээлийн хөгжил” (ЗУМУТМДСЭШС.1998.3) гэх өгүүлэлд, “5.4”-ний үеэс улс байгуулагдах хүртэлх хугацаанд хятад утга зохиолын янаг амрагийн сэдэвт бүтээлийн байдлыг түүний буй болсон ба өрнөн бадарсан, 20-оод оны сүүлчээс 30-аад оны сүүлч хүртэлх хугацаанд буй болсон хэдэн зүйлийн хэлбэр, 40-өөд оны үеэс дэхь Гоминданы эзэмшлийн орон дахь зохиол бүтээлийн байдал, чөлөөлөгдсөн орон дахь янаг амрагийн сэдэвт бүтээлийн шинэ хөгжил зэргийг тоймлон өгүүлсэн суурин дээр тэдгээрийн хөгжлийн онцлог ба нийгэм соёлын үнэ цэнэ, гоо таалахуйн онцлог жич үндэстний ба цаг үеийн байдлыг илтгэн үзүүлэхийг зорив. Орчин үеийн хятад утга зохиолын шүүмжийн тухай өгүүлэх нь” (ЗУМУТМДСЭШС.1999.1) гэх өгүүлэлд, орчин үеийн хятад утга зохиолын шүүмжийг түүний үүсгэсэн ахуй байдал тухайлбал, эртний системийн задралаас эхлэн эснэл хөгжил ба онцлог байдал, зүүний холбооны 10 жилийн хугацаанд түүхэн дэвшилт, японыг эсэргүүцэх дайны эхнээс улс байгуулагдах хүртэлх 10 жил дэх хувиралтыг хураангуйлан тоочиж, эцэст нь бүхийл орчин үе дэх хятад утга зохиолын шүүмжийн алдаа оноог хураангуйлжээ. О.Хангайн “Хориод оны үеийн хятад уран зохиолын зохион бүтээх аргын улиран хөгжсөн байдал” (ӨМБИСЭШС.1985.1) гэх өгүүлэлд, “5.4”-ний хөдөлгөөний урьд хожид, утга зохиолын хувьсгалыг өрнүүлж байх үед голдуу шүүмжлэлт ахуйч үзлийн зохион бүтээх аргыг санаачлан эрхэмлэж, улсын дотоодын анхдугаар удаагийн их хувьсгал ялагдаж, эв хамт намаас дундад улсын хувьсгалыг удирдах үүргийг хувьдаа үүрэглэснээс идэвхтэй хүсэнгүйч үзэл нь хувьсгалт ахуйч үзэл зүг хөгжих хандлагатай болсон, “Янь ань-ий утга урлагийн ярилцах хурал дээр хэлсэн үг” нийтлэгдсэний дараа томоохон урсгал болон давлагаалах болсон, хувьсгалт утга зохиолын бүлэгтэн-хувьсгалт хүсэнгүйч үзлийн зохиолчид-үндсэндээ маркс лениний үзлийн утга зохиолын онолыг журамлаж, хувьсгалт утга зохиолын хөдөлгөөнийг өрнүүлэхэд чухал үйлдлийг үзүүлсэн гэж Лү Шюнь, Гуо Моруо, Мао Дунь, Жян Гуанцы нарын зохиол бүтээлээр жишээ татан задалсан байна, мөн Жан Дун-ий “Хорьдугаар зууны дундад улсын хувьсгал болон дундад улсын утга зохиолын тухай өгүүлэх нь” (Цэлгэр тал.1997.1) гэх өгүүлэл бий.



Хоёр. Судалгааны бүтээл

Дээрх судалгааны өгүүлэл шүүмжээс гадна, судалгааны бүтээлд дурдууштай нь 1982 оны 4 сард ӨМСХХХ хэвлүүлэн тархаасан Төмөрбаганын найруулсан “Дундад улсын орчин үеийн утга зохиолын түүх” (дээд, доод) нь монгол ангийн сурагчдын хятад хэл дээр бичигдсэн тухайн зохиол бүтээлийг уншин судлахад хэцүү бэрх бодит байдлыг харгалзаж, гол гол зохиол бүтээлүүдийн үлгэрийн үйл явдлыг нэлээд дэлгэрэнгүй танилцуулан, түүний суурин дээр зохиол бүтээлийн үзэл санаач чанар ба урлагч чанар жич орчин үеийн утга зохиолын түүхэн дэх байр суурь, нөлөө тусгал зэргийг тус тус өгүүлж, сурагчдад тодорхой ойлгуулан гүн санагдуулахаар хичээсэн байдаг. “5.4”-ний улсын дотоодын анхдугаар удаагийн хувьсгалт дайны үеийн утга зохиол, улсын дотоодын хоёрдугаар удаагийн хувьсгалт дайны үеийн утга зохиол, японыг эсэргүүцэх дайны өмнөх үеийн утга зохиол (1937-1942), японыг эсэргүүцэх дайны хойнох үе ба улсын дотоодын гуравдугаар удаагийн хувьсгалт дайны үеийн утга зохиол (1942-1949) гэж дөрвөн хэсэгт хувааж, түүхэн гол чиглэлээр шат үе хуваан танилцуулсан байна. Тус бүтээл нь сурагчдын сурах бичиг, гарын авлага болсон байна. 1982 онд Сайн-Эрдэнийн орчуулсан “Дундад улсын утга зохиолчдын үлгэр”-ийг ӨМСХХХ хэвлүүлэн тараав. Үүнд дундад улсын орчин үеийн утга зохиолчдын зарим үлгэрүүдийг сонгон түүвэрлэсэн байна.

1986 оны 4 сард Жинь Жян найруулж, Оюун, Зандан, Мөс орчуулж, ӨМАХХ ЖяАХХ-ны 1983 оны 4 сард анхны хэвлэлийг үндэслэн орчуулж хэвлүүлсэн “Дундад улсын өнөө үеийн шилдэг ёгт үлгэрүүд”-д Лү Шюнь-ий “Цэцэн хүн, тэнэг хүн ба боол хүн”, “Нохойн ноцолт”, “Эртний хот”, “Онолжуулалт”, Гуо Моруо-ийн “Нэгэн хоньчин”, “Заан хийгээд ялаа”, Жан Тянь И-ийн “Гахай”, “Нэгэн сайн могой”, “Их алаг бялзуухай хийгээд гахай”, “Нохойн сургаал”, “Чоно ба батгана”, “Өд”, “Зэрлэг үхэр”, “Кун И Жи-г судлах нь”, “Лао жинь онгоц”, “Самуун төрийн балай эзэн”, Ай Чин-ий “Шувуу зурагч анчин”, “Цэцэг арчлагчийн зүүд”, “Дарцын дуу”, Фөн Шуайфөн нарын ёгт үлгэрийн зохиол бий. Тус бүтээл нь дундад улсын орчин үеийн цөөн хэдэн зохиолчийн зохиол бүтээлийг сонгон түүвэрлэсэн учраас хамарсан хүрээ тийм ч өргөн биш болохоор нийтлэг чанартай бүтээл болж чадаагүй байна.



THE CULTURAL WAY

1983 оны 11 сард Баяннамар, Гуа найруулж, ӨМСХХХ хэвлүүлсэн “Дундад улсын зохиолчдын товч намтар”-т дундад улсын эрт эдүгээгийн нийт 158 зохиолчийн товч намтар, тэдний бичсэн гол гол зохиол бүтээл ба зохиол бүтээлийн урлагийн гол онцлог, дундад улсын орчин үеийн зохиолчдын намтрыг нэлээд нарийн танилцуулсан байна. Гэвч гучин хэдэн жилийн өмнөх бүтээл учраас зарим зохиолчийн намтар нь бүрэн бус нөхвөрлөх хэрэгтэй болсон байна. Чянь Көрүн эрхлэн найруулж, Асар, Ванчин, Лигдэн, Яримпил, Дамуу, Жаргал, Бадам нар орчуулж, 1988 оны 11 сард ӨМСХХХ хэвлүүлсэн “Дундад улсын орчин үеийн утга зохиолын сонгомол” (дээд дэвтэр) нь их дээд сургуулийн сурагчдын “Дундад улсын орчин үеийн утга зохиол” хичээлийн бус цагаар унших хавсралт материал болсон учраас заах сургалт ба эрдэм шинжилгээнд чухал хэрэглээний үнэ цэнэ ба хянан лавлалтын ач холбогдолтой бүтээл болсон байна.

О.Хангайн найруулан зохиож, 1989 оны 8 сард анхны эхийг ӨМСХХХ хэвлэсэн “Орчин үеийн гурван зохиолчийг өгүүлэх нь”-д Лү Шюнь-ий амьдрал тэмцэл ба үзэл санааны эргэлт, “Хашхираан”, “Эргэлт” бол феодалын үзэл санааны хувьсгалын толь мөн, “А Q-ийн жинхэнэ намтар”-ын тухай, Дин Лин-ий амьдрал тэмцэл ба зохиол бүтээлийн тойм, Дин Лин-ий үлгэрийн зохиолын тухай ойрх үеийн судлалын байдал, дахиж дэлгэрсэн гурван боть анхилам цэцэг, “Сан ган мөрөн дээр нарны гэрэл тусав”, Юй Дафу нарын амьдрал тэмцэл ба зохиол бүтээлийн тойм, зохиол бүтээлийн судлал, дагалдуулал зэргээр бүрэлдсэн байна. Мөн О.Хангайн эрхлэн найруулсан “Дундад улсын орчин үеийн уран зохиолын түүх” гэх бүтээлийг өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо 2004 оны 12 сард хэвлүүлэн тархаав. “Засаг хэвлүүлсэн тодорхойлолт”, удиртгал, дээд найрал нийт 17 бүлэг, доод найрал нийт 14 бүлгээс бүрэлджээ. Тус хичээлийн сурах бичиг нь бүх улсын монгол хэлээр хичээллэх их сургуулийн оюутнуудын сурах бичиг болж, монгол хэлээр хэвлэгдсэн хамгийн эрх сүрт, хамгийн ерөнхийлсөн чанартай ном болж, өргөн олон сурагчдын халуун хүрээллийг олсон байна.

Билгүүн найруулж, 1992 оны 10 сард анхны эхийг ӨМСХХХ анх хэвлүүлэн тархаасан “Дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхийн товч”-д удиртгал, 12 бүлэг, төгсгөлийн үг зэргээр бүрэлдүүлэв. Тус



THE CULTURAL WAY

номыг найруулахдаа: эх сурвалж буюу нэгдүгээр материалыг ашигласан бөгөөд эш татахдаа эрт хэвлэгдсэн утга зохиолын түүхийн номд үндэслэж, шүүмжлэн тоочихдоо < Чүнх Чю-ийн өчиглөл >-ий хэрэгжүүлсний дээр холбогдол бүхий олон арвин ном бичиг сонин сэтгүүлийг хянан уншсан, бусдын судалгааны үр бүтээлийг хүндэтгэн, үзэл танилт нэгтэй олонд хүлээн зөвшөөрөгдсөн саналуудыг шууд ашигласан бөгөөд хараахан зөвшөөрөгдөөгүй хувь хүний саналыг түр бичиж оруулсангүй, зааж сургах онцлогт тохируулан дундад улсын орчин үеийн утга зохиолын үндсэн байдал ба үндсэн мэдлэгийг танилцуулахаар гол болгосон зэрэг хэдэн зурвасыг журамласан байна. Тус бүтээл нь нэлээд өндөр түвшнээс уран зохиолын түүхийг хураангуйлан дүгнэсэн дорвитой бүтээл болжээ. Билгүүн найруулж, 1993 оны 5 сард ӨМСХХХ анх хэвлүүлсэн “Дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхийн асуулт хариулт” нь удиртгал, 12 бүлэг, нөхвөр асуулт хариулт гэх хэсгүүдээс бүрэлджээ. Дундад улсын орчин үеийн утга зохиолтой холбогдох бодитой зохиогч ба зохиол бүтээлтэй холбогдох асуудлуудыг хөндсөн байдал бол сурагчдын гарын авлага ном болох нь гарцаагүй. 1997 оны 10 сард Чимэг, Арвинжан найруулж, ӨМАХХ-оос хэвлүүлсэн “Дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхийн тойм” хэмээх бүтээл нь өмнөх үг, 11 бүлгээс бүрэлджээ. Тус ном нь биеэ даан сурч шалгуулах ба насанд хүрэгсдийн сурган хүмүүжил жич дээд зэргийн тусгай мэргэжлийн сургуулийн сурагчдын онцлогт зохицуулан дундад улсын орчин үеийн утга зохиолын үндсэн байдал ба үндсэн мэдлэгийг танилцуулахад гол чиглэл болгон найруулсан бүтээл болно. Дээрх хэвлэгдсэн номуудаар лавлалт болгосон учраас зарим хэсэг агуулга давхардсан тал ч бий.

1998 оны 12 сард Чин Лун, Сэцэнбилэг найруулж, Өвөр монголын их сургуулийн хэвлэлийн хороо хэвлүүлэн тархаасан “Дундад улсын орчин үеийн утга зохиолын шилдгүүдийн дөт тайлал” гэх ном нь голдуу дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхийн далай баялаг агуулгын доторх хамгийн анхны, хамгийн шилдэг, хамгийн гол болох түүхт чанартай чухал зүйлсийг шигшин авч сорчлон найруулсан байна. Оюутнууд сурч эзэмших ба уншигчид ашиглахад хялбар байхыг бодож, агуулгын онцлог шинж, хамаарах цар хүрээг нь үндэслэж, “Хороо бүлгэм сонин сэтгүүлийн шилдгүүд”, “Онол ярилцлага уриа лоозонгийн шилдгүүд”, “Зохиолч ба зохиол бүтээлийн шилдгүүд” хэмээн гурваар



THE CULTURAL WAY

бүдүүвчлэн нарийн ангилж, нийт 75 зүйлийн хамгийн шилдгүүдийг багтаан түүвэрлэсэн байна. Тус ном нь их дээд сургуулийн оюутнууд, захидлаар сурах ангийн ба бие даан сурч шалгуулах оюутнууд жич нийгэм дээрх утга зохиолын түүхэнд дур сонирхолтой уншигчдын дундад улсын орчин үеийн утга зохиолын түүхийн элбэг баялаг мэдээг ойлгон танихад дээд хэмжээний хураангуй чанартай чухал материал болохоор барахгүй, эрдэм шинжилгээний ажилд ч гарын авлага болох материал юм.

Наран, Сайннямбуу эрхлэн найруулж, Ялгуусанбаатар, Оюунцэцэг, Бао Хайшянь нар дэд эрхлэн найруулсан, 2001 оны 8 сард анхны эх бэлтгэлийг хийж 2001 оны 9 сард анх ӨМСХХХ-оос хэвлүүлсэн бүх улсын тусгай мэргэжлийн дээд сургуулийн заах сургах сурах бичиг болох “Дундад улсын орчин үеийн уран зохиол” нь оршил, дээд найрал (1917-1949), доод найрал (1949-1997), хойнох үг зэргээс бүрэлдэж, бусад заах материалтай харьцуулбал цаг хугацааны хувьд тэлж, улс байгуулагдсаны дараах 48 жилийн дундад улсын өнгөрсөн одоо үеийн уран зохиолын түүхийн хэсгийг багтаан бичсэн байна. Энэ нь хятад уран зохиолын орчин үе гэх нэрийдэл шинэ оролдлогыг мөрдөж найруулсан нь тодорхой. Энэ нь бидний анхны “Дундад улсын орчин үеийн утга зохиол” гэх хуваарилалыг цуцалсан талтай учраас шинэхэн оролдлого болно. Гэвч өмнөх судалгааны бүтээлүүдээс зарим хэсгийг шууд шилжүүлэн хэрэглэсэн хэсгүүд нь харамсалтай зүйл болжээ.

2010 оны 6 сард ӨМШУТМХХ хэвлүүлсэн Оюунцэцэгийн “Лү Шюнь-ий судлал”-д Лү Шюнь-ий судлалын тойм байдал, түүнийг зөв таних тухай, түүний сурган хүмүүжлийн үзэл санаа, түүний өгүүллэг зохиолын тухай, “А Q-ийн жинхэнэ намтар” хийгээд А Q-ийн дүрийн тухай гэх таван бүлэгт хуваажээ. Үүнд, “Хашхираан”, “Эргэлзэл” доторх туужсын зохиолын тухай, онцгойлон “А Q-ийн жинхэнэ намтар” хийгээд А Q-ийн дүрийн тухай голчлон судалсан байна. Зохиогч урьдах хүмүүсийн шинжилгээний үр бүтээлийн суурин дээр, түүхэн бодист үзлийн нөлөөгөөр Лү Шюнь болон түүний зохиол бүтээлийг зөвөөр таних, түүхэн үнэн дүр байдлыг илрүүлэн гаргахаар хичээсэн юм. Энэ нь хэдийгээр тун товч дөт болсон боловч монгол уншигчдын Лү Шюнь ба түүний зохиол бүтээлийг зөвөөр ойлгон эзэмших хийгээд цаашид гүнзгийрүүлэн судлахад хяналт болгох материал юм.



Гурав. Монгол орчуулгын утга зохиолын түүх судалгаа

Орчуулгын утга зохиолыг орчуулгын утга зохиолын онол шүүмжийн судлал, орчуулагчийн судлал, орчуулгын утга зохиолын түүх судалгаа гэж гурав ангилан судалдаг. Орчуулгын утга зохиолын онол шүүмжийн судлалын чимэг нь зохиол тус биеийн онолын системийг бүтээн байгуулах явдал болно. Орчуулгын утга зохиолын түүх судлал бол орчуулгын утга зохиолын гол чиглэлийн ерөнхийлсөн судлал болно¹⁰.

Б.Содном “Монголын утга зохиолын хөгжлийн түүхчилсэн төлөв” (1946) гэх бүтээлдээ анх “орчуулгын утга зохиол” хэмээх ухагдахууныг анх дурдан гаргаж “Ганжуур, “Данжуур”-аар жишээ болгон анхлан шинжилсэн байна. Ц.Дамдинсүрэн, Д.Цэндийн “Монголын уран зохиолын тойм” (19 дүгээр зуун) гэх номын оршилд 19 дүгээр зууны эхэнд хүмүүс орчуулгын утга зохиолыг анхаарч эхэлсэн байна. “Монголын уран зохиолын тойм” (19 дүгээр зуун) гэх номд, хятад утга зохиолын орчуулгыг 19 дүгээр зууны монгол утга зохиолын хөгжлийн явц дахь чухал үзэгдлээр үзсэн нь зохих эрдэм шинжилгээний үнэ цэнэтэй. Ц.Дамдинсүрэнгийн “Монголын уран зохиолын түүх” (1957) гэх номд, < 13-14 дүгээр зууны орчуулгын бүтээл > ба < 15-16 дүгээр зууны орчуулгын бүтээл > гэж хуваан задалж, орчуулгын утга зохиолыг монгол утга зохиолын бүхэл цогц байдалд авч үзэн судалсан нь мөн л эрдэм шинжилгээний өндөр ач холбогдолтой. Ц.Дамдинсүрэн, Д.Цэндийн “Монголын уран зохиолын тойм” (17-18 дугаар зуун) гэх номд, < Энэтхэгийн уран зохиолтой холбогдол бүхий зохиолууд > хийгээд < Төвөдийн уран зохиолтой холбогдол бүхий зохиолууд > гэсэн бүлэгт хуваан тусгайлан өгүүлсэн байна. Ц.Дамдинсүрэнгийн найруулсан “Монголын уран зохиолын тойм” нь 13-19 дүгээр зууны монгол орчуулгын утга зохиолыг тус цаг үеийнх нь чухал агуулга болгон судалж, тэр нь орчуулгын утга зохиолыг улам цаашид бүх талаар уудлан, гүнзгий судлахад суурь тавьж өгсөн байна. Д.Цэрэнсодномын “Монгол уран зохиол” (13-20 дугаар зуун) гэх номд, < 13-14 дүгээр зууны орчуулгын уран зохиол >, < 17-18 дугаар зууны орчуулгын уран зохиол > гэх хоёр бүлгээр орчуулгын бүтээлийг задлан өгүүлжээ. Монгол улсын

¹⁰ 王向远著：《翻译文学导论》，北京师范大学出版社，2004年，第240页。



THE CULTURAL WAY

эрдэмтдийн бичсэн олонх утга зохиолын бүтээл нь энэтхэг төвөдийн утга зохиолын орчуулгаар гол болгож, монгол утга зохиолын бусад үндэстний соёлыг хүлээн авах явц дундах их төлөв хөгжлийн ул мөрийг бүх талаас нь хайсан байдаг.

Мансангийн “Монголын уран зохиолын түүх”-д < 13-15 дугаар зууны орчуулгын зохиол >, < 15-17 дугаар зууны орчуулгын зохиол >, < 17-20 дугаар зууны орчуулгын зохиол > гэх гурван бүлгээр 13-20 дугаар зууны эхний орчуулгын утга зохиолын үндсэн байдлыг товч тодорхой танилцуулсан байна. Таван дээд сургуулийн хамтран найруулсан “Монгол уран зохиолын түүх” гэх номд орчуулгын утга зохиолын дараа хэвлэгдсэн монгол утга зохиолын түүхийг өгүүлснээс биш, цөөн хэдэн бүтээл ба орчуулгын бүтээлээс гадна орчуулгын утга зохиолын тухай өөр системтэй өгүүлсэнгүй. Н.Сайшаалт “Монгол уран зохиолын түүх”-д Билгүүндалайн намтар, Номуундалайн намтар ... зэрэг хэдэн хэсэгт зохиогчийн намтрыг танилцуулах үед орчуулгын бүтээлийг дурдсанаас биш гүнзгий судалсангүй.

Дээрх бүтээлүүдээс ялгагдах “Монгол уран зохиолын хөгжлийн товчоо” нь < Монгол орчуулгын уран зохиолын хөгжлийн төлөв > гэх тусгай бүлгээр 13-20 дугаар зууны эхэн үеийн орчуулгын үйлсийн хөгжлийг өгүүлж, орчуулгын утга зохиолын хөгжлийн шат үеийг үүсэж төлөвшсөн шат (13-16 дугаар зууны сүүл үе), анхны хөгжлийн шат (16 дугаар зууны сүүл үе – 17 дугаар зууны дунд үе), хөгжлийн шат (17 дугаар зууны сүүл үе – 18 дугаар зууны сүүл үе), боловсрон төгөлдөржсөн шат (19-20 дугаар зуун) гэж хуваан, орчуулгын утга зохиолыг монгол утга зохиолын түүхэн дэх чухал үзэгдэл болгон сүвэгчилж, хөгжлийн явц дахь чухал бүтээл ба түүний онцлогуудыг нэлээд системтэй өгүүлж, монгол орчуулгын утга зохиолын хөгжлийн онцлогийг эхний удаа хураангуйлж гаргасан байна.

Б.Сүхийн “Монгол уран зохиолын хөгжлийн түүхийн удиртгал” гэх номд, < Монгол уран зохиолын хөгжил хийгээд харь бусдын уран зохиолын хэлхээ холбоон үзэгдэл > хэмээх бүлэгт орчуулгын утга зохиолын үзэгдлийг хөндсөн боловч, гол нь орчуулгын утга зохиолын монгол утга зохиол дахь нөлөөллийг бичиж, орчуулгын утга зохиол нь монгол утга зохиолын “нүүлгэн авч ирэх ба дуурайх” үзэгдлийг буй болгосон гэж үзжээ. Үүнд орчуулгын утга зохиол ба нүүлгэн авч ирэх



THE CULTURAL WAY

хийгээд дуурайх үзэгдлийг хэрхэн ойлгох асуудал оршиж байна. Рун, Сүх нарын “Монгол үндэстний уран зохиолын түүх” (4 боть)-д анх удаа дундад улсын эртний туужсын зохиолын орчуулга жич монгол орон дахь өргөн нөлөө бүхий түүхэн туужсын холбогдол бүхий асуудлыг судалж, орчуулгын утга зохиолыг системтэй гүнзгий судлахад хяналт болгож байх бодит жишээг хангаж өгчээ. Мансангийн “Монгол уран зохиолын түүх”-д дундад улсын монгол утга зохиолын судлалын хүрээнд анх энэтхэг төвөдийн утга зохиолын орчуулгыг утга зохиолын түүхийн нэгэн бүрэлдэхүүн хэсгээр үзэж, Б.Сүх, Буянтогтох нарын номд энэтхэг төвөдийн утга зохиолын орчуулгад адилхан байр суурийг олгож, онолын талаас түүний хөгжлийн жам ёсыг илэрхийлсэн нь тодорхой. Рун, Сүхийн номд орчуулгын утга зохиолыг монгол утга зохиолын түүхийн дутагдаж болшгүй бүрэлдэхүүн хэсгээр үзэж, чухал зохиол бүтээлд нарийн хянамгай бөгөөд гүнзгий задлалт хийж, монгол утга зохиолын судлалыг шинэ нэгэн өндөрлөгт хүргэсэн байна. Г.И.Михайловын “Орчин үеийн монгол уран зохиолын түүхэн найруулал” ба өвөр монголын их сургуулийн дундад улсын хэл утга зохиолын салбарын найруулсан “Өвөр монголын өөртөө засах орны утга зохиолын түүх”-д орчуулгын утга зохиолын тухай дурдсангүй¹¹. Ренчинкавагийн “Монгол орчуулгын түүхийн хураангуй тойм” 13-20 дугаар зууны орчуулгын утга зохиолыг шат хуваан задалсан байна. М.Баясгалан, Ренчиний “Орчуулгын ухааны суурь”, Жинхуарын “Орчуулга зүй”, С.Хичээлтийн “Орчуулгын ухааны үндсэн онол”, Асралтын найруулсан зохиосон “Хятадыг монголчлох орчуулгын анхны шинжлэл”, Пэрэнлэйн зохиосон “Монгол орчуулгын найрлага”, Чойжонжав, Гончиг, Эрдэнэчулуу, Вансанжав нарын найруулан зохиосон “Хятадыг монголчлох мэдлэг”, Ү Юэ-ийн “Орчуулгын ухаан суурь”, Г.Буянт, Хасгэрэлийн “Албан бичгийн орчуулга”, Тэнгисийн “Хятад монгол орчуулгын сурах бичиг” ... гэх мэт онолын бүтээлүүдэд хэдийгээр орчуулгын тухай ерөнхий мэдлэг, үгсийн орчуулга, өгүүлбэрийн орчуулга, найруулгын орчуулга, утга зохиолын агуулга, хэлбэр, хэв маягийн тухай орчуулах асуудал, орчуулагчийн эзэмших бүрэн боловсрол, орчуулгын онол зарчим арга зам жич орчуулгад оршиж байгаа асуудал ба анхаарах чухал асуудлуудыг хөндсөн ч утга зохиолын орчуулгыг гүнзгийрүүлэн

¹¹ 乌日斯嘎拉：《蒙古族翻译文学史研究述评》，内蒙古师范大学学报，（哲学社会科学版），2003年第4期，第12页。



THE CULTURAL WAY

судлаагүй байна. Ийнхүү дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын тухай “Монгол үндэстний дундад улсын орчин үеийн орчуулгын утга зохиолын түүх судлал” (1947-1976) гэх түүх судалгааны тусгай бүтээл хэвлэгдсэнийг гаргавал, хамаарал бүхий судалгаа тийм ч сайн хийгдээгүй байсаар байна.

Өнөө үеийн орчуулга судлалын хөөцөлдөх байдал нь судалгааны аргын бусдач чанар ба дээд хэмжээний онолын хураангуйлах чанар болно. Шинэ эринээс нааш 40-өөд жилийн судалгааны ерөнхий байдлыг шинжвэл, дээрх судалгааны бүтээлүүд нь зохих эрдэм шинжилгээний ач холбогдолтой байж, хойшдын судалгаанд лавлалт болох юм. Эдгээр судлалын байдал ба гол зүйл нь дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулга биш, харин дундад улсын орчин үеийн утга зохиолын судалгаанд хамрагдана. Жинхэнэ судалгааны өндөр түвшинтэй, хошууч чанартай, системтэй судалгаа дутагдаж байна. Судалгааны өгүүлүүд нь хоёр талын онцлогтой. Эн тэргүүнд, зохиогчийн эгнээ хэтэрхий явцуу, ихэнх нь нэртэй зохиолчийн судалгаа байж, зарим нь үзэл ухамсар зэрэг шалтгаанаас болж үүдний гадаа хашигдсан байна. Дараа нь, судалсан нэртэй зохиогчийн дотор Лү Шюнь, Гуо Морую, Мао Дүн, Ба жинь, Лао Шө, Цао Юй, Жан Тянь И зэрэг зохиолчоос гадна бусад зохиогчийн судалгааны өгүүлэл тун цөөн байна. Ерөнхийд нь ажиглавал, судалгаа нь 70-аад онд эхлэлийн шатандаа орж, 80-аад онд өрнөлийн шатанд орж, 90-ээд оноос нааш бууралтын шатанд орсон хөгжлийн ул мөрийг үзэх болно. Судалгааны өгүүлэл нь зохиогчийн намтар, зохиол бүтээл, урлаг гоо зүйн судалгаа зэрэг талаар өрнөж, өмнөх үетэй харьцуулбал тун олон нийтлэгдэж судалгааны чиглэл өргөжиж, харьцуулан судлах, тусгайлан судлах жич ширхэгчлэн судлах, хураангуйлан судлах ба цөөн хэдэн эмэгтэйчүүдийн уран зохиолын талын судалгаа зэрэг олон цар хүрээнд тэлсэн судалгаа улам гүнзгийрч байна. Хоёр зохиогч буюу хоёр зохиол бүтээлийн харьцуулсан судалгаанд судлаачдын үзэл нь нэн тодорхой илэрч, дараагийн судалгаанд лавлагааны чухал ач холбогдолтой. Хойшдын судалгаанд ганц нэг буюу хэдэн зохиогчийн зохиол бүтээлийн судалгаанд төвлөрч болохгүй, дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын системтэй бүх талын ерөнхийлсөн судалгааг өрнүүлж, орчуулгын утга зохиолын түүх шинжилгээг бүтээн байгуулах нь бидний өмнө тулгарч буй зангилаа асуудал болно.



THE CULTURAL WAY

Ерөнхийд нь ажиглавал, судалгаа нь 70-аад онд эхлэлийн шатандаа орж, 80-аад онд өрнөлийн шатанд орж, 90-ээд оноос нааш бууралтын шатанд орсон хөгжлийн ул мөрийг үзэх болно. Судалгааны өгүүлэл нь зохиогчийн намтар, зохиол бүтээл, урлаг гоо зүйн судалгаа зэрэг талаар өрнөж, өмнөх үетэй харьцуулбал тун олон нийтлэгдэж судалгааны чиглэл өргөжиж, харьцуулан судлах, тусгайлан судлах жич ширхэгчлэн судлах, хураангуйлан судлах ба цөөн хэдэн эмэгтэйчүүдийн уран зохиолын талын судалгаа зэрэг олон цар хүрээнд тэлсэн судалгаа улам гүнзгийрч байна. дундад улсын орчин үеийн утга зохиолын монгол орчуулгын системтэй бүх талын ерөнхийлсөн судалгааг өрнүүлж, орчуулгын утга зохиолын түүх шинжилгээг бүтээн байгуулах нь бидний өмнө тулгарч буй зангилаа асуудал болно.

**АМЬ АХУЙН УХАМСРЫН ИЛРЭЛ**

- БҮРЭНТӨГСҮЙН “ХАН ДЭЛХИЙ” БА ЧИНГИЗ АЙТМАТОВЫН “ЦААЗЫН ТАВЦАН” ЗОХИОЛЫН ЖИШЭЭН ДЭЭР

Аяс *

ХУРААНГУЙ

Бүрэнтөгсийн “Хан дэлхий” ба Чингиз Айтматовын “Цаазын тавцан” гэх хоёр бүтээл хорвоо ертөнцийн амьд бодисын хоорондох харилцан түшиглэлцэх мөртөө бас харилцан өрсөлдөх, хүн ба байгалийн эсэргүүцэл хийгээд нэгдэл, хан дэлхийн түмэн бодисын хоорондох хайр ба хорсол хосолсон зэрэг үзэгдлүүдийг дэлгэхийн хамт, байгаль – хүн – амьтан гурвын уялдал түшилцэл жич тэгш оршихуйг хэрхэн цогцлоох, байгаль орчин ахуйтайгаа хэрхэн зохицох, хэрхэн оршин тогтнох гол сэдвүүдийг товойлгосон учраас тус хоёр бүтээлийг амь ахуйн уран зохиолын айд багтааж, амь ахуйн шүүмжлэлийн талаас хоёр бүтээлийг хооронд нь харьцуулан судалсан юм. Амь ахуйн утга зохиолын шүүмжийн судалгааны хөгжилд өөрийн өчүүхэн хүчээ өргөхийг хүссэн билээ.

Түлхүүр үгс: Бүрэнтөгс, Чингиз Айтматов, амь ахуйн ухамсар, уялдал зохицол, чонын соёл

Амь ахуйн уран зохиол бол улс үндэстний заагийг давсан дэлхийч/глобал/ чанартай үзэгдэл болно. Тэр нь гол төлөв ХХ зууны 80-аад он даруй шинэ эринд илэрсэн элдэв зүйлийн амь ахуйн муу талыг тусгасан, амь ахуйг эвдэгч – хүн төрөлхтнөөс хариуцлага нэхсэн утга санаат уран бүтээлүүдийг заана. “Амь ахуйн уран зохиол гэдэг нь голдуу байгаль хийгээд хүний харьцааг зураглан дүрсэлж сүвэгчлэн тайлбарладаг уран туурвилуудыг зааж байна. Даруй байгаль дэлхийн хүн төрөлхтөн хийгээд жигүүртэн араатанд үзүүлэх нөлөө, хүн төрөлхтний байгаль дэлхий дэх байр суурь, байгаль дэлхийн түг түмэн бодис хийгээд хүн төрөлхтөнд чиглэсэн харьцаа, хүн төрөлхтнөөс байгаль дэлхийдээ

* Харьцуулсан утга зохиол ба дэлхийн утга зохиолын магистрант (ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургууль).



THE CULTURAL WAY

үзүүлж буй бүхий сүйтгэл хохирол жич амьд бодис ба эх байгалийн эе зохицол зэргийг уран найруулгын аргаар дүрслэн илэрхийлэхийг хэлж буй”¹². Үүнд амь ахуйн хариуцлага, амь ахуйн боловсны шүүмжлэл, амь ахуйн хүслэн, амь ахуйн сэрэмжлүүлэл ба амь ахуйн ухамсрыг сэргээх зэрэг нь бүр амь ахуйн уран зохиолын хамгийн товойсон онцлог болох юм. Амь ахуйн уран зохиол нь улс үндэстний заагийг давсан дэлхийч чанартай үзэгдэл болсон учраас амь ахуйн уран зохиол нь үзэгдэл сэтгэлгээ, зохиомж сэтгэхүйн талаар улс үндэстний гэсэн ялгаа зөрөө харагддаг юм.

Баяннуурт нутагтай монгол үндэстний алдарт уран зохиолч Бүрэнтөгсийн “Хан дэлхийн буян” гэх роман нь өөртөө засах орны “5.1 инженеринг/төслийн ажил”-ийн шагнал хүртсэн ба тус роман нь монгол үндэстний амь ахуйн уран зохиолын судалгаанд дутагдаж болшгүй, судлууштай үнэ өртөгтэй/цэнтэй/ уран бүтээл болж чадсан байна. Зөвлөлт Холбоот Улс – Киргизстаны алдарт уран зохиолч Чингиз Айтматовын бүтээл “Цаазын тавцан” нь амь ахуйн ухамсар төгөлдөр илэрсэн уран бүтээл болох учраас олон хэлэнд орчуулагдан, түг түмэн хүмүүсийн амь ахуйн ухамсрыг сэнхрүүлж чаджээ.

Нэг. Хүн – амьтан – байгаль гурвын чандмань харьцаа

(Нэг) Хүн – хүний ертөнцийн хэмээ алдсан нь

“Хүн төрөлхтөн бол хорвоо ертөнцийн хамгийн дээд оюун ухаант, хүч чадалтай, ашиг хүртэгч, эрх мэдэлтэй мөн ч хамгийн эвдэгч чанартай амьтан болсны хувьд байгаль нийгмийн жам ёсыг журамлаж, аливаа амьд бодисын оршихуй болон бүх бөмбөрцгийн оршихуйд хариуцах хариуцлагатай юм”¹³ гэтэл роман “Хан дэлхий” ба “Цаазын тавцан”-д хүн хэмээгдэх нь үнэнхүү ийм үүрэг хариуцлагаа дааж яваа юу? энэ асуултад Бүрэнтөгс ба Айтматов нараас жихүүн сэрүүн байгаль дэлхийгээр хүн чанарын цэвдэгшиж хүйтэрч байгаа байдлыг ёгтлон өгүүлжээ.

“Байгалийн их эвдэгдэл нь хэрэг дээрээ хүн чанарын эвдэгдэл гэсэн үг ... оршин буй дэлхийн бөмбөрцгөө элдвээр эвдэх бол хамгийн

¹² Сүх нар. “Монгол үндэстний амь ахуйн уран зохиолын судлал”, ЛяоҮнХХ 2015, т 36

¹³ Л.Тэмүжин нар. “Уламжлалт байгаль хамгаалах арга ухаан”, ҮнХХ 2007, т 42



THE CULTURAL WAY

том хүн чанарын доройтол мөн”¹⁴ Хан дэлхий романд Диваа шинжлэх ухааны судлалын үр бүтээлтэй аварга малчнаар цоллогдов¹⁵. Диваа бол оодон хар азарган илжигний эзэн, Дарьсоотой гэрэлсэн нь ч зөвхөн Дарьсоогийн эм хүйс л дом эмчилгээ болж байв, тэр бусдын хайр халамжлалыг ухаж ойлгохгүй мөртөө бусдыг энэрч хайрлахгүй, хийж бүхий ажиллагааныхаа хожмын нөлөө тусгал, үр ашгийг гүнзгий сэтгэхгүй, хамгийн наад захын нохой ба чонын мөрийг ялгах ухаангүйгээр үгнийхээ хоточ нохойг амьдаар өвчих харгис мунхаг ажиллагааг үйлдэж, оодон хар азарган илжгээрээ адууны үүлдрийг сайжруулж, толботыг хайрч адуун сүргээ сүйдэх хэмжээнд хүрсэн байна. Дарьсоо горьлол хүсэлтэйгээр энэ дэлхийд төрөөд гурван эр дамжсанаас гуниг бодлогошрол цээж дүүрэн байдлаараа Хатан голын үерийн урсгалд дальдрив.

Түүний охин Цагаанхүүхэн нь арай гэж дурласан залуутайгаа ханилж, цуг ханилж суух буянтай байжээ гэтэл энэхүү буян нь буян буянаараа гэсэн шиг, төрсөн эцгээ буруу таньсан уршгаас болж төрсөн ахтайгаа ханилаад жирэмсэн болчихжээ. Энэ бүхний гол шалтгаан нь даруй хүн юм. Дээрх илэрсэн үр дүнгээс үзэхэд, нийгмийн харьцааны хувиралт, хүний харьцааны будлиан, хүн чанарын доройтол зэрэг аль олон зүйлээс болж хүний удам угсааны доройтол, соёлын зориг санааны гажилт буй болсон байна. Энэ нь мөн ч хүн төрөлхтний том орон гэр болж байгаа байгалийн амь ахуйг талхидаж байхын чухал нэгэн шалтгаан болохыг Бүрэнтөгсөөс тунгаан бодлогоширч сэхүүн шүүмжилж байх юм.

Чингиз Айтматов “Цаазын тавцан”-даа “Эд мөнгөнд шунахайрч, эрх мэдэл ба нэрэлхүү зан нь хүнийг туйлын ихээр зовоодог байлаа ... энэ бол олон түмний үзэл ухамсрын гурван тулгуур мөн, хэзээ хаана ч гэсэн тэд цөм гуйвшгүй хорвоо ертөнцийг тулгуурлаж байдаг ...”¹⁶ гэсэн үзэл саналаа илтгэсэн байна. XX зууны Фуколтын дурдсан “хүн төрөлхтөн үхчихлээ” гэсэн нь хүний бодгаль бие нэгмөсөн хязгаарын байранд оршиж, туйлын тогтонгуй бус байдалтайгаас болоод нийгмийн биеч оршихуй болж чадахгүй байгааг харуулжээ. Хүний боловсон чанар нь

¹⁴ Ц.Баатар. “Хан дэлхийн буян хэмээх романы шүүмжийн гурвалжин бүтэц”, Цэцэгт тал, ҮнХХ, т 630-639

¹⁵ “Хан дэлхий”, ӨМХБ 2015, т 368

¹⁶ Чингиз Айтматов. “Цаазын тавцан”, ӨМСХХ 2018, т 316-361



THE CULTURAL WAY

нэгэнт энэхүү боловсондоо боомлигдсон тул хүн ба хүн бусын хязгаар, би хийгээд би бусын зааг нь хүний бодгаль бие нэг бүрийн оршиж болохуйц орон зай болжээ¹⁷. Ямар ч хүн гэсэн бүр адил нэг насны үйл ажиллагаа ба хувь заяагаа эзэмдэн захирч чадахгүй, Хан дэлхий дэх арьсаа өвчүүлэн нохой, бөгсөө хайруулсан азарга ба удмаа самууруулсан хүн төрөлхтөн зэрэг нь бүр л хуучин хууль ёс цоцролд учраад аврах аргагүй болсон байдлыг үзүүлсэн байна.

(Хоёр) Амьтан – хүний ухаантай амьтад

Түмэн бодис сүнстэй байх ба хүн амьтан эрх тэгш байх ойлгогдохуунд суурилж, ертөнцийн түмэн бодист хүмүүнлэг чанар оршиж, амьтлаг хүмүүнчлэгдсэн байна. Бүрэнтөгсийн Хан дэлхий ба Чингиз Айтматовын Цаазын тавцангийн хамтын онцлог гэвэл бүр чоно гэх амьтан эхлэлээс төгсгөл хүртэл илэрч, хүнтэй чацуу дээд зэргийн оюун ухааны шимийг нь авч явсан байлаа.

Хан дэлхий ба Цаазын тавцан гэх хоёр романы хамтын урлагийн гол онцлог гэвэл, амьтадын дүр нь бүр дүрс хувирмал бэлгэдлийн аргаар бичигдсэн дүр болох юм. Үүнд хээрийн зэрлэг амьтад эсвэл гэрийн тэжээвэр ч гэсэнгүй, цөм хүмүүнчлэгдсэн дүрээр илэрсэн байдаг. Бүрэнтөгс ба Айтматовын зохион бичлэгийн хамтын гол онцлог гэвэл адгуус амьтны дүрээр ямар нэгэн үзэл ухамсрыг ёгтлон илрүүлэхийг зорьсон байна.

Хүмүүнчлэгдсэн амьтад – хүмүүнчлэлийн аргаар амьтан ургамалд бэлгэдэл шинж нэмэрлэж, тэр нь хүний сэтгэхүйн чадварыг тусгах мөртөө хүн чанарын доройтолд ил тод харьцууллын эзэн бие хангаж чадсан билээ. “Төрөлх чадавхид шаардлагын материалтай боловч оногдохуунаа байм хол газраас хайн эрхэлж чадахгүй, төрөлх чадавхи сэтгэж чаддаггүй”¹⁸. “Биологийн хүрээнд амьтны зөн мэдрэхүйн чадавхи олон талаар хүнээс илүү гарах нь шинжлэх ухаантнууд гэрчилсэн юм. Хүний оюунч шинжийн гэрэл гялбаанд зөн мэдрэхүй дарагдсан магад”¹⁹. Энэ бүхнийг жишээн дээр харуулбал: Толбот, азарга болохоор байдсаа салгахын төрөлх чадавхи байдаг. Чонын удамтай жирхэг харин дэлттэй

¹⁷ Ц.Баатар. “Хан дэлхийн буян хийгээд хязгаарын ухамсар”, Алтан түлхүүр 1999, т 13-17

¹⁸ 亨利·伯格森: 《创造进化论》, 湖南人民出版社, 1989年5月, 第118页

¹⁹ Билүүндадай. “Шинэ эриний монгол туужсын хүний дүрийн амь насны ухамсар”, ӨМАХХ, т 71



THE CULTURAL WAY

уулзмагцаа учраа олсон байдаг. Гэтэл эцэг нэгтэй хоёр залуугийн сэрэл чадавхи төөрөгдсөн байлаа. Хонзбаяр ба Цагаанхүүхэн хоёр хүүхэдтэй болж хурим хийхээр бэлтгэнэ. Тэр ч байтугай, эцэг нь болсон Доржид ч зөн мэдрэхүй буусангүй. Амьдран оршихын тэмүүлэлд хүн төрөлхтөн нь зарим талаар амьтанд хүрэхгүй тал олон байх аж. Хамгийн эцсийн их үерийн гайнаас Шонхор Толбот хоёр амьтай хоцорсон байхад Дарьсоо харин үерт дайрагдсан билээ.

Тэр амьдран оршихын тул Шонхор, Тольт, Толбот шиг шуурхайлсангүй, тэрнээс зөвхөн оршихын төдий оршиж, ахуйн үрэгдэл болжээ. Тэр хувь ерөөлийг мэдэвч өөрчлөхөө бодсонгүй. Диваатай цуг амьдарсан нь түүний гунигт хувь заяаг түргэтгэжээ. Диваа мөн ч зарим төрөлх чадавхаа алдсан “ондоошсон хүн” гэж хэлж болох юм. Тэр энэрэхүй хайр сэтгэл гэж байхгүй мөртөө бодол санал нь ч хүнээс өөр, үнэн худал сайн муу гэж ялгахгүй, “бодол дундуур” хүнээс гажсан хүн болох бүлгээ. Амьтанд байх амьдран оршихын тул бусдыг сүйтгэдэг чанар Диваа, Дорж, соёо Шар, Хонзбаярын бие дээр бүр адил бус хэмжээгээр илрэлээ олжээ. Хүн гэдэг амьтан ухамсарта болохоор бусдад авч ирэх гай барцад нь амьтнаас хол илүү юм. Ухамсрын илрэлийн ил тод нь хүн ба амьтны заагийг тодруулж чаддаг. Мөн ч хүнд ухамсар гэх зүйл байдаг болохоор чөлөөт сонголт хийж чадна. Хэрэв энэхүү ухамсрын заагийг гүнээ тунгаах бодохгүй юм бол ондоошсон хүн хүмүүнчлэгдсэн амьтдад хүрэхгүй болно. Багцлан хураангуйлбал, Хан тэнгэрийн буян ба Цаазын тавцанд хүний нийгмийн самуурлыг илчлэхээр дамжин зүй ёсны эвдрэлээс байгалийн гамшиг үүсэж, хүн төрөлхтний удам тасрах шахсан зохих цаг үеийн будлиант хандлагыг дэлгэрүүлсэн байна.

(Гурав) Байгаль – хан дэлхийн түмэн бодисын ивээгч

Ер нь дэлхийн бөмбөрцөг ганцхан хоёр хөлт хүний төлөө эргэдэг юм биш, хан орчлонгийн нар сарны илч туяаг араатан амьтад, үүнд тэжээвэр ч, зэрлэг ч, нэн цаашлаад зэлүүд бүрд уул сарьдагуудыг ч бүр ялгаагүйгээр ивээн гийгүүлдэг. Энэ нь даруй байгалийн төрөлх эрх. Гэтэл үүний ард харин хөндөж болшгүй байгалиар төвлүүлэх эш ёсны үзэл санаа нуугдаж байдаг. Хүн – амьтан – байгаль гурвын “чандмань харьцаа”-ны эрх тэгшийг сурталчлах нь өрнө дахины амь ахуйн эш ёсны



THE CULTURAL WAY

шинэ урсгал болох мөртөө үндэстний амь ахуйн язгуур ухамсар, сэтгэхүйн танилтын баримтлал зэргийг мөрдөн олж болох юм.

Хан дэлхий хийгээд Цаазын тавцан хоёр бүтээлийг задлан шинжилбэл, Бүрэнтөгс ба Чингиз Айтматов хамтын зорилго санаачилга нь илхэн тодорч гарах юм, даруй самуурал дайсагналцлыг илчлэх, шүүмжлэх, сэхээрүүлэхээр дамжуулж хүн төрөлхтөн хийгээд байгаль орчны уялдаа, нөхөрлөл, түшилцэл жич эрх тэгш оршихуйн тухай ухамсрыг уриалжээ.

Хоёр. Хан дэлхий ба Цаазын тавцан дахь чонын соёлын зохион бүтээлтийн шинжлэл

Ойрын хэдэн жилд чонын сэдэвт уран зохионы ном туурвил олон бичигджээ. Жишээлбэл АНУ-ын зохиолч Жек Лондоны бүтээл “Зэрлэг байгалийн дуудлага”, монгол улсын зохиолч Бавуугийн Лхагвасүрэнгийн “Сэрүүн орчлонгийн сиймхий”, Жян Рун-ий “Чоно” тотем зэрэг бүтээлүүд буй. Чонын соёлын зохион бүтээлт нь ч улс үндэстний хил хязгаарыг давж, олны халамшил зохион туурвих цэг сэдэв болж хувирсан байна. Өрнө дахины домог ярианд чоно бол хүнл бишрэн хүндэтгэгддэг амьтан болох бөгөөд монгол үндэстэн ч гэсэн “тэнгэрийн нохой” хэмээн цээрлэн хэлдэг. Хан дэлхи Цаазын тавцан гэх хоёр бүтээлд чоно нь хүн чанар төгөлдөр, нэн цаашид хүнээс илүү хүн чанартай гэж хэлж болох юм.

Чонын соёлын зохион бүтээлтийн чухал нэгэн үүрэг хариуцлага бол чоныг бичиж, түүний дүрийг бүтээх явдал болно. Хан дэлхий ба Цаазын тавцан гэх хоёр бүтээлийг харьцуулсан судалгааны суурийг бүрэлдүүлж чадсан хамгийн тэргүүний шалтгаан бол даруй тус хоёр бүтээл нь бүр чоноор романыхаа гол баатраа болгосон, чонын үлгэрийг тэмдэглэхийн дагуу бас хүний амьдралын жам хуулийг тусгасан байна.

Монгол уран зохиолд ихэнхдээ чононд сүрлэг дээл онцлог шинж хайрладаг. Уламжлалт домог ярианд чоно нь монголчуудын өвөг дээдсийн хувиар шүтэгдэн илэрнэ. Жишээ нь, Монголын Нууц Товчоонд “Чингис хааны язгуур дээр тэнгэрээс заяат төрсөн Бөртэ чоно ажгуу” гэж тэмдэглэжээ. Алунгоо эхийн домогт түүний жирэмсэлсэн үзэгдлийг “Шөнөд бүрийн цэгээн шар хүн гэрийн өрх тотгын гэгээгээр орж, хэвлийг минь илж гэгээ нь хэвлийд минь шингэх бүлгээ. Гарахдаа нар



THE CULTURAL WAY

сарны хилээр шар нохой мэт шижвэлзэж гарах бүлгээ. Талам яахан өгүүлэн та, түүгээр ухаас тэмдэг нь тэнгэрийн хөвгүүн ..." тус хоёр домогт тэнгэрийн нохой, чоно, өвөг дээдэс гурав нь хамтдаа холбогдож байна. Үүнээс монголчуудын өвөг дээдсийн мөрдлөгөд тэнгэр, чоно, дээдэс зэргээр системээ болгосон өвөг дээдсийн ухамсар бүрэлдэн тогтворжсон нь мэдэгдэж байна. Бас нэгэн тодорхойлох зүйл гэвэл, тотем шүтлэгийн ухамсар нь нэг үндэстний үзэл ухамсрыг маш урт хугацаагаар жолоодох нөлөөтэй байдаг. Иймээс эртний монголчууд чоныг дээдэс лугаа холбогдуулан үзэх ухамсар нь домог үлгэр зэргээр дамжиж одоо үеийн уран зохиолд уламжлагдан иржээ.

Хан тэнгэрийн буян романд азарган чоно дэлтийн дүрээр чонын уян нарийн хайр сэтгэл ба элбэг баялаг хүн чанартай байхыг тусгасан юм. Жишээлбэл романд дэлт чоно нь шархадсан эм чоно шонхороос нэг мөч ч салалгүй үүрч тэтгэсэн, бас Диваагаар арьсаа өвчүүлсэн зэргийг өр өвтгөм үүрч туулсан үйл, эдгээр үйл явдал нь Диваагийн адгуус амьтанд ч хол хүрэхгүй байхыг дамаар өгүүлэх мөртөө дэлт чоныг "хүн" гэдэгт байваас зохих энэрэлт сэтгэлгээ, элэгсэг сэтгэл ба хүн чанартай болгон зураглаж чадсан ажээ.

Чингиз Айтматовын Цаазын тавцан роман дахь чонын дүрийг мөн л нүдэнд үзэгдэж, гарт баригдам маш бодит зураглаж чаджээ. Чонын дүрийг зурагласнаас нь түүний хүн төрөлхтөн ба байгаль гэх энэхүү амь ахуйн ухааны асуудал ба хүмүүнч чанар, хүмүүнлэг үзэл хийгээд нийгмийн гүн ухааны асуудлын тухай үзэл ба хэлбэрийг уусгаж, махчин амьтны мөн чанараас гадна, чоно ч бас үр зулзагаа хайрлах, хайрт ижилдээ шударга, гэр бүлдээ хоргодох зэрэг зарим тохиолдолд хүнээс ч илүү хайр сэтгэл бялхам үзэгдэл илэрнэ. Гэтэл тус романы зарим дүр, тухайлбал хулгайн анчин хор панзлагч Кдалов, Базарбай мэтийн хүмүүс чононоос нэн аймшигтай мөртөө бохир бүдүүлэг зүрх сэтгэлтэй. Иймээс хамгийн сүүлд нь Бостоны чонотой үхэж сэхэхийн тэмцэлдээний дунд хамтдаа эцэслэжээ. Ч.Айтматов үйл явдлыг ёгтлон өгүүлжээ. Чононд хүн чанар олгохоор дамжуулж хүн төрөлхтний зүй ёсны бус үйл ажиллагааг шүүмжилж, хүн ба амьтан, хүн ба байгалийн хооронд зөрчил мөргөлдөөнөөс болж харамсам төгсгөлтэй болсон байна.



Гурав. Бөмбөрцөг гэгч нэг айл хэмээх ухамсар

Монголчууд аль эрт Чингис хааны үеэс эхэлж байгаль орчноо хайрлан хамгаалах, эх байгальтайгаа зүй зохистой, харилцан аж төрөн амьдарсаар ирсэн түүхтэй билээ. Тэгэх мөртөө монголчуудын амь ахуйн тухай ухамсар ба ур сэтгэхүй нь дэлхийд дуурсгалтай байдаг, эх байгалиа мөнхөлж, шүтэн хайрлаж, хамгаалах талаар нийт олны мэдрэмжийн жишээг ард түмэн үлдээж авсан юм. Жишээлбэл эрт дээр үеэс нүүдэллэсээр ирсэн монголчууд овоо хөтөл буюу булаг рашаан зэрэг газарт гэр байшин барихгүй, ан агнахгүй, мод огтлохгүй, чулууг нь хөндөхгүй, өвс үндсийг ч ухахгүй ёс заншилтай бөгөөд эдгээрийг бузартуулж болохгүй гэсэн цээр ёсон байдаг. Ялангуяа эдгээрийг бүр тахин шүтэж байжээ. Эдгээр үйл ажиллагаанууд нь амь ахуйн хамгаалалтын нөлөөтэй бөгөөд эртний монголчуудын боловсон амь ахуйн ухамсар ба бөмбөрцөг даяар амь нэгтэй гэсэн дэвшсэн үзэл ухамсруудыг мөрдөн олж болох юм.

МНТ нь 13 дугаар зуун ба түүнээс өмнөх монголын нийгэм соёлын нэвтэрхий толь болсон аварга бүтээл болохын хувьд эртний монголчуудын байгаль амь ахуйн соёл боловсныг бусдач мөртөө үнэн мөнөөр нь тэмдэглэж үлдээснийг үнэлүүштэй юм. Эртний монголчуудын байгаль амь ахуйн соёл боловсны цөм агуулагдахуун – тэнгэр, газар, мод ургамал, амьтан жигүүртэн ба тотемын шүтлэг зэрэг нь МНТ маш нарийн тэмдэглэгджээ.

⑤[明]罗日裘著：《咸宾录》[M]，卷二《东夷志·琉球》. 万历刻本，p. 37。

①[明]罗日裘著：《咸宾录》[M]，卷七《南夷志》. 万历刻本，p. 38。

②[明]罗日裘著：《咸宾录》[M]，卷六《南夷志》. 万历刻本，p. 18。

③[明]罗日裘著：《咸宾录》[M]，卷四《西夷志》. 万历刻本，p. 18。

④[明]罗日裘著：《咸宾录》[M]，卷七《南夷志》. 万历刻本，p. 38。



泽被遐荒绝域，彰显王化威远，“南中以下，俱中国郡县卫司之地，与化外诸蛮不同，……今皆奉我正朔，或供命输纳、或听调奉贡，王化远矣。……以彰我国家辟地之广，而守牧其地者毋徒尸位素餐可矣。”¹⁰²是书还体现作者指陈时弊，扬善惩恶的态度与立场，对于“朝臣结舌，边疆敛手”致使倭奴得志的局面而痛批；对“安而忘危，玩以生寇，亭障废弛，舳舻不修”¹⁰³导致倭患荼毒猖獗的现状而担忧；对于“助纣为虐”，导夷作逆的亡命之徒主张严惩不贷，不容姑息。如卷六《南夷志》：“海滨诸国，两粤亡命多逃归之，大都能导夷人作逆，如日本事，可概见也。第三佛齐，势孱弱尔。陈祖义、施进卿俱系叛贼，谓宜先诛祖义，旋及施进卿，即不然槛进卿抵京，以杜后来可也。曷为官之同罪异罚，郑和失之矣”，¹⁰⁴作者对亡命之徒作逆的行为深恶痛绝，对为官者的过失行为直陈弊病，毫不隐晦，其善恶有别，立场分明。

（四）开化民主、经世致用

作者陈述一个民族或国家后，在其文后有“论”，作者“寓论于史”。“论赞寓文”是古代记史传统，罗日褰深受影响，因袭之。明代私人著述中“论赞”之气更为普遍，作者通过对史实（人、事、物）的记述，往往在文后谈感受、抒己见、发议论，流露其真实想法，抑褒抑贬、抑赞抑损、抑惩抑奖、表达思想、陈明立场，具有民主开化之风气。同时，作者本着“经世致用”原则，博览群书，广征博引，将明朝四周民族和国家录入是作之中，让学者藉此丰富知识、开阔眼界，了解世界。且作者重视当下，关切本朝（明朝），经济现世，关注本朝治“夷”方略，大赞本朝圣武神威、德泽寰宇、仁施天下、“四夷”皆贡。

结语

罗日褰所作《咸宾录》广征博引，史料丰富，价值颇大。对于考证明代万历前历代王朝与边疆民族和周边通贡国家往来的史实有参考、补证价值，但一些未经作者鉴别的史料要慎重利用。是书体现的“多元一体”、“和平友好”、“扬善抑恶”、“民主开化”、“经世致用”的思想具有积极、进步作用。

⑤[明]罗日褰著：《咸宾录·凡例》[M]. 万历刻本，p. 2-3。

⑥[明]罗日褰著：《咸宾录》[M]，卷二《东夷志·日本》. 万历刻本，p. 32。

⑦[明]罗日褰著：《咸宾录》[M]，卷六《南夷志·三佛齐》. 万历刻本，p. 29。



He Чанжян

THE CULTURAL WAY

1979 онд төрсөн, эрэгтэй. ӨМИС-ийн Монгол судлалын дээд сургуулийн түүхийн салбарын докторант. ӨМБИС-ийн Аялал жуулчлалын дээд сургуулийн багш, судалгааны чиглэл *түүхийн сурвалж бичгийн судалгаа, аялал жуулчлалын соёлын судалгаа*.

Шударга

1967 онд төрсөн, эрэгтэй. ӨМИС-ийн Монгол Судлалын Дээд Сургуулийн профессор, докторантын удирдагч багш, судалгааны чиглэл *түүхийн сурвалж бичгийн судалгаа, Мин, Чин гүрний үеийн монголын түүх*.

ЛУО РИЖЮН-ИЙ “ШЯНЬ БИНЬ ЛҮ” ЗОХИОЛЫГ ХЯНАН ШАЛГАХ НЬ

Престер Жон бол XII-XIII зууны үед Баруун Европт цэцэглэн хөгжсөн хүчирхэг дорно дахины несторианизмын захирагч байсан бөгөөд Персийн лалын шашинтнуудын эсрэг тулалдаж, нийслэлийг нь эзлэн, загалмайтны цэргүүдэд туслахаар Иерусалимын зүг чиглэж байв.

Түлхүүр үг: Луо Рижюн, Шянь Бинь Лү, түүхэн баримтын үнэ цэнэ, түүхэн ойлголт

Тус өгүүлэл бол Үндэсний нийгмийн шинжлэх ухааны сангийн томоохон төсөл “Юань-Мин (Хойд Юань) Монголын тэгш өдөрдөгийн түүхэн газар зүйн судалгаа”-ны хүрээнд бичигдсэн болно (19ZDA203).

ИХ ХЭЛМЭГДҮҮЛЭЛТИЙН ГАЛЫГ ӨӨРТӨӨ ТАТСАН НЬ

Б.Амартүвшин *

ХУРААНГУЙ

Тус өгүүлэлд А.Амар сайдын намтарыг өгүүлэхээс илүү Монголд өрнөсөн их хэлмэгдүүлэлт түүнийг тойроод биш дайраад өнгөрсөн тухай, мөн түүнийг хэрхэн хэлмэгдүүлж улс төрийн тавцангаас зайлуулсан, цаашлаад хэрхэн амь насаа алдсан тухай өгүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: А.Амар, хэлмэгдүүлэлт, ЗСБНХУ, МАХНТХ

УДИРТГАЛ

Улс төр, нийгэм, түүхийн нэрт зүтгэлтэн А.Амар (Гонгор) 1886 онд түшээт хан аймгийн Эрдэнэ дайчин вангийн хошуу одоогийн Булган аймгийн Бугат сумын нутаг Хан жаргалант хайрханы Ар Маалийн ам гэдэг газар Алтан ургийн Агданбуу тайжийн гэрт ууган хүү болон төржээ. Тэрээр бага насандаа эхээсээ өнчирсэн бөгөөд, аав нь түүнийг эрдэм номд шамдуулан, хошууны сургуульд сурч монгол бичиг, төвөд, манж хэл сурчээ. Тэрээр 1913 оноос Гадаад яаманд эх зохиогч түшмэл, дэс түшмэлийн алба хааж байв. 1921 оны Хувьсгалын үйл хэрэгт багахан оролцож, Хувьсгалын дараагаар ардын засагт боловсрол мэдлэгтэй хүмүүс ус, агаар хэрэгтэй басан тул Ерөнхий сайд Б.Цэрэндорж Амарыг ардын засагт алба хаалгахаар дуудуулж, тэр цагаас монголын төрд эргэлт буцалтгүй зүтгэжээ¹⁰⁵.

* ӨМИС-ийн МСДС-ийн түүхийн салбарын докторант.

¹⁰⁵ Ж.Болдбаатар. Монгол улсын засгийн газрын тэргүүн., УБ., 2013



THE CULTURAL WAY

А.Амар монголын улс төрд хашиж байсан албууд гэвэл:

- 1923-1928 онд Гадаад явдлын яаманд эрхэлсэн түшмэл, сайд Дотоод ба аж ахуйн явдлын яамны сайд, Ерөнхий сайдын жинхэнэ орлогч
- 1928-1930 Ерөнхий сайд
- 1930-1932 онд ШУХ-ийн дарга
- 1932-1936 БНМАУ-н Бага Хурлын Тэрг үүлэгчдийн дарга
- 1936-1939 Ерөнхий сайд, Гадаад явдлын яамны сайдаар хавсран ажиллаж байжээ.

А.Амарыг хэлмэгдүүлэх шалтгаан

А.Амар нь БНМАУ-н ерөнхий сайдаар 2 удаа, Улсын Бага Хурлын дарга, Гадаад явдлын яамны сайд зэрэг монголын төрийн хамгийн өндөр алба хашиж байсан бөгөөд, дотоод гадаад бодлого үйл ажиллагаандаа үндэсний ардчилсан шугамыг хэрэгжүүлэхийн төлөө тууштай байж, ЗХУ, коминтернээс Монголын талаар баримталж байсан бодлого шийдвэрт, шүүмжлэлтэй хандаж байсан нь ЗХУ-ын эсрэг үзэлтэн, хоёр орны найрамдалт харилцаанд эргэлзэж, тасалдуулах гэсэн хэмээн яллах үндэс болжээ¹⁰⁶.

Мөн ЗХУ болон Монголд өрнөж байсан Улс төрийн хэлмэгдүүлэлтийн хар шуурга буюу зохиомол хэргүүд бий болгож олон хүмүүсийг хомрогolon баривчилж байсан үйл явцад шүүмжлэлтэй хандаж, ДЯЯ-ны удирдлагад шаардлага тавих, сануулга өгөх, тэр бүү хэл таслан зогсоох оролдлого хийж байв. Тухайлбал “Лхүмбийн хэрэг” холбогдсон зарим хүмүүсийн хилс хэргийг цагаатган суллуулсан, 1937 онд Чойбалсангийн дураар аашилж байгааг Улсын Прокурорт сануулсан, 1937 рны НТХ-ны Бүгд хурал дээр зохиомол хилс хэрэг гарч байгааг хатуу сануулсан зэрэг нь ЗХУ түүнийг дайсан хэмээн үзэн хараандаа авчээ.

¹⁰⁶ Ж.Болдбаатар. Мэргэн сайд нэрт түүхч А.Амар илтгэл. 2016



THE CULTURAL WAY

А.Амарыг улс төрийн хилс хэргээр баривчлах үйл ажиллагаа

Өндөр мэдлэг боловсролтой, улс төрийн ноён нуруутай, ард олондоо нэр хүндтэй удирдагч А.Амарыг улс төрийн тавцангаас зайлуулах ажил ЗХУ болон түүний гар хөл болсон хүмүүст хялбар биш бөгөөд ихээхэн бэлтгэсэн нь лавдаггүй юм. Энэ нь түүнийг монголын нам төр, цэргийнхнийг хомрогolon баривчилсан 1937 оны 9 сарын 10-нд бус харин жил хагасын дараа буюу 1939 оны 3 сард баривчилсан гэдгээс харагдана. Тийнхүү баривчлахын тулд:

А.Амарыг улс төрөөс зайлуулах ажлыг дэс дараатай бэлтгэж, “түүнийг зайлуулахгүйгээр БНМАУ-ын удирдлагын нэгдлийг хадгалах боломжгүй” гэсэн дүгнэлтийг 1938 оны 9 сард бий болгов. 1937-1939 он улс төрийн хилс хэргээр баривчлагдсан БНМАУ, ЗСБНХУ-н харьяат 28 хүнээс албадах, тарчлаан зовоох зэрэг аргаар А.Амарын тухай сөрөг мэлүүлэг гаргуулан авчээ¹⁰⁷. Мөн Тухайн үеийн ОБЭК-н дарга маршал Х.Чойбалсанд ЗХУ-ын удирдлагаас өгсөн нууц заавар зөвлөмж өгч харилцан нот бичиг илгээж байжээ. Энэхүү А.Амарыг баривчлах үйл ажиллагааг монголын талаас гардан зохион байгуулах ажлыг Х.Чойбалсан, Д.Лувсаншарав нарт даалгаж тэд:

- Улсын бага хурал хуралдуулж Засгийн газрын тэргүүн А.Амарын үйл ажиллагааг тал бүрээс шүүмжлэх
- Амарыг УБХ, Засгийн газрын бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэрийг батлах
- Дараа нь Амарыг шууд баривчлах төлөвлөгөө гаргажээ¹⁰⁸.

Үүний дагуу 1939 оны 3 дугаар сарын 7-нд НТХ-ны бүгд хурлыг хуралдуулж түүн дээр Д.Лувсаншарав ”Намын төв хорооны тэргүүлэгч гишүүн А.Амарын нам бус явдлын тухай” илтгэл тавьж, түүнийг дэмжиж 14 хүн үг хэлсэн бол, мөн өдрийн үдээс хойш Улсын 22-р Бага хурлын хуралдаан болж, Х.Чойбалсан “Засгийн газрын байдал ба ерөнхий сайд А.Амарын ажил явуулгын тухай” илтгэл тавжээ. Түүнд:

- БНМАУ-ын дотор Японы тагнуулын байгууллага ажиллаж байсныг илрүүлэн устгаж хөрөнгөтний биш хөгжлийн замыг

¹⁰⁷ ТЕГ-ын тусгай архив. Ц-1384. Хуудас 163-198

¹⁰⁸ Ч.Дашдаваа, С.Туяа. Москвад цаазлагдсан монголын удирдагчид. УБ., 2011



THE CULTURAL WAY

хангаж чадсан ... гээд Ерөнхий сайд А.Амарын улс төрийн шугам, итгэмж хүндийн талаар өөрийн санаа дүгнэлтийг баримт тоочин өгүүлсний эцэст ..

- “Амарын улс төрийн шугам ажилчин ард нийтийн сонирхлоос тэс хөндлөн явж буй,
- Амар Улсын бага хурал ард түмнээс итгэсэн хүндтэй их үүргийг биелүүлж чадаагүй
- Ийм хүн улсын жолоог жолоодон сууж үл чадна. Амар манай хувьсгалын ажлыг саад хийж байсан ба цаашид ч саад хийнэ гэхэд буруудахгүй
- Би өөрийн үүргийн гүйцэтгэлээ. Үүнийг үнэнч ард, засгийн газрын гишүүд заавал хийж гүйцэтгэх үүрэг мөн¹⁰⁹ гэжээ.

МАХН-ын Төв Хорооны тэргүүлэгчдийн хурал дээр Х.Чойбалсан хэлсэн үгэндээ "... Ийм өнгөө нуусан, дотор нь харласан, идээ бээрээр гүйцсэн этгээдийг намын хүрээнд, түүнчлэн тэргүүлэгчээр нэг цаг, минут ч байлгахгүй хөөвөл зохино. Ерөнхий сайдын тушаалаас нь шууд зайлуулбал таарна" гэжээ.

Дараа нь үг хэлсэн хүмүүс Д.Лувсаншарав, Х.Чойбалсан нарыг дэмжиж ам өрсөн муучилж гарчээ. Эл хурлаар Амарыг Намын Төв Хорооны тэргүүлэгч ба намын гишүүнээс хөөж, Улсын Бага Хурлын гишүүн, Засгийн газрын Ерөнхий сайдын албан тушаалаас зайлуулах шийдвэр гаргасан байна.

Ингээд А.Амарыг шууд баривчилжээ. Ерөнхий сайд А.Амарын асуудлыг Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэхэд хурлын танхимын арын хөшигний цаана ЗХУ-аас Монголд суугаа Элчин Иванов, Дотоод явдлын яамны зөвлөх Скоков, Х.Чойбалсангийн зөвлөх Мальков, 17 дугаар армийн тагнуулын газрын дарга Панин нар нуугдан сууж хэн юу ярьсныг нь Н.Лхамсүрэнгээр орчуулуулан сонсож, бас олигтой нарийн сайн дамжуулсангүй гэж анхааруулж байсан гэдэг¹¹⁰.

МАХН-ын Х их хурлын дундуур Х.Чойбалсан Б.Баасанжавыг шоронгоос Дотоод явдлын яаман дээр аваачиж Д.Дамбатай нүүрэлдүүлэхэд хажуу өрөөнд Иванов болон сургагч нар чагнаж суусан гэдэг.

¹⁰⁹ Л.Бат-Очир. Чойбалсан УБ., 1996

¹¹⁰ Д.Өлзийбаатар. Монголчууд цахим түүх УБ. 2015



THE CULTURAL WAY

Энэ талаар түүхийн ухааны доктор Л.Бат-Очир "Энэ бүхэн нь эсэргүү гэж хилс баригдсан нам, төрийн зүтгэлтнүүдэд Х.Чойбалсангийн хэрхэн хандаж байгааг тагнаж хянаж байсан баримт мөн. Дэргэдээ тагнуултай, хажуудаа харгалзагчтайг мэдээд ч Х.Чойбалсан А.Амарын асуудал гэгчийг хэлэлцэхэд "өнгөө нуусан, дотор нь харласан, идээ бээрээр дүүрсэн" хэмээн муу муухайгаар хэлсэн ба шоронд тамлуулж хүнээр түшүүлэн амьдын төдий оруулж ирсэн Баасанжавыг үнэнээ хэлэхэд "аваад гар" гэж зандран догширч ширүүлсэн дүр үзүүлсэн байж болох талтай" хэмээжээ гэсэн байна

БНМАУ-ын ерөнхий сайд А.Амарыг 1939 оны 3-р сарын 7-ны өдөр ДЯЯ-ны сайд Х.Чойбалсангийн гарын үсэг зурсан бичигийн дагуу дайчлан баривчилжээ.

А.Амарын өгсөн мэдүүлгээс:

1939 оны 3-р сарын 14-ны өдрийн байцаалтанд хэрэгтэн А.Амарт 11 асуулт тавьж, тэрээр амьдралын түүх, гэр бүл, албан тушаал, ажил үйлийн талаар дараагаар нь 1939 оны 3-р сарын 30-31-нд өөрийн эсэргүү үйл ажиллагааны гэгчийн талаар өөрийн гараар бичин мэдүүлэг гаргуулжээ. *Энэхүү мэдүүлэгтээ:*

Би монголд шашин цэцэглэн хөгжиж байх үед төрсөн хүн. Бага наснаасаа ажил хийж феодал ноёдын үлдэгдлийн дарлалыг багагүй амссан. Хувьсгалын үйл хэрэгт хүчин зүтгэж дараа нь ГЯЯ-нд хүчин зүтгэж байхдаа монгол бол бие даасан улс байх ёстой гэдгийг сайн ойлгосон. ГЯЯ-н сайд Ханддорж, хичээнгүй сайд Б.Цэрэндорж, эрдэмтэн Цэвээнжамсранов нарын үндэсэрхэг үзэлтэй хүмүүсийн дунд би гэсэн үндэсэрхэг үзэлтэй болж панмонголизмийн үзэлтэй болсон. Ардын засаг мандаж үйл ажиллагаагаараа хатуу журам тогтоон хошуу ноёд, лам нарын эрхийг хасаж, татвар нэмэглүүлэн тэднийг шахан хавчиж байсныг байнга эсэргүүцэж хувьсгалын ажилд саад учруулж байв. Үүний зэрэгцээ Дамбадорж, Жадамба, Цэвээн нарын хамт барууны үзэл баримталж байв. Бусдын адил би ч гэсэн найрамдалт зөвлөлт улсаас холдож хөрөнгөтөн орныг түшихийг зорьж байв. Улс орноо хөрөнгөтний замаар хөгжүүлэхийг зорьж байв. Хятад, Америк, Герман, Франц зэрэг улс оронтой гэрээ байгуулж худалдааны пүүс оруулж ирэн, оюутан сургагч нарыг сургаж, аж үйлдвэрийн тоног төхөөрөмж оруулж ирэн барууны хандлагатай ажил явуулж байсан. Японы өдөөн хатгаасаар би монголын олон овог аймгийг нэгтгэж аугаа их улсыг байгуулахыг зорьж байсан ба



THE CULTURAL WAY

манай олон эрдэмтэн, төрийн зүтгэлтнүүд надтай санал нэг байсан. Би монгол улсыг хөрөнгөтний замаар хөгжүүлэхийг зорьж байлаа. Мөн Япон-Монголын хэлэлцээрт явсан хүмүүст Японтой харилцаа тогтоохийг даалгаж захиж байсан. Удалгүй газар сайгүй эсэргүү бүлгийг илчилж эхлэн Гэндэн, Дэмидийн бүлгийг илчилж салбаруудыг нь хүртэл илчилсэн. Би энэ байдлыг ашиглан лам хуврага, шашныг устгаж байна энэ нь цөөн хүн амтай манай улсад их хохиролтой хэмээн эсэргүүцэн шүүмжилж байлаа. Би Гэндэн, Дэмид нарын хэргийг заавал үргэлжлүүлэх ёстой хэмээн үзэж байсан. Би Японыг түшиглэн хөрөнгөт нийгэм байгуулахыг оролдон, Дамба, Довчин, Дорж нартай дотноссон. Манай улс ЗХУ-н тусламжаар асар хурдан хөгжиж бэхжсэн. Үүний сацуу улсын хөгжилд Япон болон дотоодын лам, феодал, эсэргүү нар байнга саад учруулж байсан.

Монгол орноо хайрлан хамгаалдаг, үй олноор баривчилж, цус урсгах явдлыг зогсоож, тайван амьдрахыг хүсдэг хүн бүр гэмт үйлдлээ зогсоож, орчин үед зохицоогүй ялзарсан үзлээсээ салж, мөхөж буй Японд итгэн түшиглэнэ гэсэн тэнэг бодлоо орхих, эх орон үндэсний хувьсгалын төлөө үйл ажиллагаа явуулах хэрэгтэй байна. Иймээс монголд ямар нэгэн баривчилгаа явуулж, цус урсгах явдалыг зогсоон ард олонд тайван амьдрах боломж олгох явдал зайлшгүй хэрэгтэй гэж үзэн өөрийн гэмээ бүрэн хүлээхээр шийдсэн юм. Гэж мэдүүлсэн байна.

Үүгээрээ Амар их хэлмэгдүүлэлтийн галыг өөртөө дуудаж энэ их хэлмэглүүлэлт, яргаллыг өөрөөрөө болон урьд өмнө баригдан шийтгэгдсэн хүмүүсийн хүрээгээр хязгаарлахыг хичээсэн байдаг.

Түүнийг ЗСБНХУ-ын ДХАК-ын Чита мужийн удирдах газрын 1939 оны 7 сарын 21-нд гаргасан тогтоолоор Москвад хүргэж 8-р сарын 1-ний өдрөөс ЗХУ-ын ДХАК-ын Лефертовогийн шоронд хорьжээ. Лефертовод А.Амар 1941 оны 7 сарын 27 хүртэл 2 жил хорин олон удаа байцааж, БНМАУ-ын зүтгэлтэн Д.Догсом, Г.Дамба, С.Довчин, Д.Лувсаншарав, Ө.Бадрах, Н.Насантогтох нартай нүүрэлдүүлэн өчиг мэдүүлэг авч зохиомол хэргийг тулган хүлээлгэх үйл ажиллагаа явуулжээ¹¹¹.

¹¹¹ ТЕГ-ын тусгай архив. Ц-1384. Хуудас 90-156



THE CULTURAL WAY

Ийнхүү байцаан А.Амарын эсэргүү үйл ажиллагааны талаархи материалыг бэлтгэн яллах дүгнэлт үйлдэж ЗСБНХОУ-ын эрүүгийн хуулийн 58-ийн 1а, 58-ийн 11-т заасан гэмт хэргийг үйлдсэн гээд “Амар хэргээ бүрэн хүлээсэн, мөрдөн байцаах ажиллагаа дууссан гэж” үзэн шүүхэд шилжүүлжээ. 1941 оны 7-р сарын 10-нд ЗСБНХУ-ын дээд шүүхийн Цэргийн Коллегийн хаалттай шүүх хурдаан болж А.Амарт цаазаар авах ял оноон 7-р сарын 27-нд гүйцэтгэжээ¹¹².

БНМАУ-ын ерөнхий сайд А.Амарыг цагаатгах ажил 1956 онд явагдсан бөгөөд ЗСБНХУ-ын Дээд шүүхийн Цэргийн Коллегийн хуралдаанаар А.Амарт ногдуулсан ялыг гэмт хэргийн бүрэлдхүүнгүй хэмээн үзэж хэрэгсэхгүй болгож 1962 оны 1-р сард АИХ-ын Тэргүүлэгчдийн газрын дэргэдэх Цагаатгах ажил эрхэлсэн комиссоос түүний нэр төрийг цагаатгасан шийдвэр гаргажээ¹¹³.

ДҮГНЭЛТ

Төр нийгмийн нэрт зүтгэлтэн А.Амар улс орныхоо бүрэн эрхэт байдал, үндэсний эрх ашгийн төлөө тууштай зогсож байсныхаа төлөө гадаад улсын хуулиар шийтгэгдэн хороогдсон юм. Тэрээр Би монгол улсын иргэн хүн учраас миний хэргийг Зөвлөлтийн шүүхээр бус Монголын шүүхээр шүүх ёстой. БНМАУ-д Хувьсгалын эсэргүү ямарч бүлэглэл байгаагүй хэмээн мэдэгдэж байв.

ОХУ-ын Аюулгүй байдлын албаны төв архиваас ирүүлсэн давлагаанд түүний нэр Москва орчмын “Коммунарка” сангийн аж ахуйн орчимд хороогдсон 232 рүний 191 дүгээрт бичигдсэн байжээ.

А.Амар: “Монголд ямар нэгэн баривчилгаа явуулж, цус урсгах явдалыг зогсоон ард олонд тайван амьдрах боломж олгох явдал зайлшгүй хэрэгтэй гэж үзэн өөрийн гэмээ бүрэн хүлээхээр шийдлээ” хэмээн мэдүүлж их хэлмэгдүүлэлтийн галыг өөртөө дуудаж энэ их хэлмэглүүлэлт, яргаллыг өөрөөрөө болон урьд өмнө баригдан шийтгэгдсэн хүмүүсийн хүрээгээр хязгаарлахыг хичээсэн байдаг. Энэ утгаараа эх орондоо хичнээн их хайртай, эх орон, ард иргэд, журмын олон нөхдийнхөө төлөө өөрийн амь насаа гаргуунд нь гарган эцсээ

¹¹² ТЕГ-ын тусгай архив. хн. Хуудас 28-31

¹¹³ Ч.Дашдаваа, С.Туяа. Москвад цаазлагдсан монголын удирдагчид. УБ., 2011. Тал 44-46



THE CULTURAL WAY

хүртэл тэмцэж чадсан баатарлаг нэгэн болохоо, хойч үеийнхэндээ харуулж чадсан юм.

НОМ ЗҮЙ

1. Ж.Болдбаатар. Монгол улсын засгийн газрын тэргүүн., УБ., 2013
2. ТЕГ-ын тусгай архив
3. Ч.Дашдаваа, С.Туяа. Москвад цаазлагдсан монголын удирдагчид. УБ., 2011
4. Л.Бат-Очир. Чойбалсан УБ., 1996
5. Ж.Болдбаатар. Мэргэн сайд нэрт түүхч А.Амар илтгэл. 2016
6. Д.Өлзийбаатар. Монголчууд цахим түүх УБ. 2015

ЛАМ НАРЫН СЭТГҮҮЛИЙН ТУХАЙ

Л.Чулуунбаатар *

ХУРААНГУЙ

Өвгөдийн ярих нь "Лам нарын сэтгүүл" 6 дугаар гарсан гэдэг билээ. Энэ хугацаанд эрэн сурагласаар 1936 онд гарсан № 3, 4 мөн 1937 оны № 1, 2 болон № 5, 6 дугаар сэтгүүлийг олж авав. № 3, 4 нь нэг дэвтэр № 1, 2 болон № 5, 6 нь нэг дэвтэр болой. Хоёр дэвтэр хоёулаа монгол хэлээр, хоёр үсгээр хавсран хэвлэсэн боловч 1936 онд хэвлэгдсэн нь төвд үсгээр монгол хэлээр бичсэн нь эхэндээ, 1937 оных нь монгол бичгээр бичсэн сэдвүүд нь эхэндээ байна. Энэ нь лам нарын унших чадвар боломжийг харгалзан үзсэн хэрэг бололтой. Энэ хоёроос өөрийг олж үзээгүй тул ер нь энэ хоёр сэтгүүлд орсон 6 дугаараа хэлж байгаа юм биш үү гэдэг сэтгэгдэл төрсөн юм. Гэвч нарийвчлан, дахин нягтлан шалгах хэрэгтэй юм. Монгол хэлээр төвд үсгээр бичсэн зохиол бүтээлийн талаар гадаад дотоодын эрдэмтэд анхаарал хандуулж судалгаа хийсээр ирсэн билээ. Мөн энэ сэтгүүлийн хамгийн гол зорилго бол лам нарыг монгол бичигт сургах, худал ташаа мэдээллийг арилгаж үнэн зөв мэдээлэл лам нарт хүргэх зорилготой байсан байна. Энэ тухай сэдэв бүрээр задлан яривал маш урт зүйл болох бөгөөд энэ удаа тийм зорилго тавиагүй тул үүгээр товчилъё. Ер нь түүх бичлэгийн асуудалд лам нарын энэ сэтгүүлээс баримт болгон ашигласан зүйл туйлын хомс байдаг бөгөөд ганц хоёр мөрийг иш татсан зүйл мэр сэр тааралддаг. Энэ нь үзэл суртлын хатуу хүлээсийн улмаас уншиж ашиглах байтугай харах ч хориотой байсанд оршино. Социалист номлолын үед лам нарыг шашнаар мунхруулагчид хэмээн ухуулдаг байсан тул дунд үеийнхэн тэдний талаар туйлын ташаа ойлголттой байдаг болой. Тэд ямарч үед оюуны соёлыг түгээн дэлгэрүүлэгч, хөгжүүлэгч байсан гэдгийг энэ сэтгүүл болон түүхийн олон баримт нотолдог билээ.

* Монголын Үндэсний Их Сургуулийн ОУХС-ийн профессор



THE CULTURAL WAY

Түлхүүр үгс: Лам нарын сэтгүүл, төвд үсэг, монгол хэл, монголч эрдэмтэн, төвд үсгээр бичих систем

Оршил: Энэ өгүүлийг 2003 оны намар болсон Японы монгол судлаачдын намрын эрдэм шинжилгээний ээлжит бага хуралд тавьсан бөгөөд Токиогийн Гадаад судлалын Их Сургуулийн профессор Окадо Казюүки авгай япон хэлээр орчуулж ТГСИС-ийн Соёлын Солилцооны Судалгааны Хүрээлэнгийн 2004 оны эрдэм шинжилгээний сэтгүүлийн 8-р ботийн 176-180-р хуудсанд¹¹⁴ хэвлүүлсэнд туйлаар талархаж явдаг билээ. Энэ удаад бол тэр үед тавьсан илтгэл дээр олон зүйлийг нэмэн оруулсан тул илүү өргөн хүрээтэй болсон хэмээн үзнэ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Өвгөдийн ярих нь *"Лам нарын сэтгүүл"* 6 дугаар гарсан гэдэг билээ. Энэ хугацаанд эрэн сурагласаар 1936 онд гарсан № 3, 4 мөн 1937 оны № 1, 2 болон № 5, 6 дугаар сэтгүүлийг олж авав. № 3, 4 нь нэг дэвтэр № 1, 2 болон № 5, 6 нь нэг дэвтэр болой. Хоёр дэвтэр хоёулаа монгол хэлээр, хоёр үсгээр хавсран хэвлэсэн боловч 1936 онд хэвлэгдсэн нь төвд үсгээр монгол хэлээр бичсэн нь эхэндээ, 1937 оных нь монгол бичгээр бичсэн сэдвүүд нь эхэндээ байна. Энэ нь лам нарын унших чадвар боломжийг харгалзан үзсэн хэрэг бололтой. Энэ хоёроос өөрийг олж үзээгүй тул ер нь энэ хоёр сэтгүүлд орсон 6 дугаараа хэлж байгаа юм биш үү гэдэг сэтгэгдэл төрсөн юм. Гэвч нарийвчлан, дахин нягтлан шалгах хэрэгтэй юм. Монгол хэлээр төвд үсгээр бичсэн зохиол бүтээлийн талаар гадаад дотоодын эрдэмтэд анхаарал хандуулж судалгаа хийсээр ирсэн билээ. Энэ талаар *"Mongolian in Tibetan script"* нэртэй анхны өгүүлийг Данийн эрдэмтэн Кааре Грөнбэч (Kaare Grønbech) 1953 онд бичиж, Studia Orientalia сэтгүүлд хэвлүүлсэн билээ.

Өгүүлэлдээ тэрээр төвд үсгээр монгол хэлээр бичих явдал бол лам нарын хувьд *"тогтсон тогтвортой хэм хэмжээ"* хэмээн дүгнэсэн байдаг бөгөөд олон зуун жил хэрэглэж ирсэн хийгээд *"лам нар амаар хоёр хэлрүү орчуулж чадах боловч бичгээр санаагаа илэрхийлэх үедээ гагц мэддэг төвд үсгээрээ илэрхийлэн бичих нь зайлиггүй байсан юм"* хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Энэ санааг Оросын эрдэмтэн А.М.Позднеев 1887 онд бичсэн *"XIX зууны сүүл үеийн Монголын ламын шаашин"* номдоо анх гаргасан байдаг билээ. Алаксей Бобровников авгайн 1849 онд Казанд хэвлүүлсэн *"Монгол-Халимаг хэлний зүй"* хэмээх номдоо ч энэ талаар бас дурдсан зүйл буй. Кааре Грөнбэч бол Өвөрмонголд хийсэн Данийн эзэн хааны номын сангийн судалгааны экспедицийн бүрэлдхүүнд оролцон явж олон зуун монгол ном цуглуулж,

¹¹⁴P176-180 総合文化研究 VOL. 8 (2004)



THE CULTURAL WAY

Данийн эзэн хааны номын сангийн монгол номын фондыг үндэслэн байгуулсан гавьяатан билээ. Хожим тэдгээр номын каталог болон тайлбарыг “*Catalogue of Mongol books, manuscripts and xylographs*” хэмээх нэртэйгээр Вальтер Хайсэг (Walther Heissig), Чарльз Боодан (Charles Bawden) нар хамтран хийж 1971 онд хэвлүүлсэн юм.

Үүний дараа профессор Т.Пагва “Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол” хэмээх томоохон хэмжээний өгүүлэл бичиж үсэг зүй, зөв бичлэгийн талаар нилээд чамбай тайлбарлаж 1957 онд хэвлүүлсэн бөгөөд академич Ц.Дамдинсүрэн авгай 1959 онд хэвлүүлсэн “*Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой*” цоморлигтоо Гэлэгбалсангийн төвд үсгээр монгол хэлээр бичсэн “Наадмын ерөөл”¹¹⁵ шүлгийг оруулж товч тайлбар хийсэн юм. Мөн энэ жил академич Б.Ринчин Ишдоржийн зохиосон “*Ye-šes-rdo-rje Bod-skad-kyi-brdah-gsar-rñiñ-dkan-ba sog-skad-du-kah-li-sum-cuhi-rim-pas gtan-la-pheb-pahi-brdah-yig-mkhas-pa rgya-mcho-blo-gsal-mgul-rgyan-ces bya-ba-bžugs-so*”¹¹⁶ хэмээх төвд үсгээр бичсэн Төвд-Монгол толийг хэвлүүлсэн бөгөөд оршлын үгэндээ “*Монгол үгийг төвд үсгээр өөрийн нутгийн аялгууг баримтлан, аман бичгийн хэлний байдлаар тэмдэглэсэн нь монгол аялгууг судлах монголч эрдэмтэнд маш сонин чухал зүйл болжээ*” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг.

Английн нэрт монголч эрдэмтэн д-р Чарльз Боодан “*Mongolian in Tibetan script*” хэмээх Кааре Грөнбэчтэй адил нэртэй өгүүлэл бичиж *Studia Orientalia* сэтгүүлд 1960 онд хэвлүүлсэн билээ. Гэсэн хэдий ч судлаачид лам нарын энэ сэтгүүлд дагнан анхаарал хандуулсан нь үгүй билээ. Т.Пагва багш болон Ч.Боодан нар дурдах төдий өнгөрсөн байдаг. Ч.Боодан дээр дурдсан өгүүлэлдээ ч энэ сэтгүүлийн талаар бас л цухас дурдсан байдаг юм. Харин Ч.Боодан “*Орчин үеийн монголын түүх*” номдоо “*нэг юмуу хоёр жил хэвлэгдсэн*”¹¹⁷ хэмээн дурдсан нь миний дээрх хоёр дэвтэрт орсон 6 дугаар бол нийт гарсан 6 дугаар мөн гэдгийг ялимгүй ч гэсэн баталгаажуулж байгаа юм. Д-р Л.Чулуунбаатар 2000 онд нийтлүүлсэн “*Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл*” хэмээх номдоо төвд үсгээр монгол хэлээр бичсэн зохиол бүтээлийн эгшиг гийгүүлэгчийн системийн талаар сайтар харьцуулан бичиж оруулсан байдаг. Өрнөдийн эрдэмтэдээс энэ сэтгүүлийн талаар анхаарал хандуулан дагнаж, товч судалгаа хийсэн хүн бол Америкийн судлаач Степани Гривелет (Stephane Grivelet) юм. Тэрээр 2001 онд Индианы Их

¹¹⁵ C, Demdiesoiroicit, MoeIgo& oa Forea Joliye& oa DeIejI Jegoa biliet ForosibEI, Corpus Scriptorum Mongolorum, tomus XIV, FolegeebEgedo*, 1959, x 1966-1969

¹¹⁶ Ye-šes-rdo-rje Bod-skad-kyi-brdah-gsar-rñiñ-dkan-ba sog-skad-du-kah-li-sum-cuhi-rim-pas gtan-la-pheb-pahi-brdah-yig-mkhas-pa rgya-mcho-blo-gsal-mgul-rgyan-ces bya-ba-bžugs-so, Corpus Scriptorum Mongolorum, tomus IV, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1959 он, x 7

¹¹⁷ Bawden Charles, 1989[1968]. The Modern History of Mongolia. London: P 248



THE CULTURAL WAY

Сургуулийн Монголын нийгэмлэгийн сэтгүүлд цувралын нэгэн дугаар болгож 1936 оны лам нарын сэтгүүлийг хуулбарлаж өмнө нь гурван хуудас судалгааны өгүүлэл оруулан *“The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script”* хэмээх нэртэйгээр хэвлэж гаргасан юм. Энэ өгүүлэлдээ үсгийг оноосон байдалд нилээн сайн дүгнэлт хийсэн байдаг юм. Тэрээр *“Бичлэгийн хоёр системээр хавсран гаргасан нь төвд үсгээр бичигдсэн лам нарын сэтгүүл нь монгол бичвэрүүдийг илүү сайн ойлгоход тус болохоос гадна энэ салбар дахь үнэлж баригүй чухал баримт юм”*¹¹⁸ хэмээн дүгнэсэн нь буй.

1935, 1936 он бол латин үсэг сурахыг зогсоож монгол бичгийг бүх нийтээр сурах хөдөлгөөн өрнүүлсэн жил бөгөөд нэн ялангуяа нийт эрэгтэйчүүдийн 40 шахам хувийг эзэлж байсан лам нарыг үндэсний бичигт сургахыг нэн чухалчилж эхний үед сайн дурын бодлого баримтлан урсгалаар нь явуулж байснаа дараа нь сумын захиргаа, клуб, улаан булан, хүрээ хийдийг түшиглүүлэн байгуулсан бүлгэм дугуйланд зохион байгуулалттай хамруулан сургах болсон байна. Лам нарыг үндэсний бичигт сургахад эхэндээ орон тооны үсэг бичгийн багш ажиллуулж байгаад, сүүлдээ монгол бичигтэй сайн дурын лам нарыг багшаар ажиллуулах болжээ.

1935-1937 оны байдлаар 20 мянга гаруй залуу лам нар бичиг үсгийн бүлгэмд хамрагдах болжээ. Эхний дэвтэрийн зорилго бол төвд үсгийг бүх лам нар мэдэх учраас төвд үсгээр монгол хэлээр эхэлж уншаад суралцаж буй лам нар монгол бичгээр харьцуулан унших бололцоог бодолцсон бололтой. 1937 оны дэвтэрийн эхэнд нь монгол бичгээр сэдвүүдээ хэвлэсэн явдал бол олон хүрээ хийдийн лам нар монгол бичиг сурах хөдөлгөөнд хамрагдаж ихэнх нь монгол бичиг мэддэг болоод байсан тул ийнхүү эхэнд нь тавьсан байна. Жишээлбэл: Амарбаясгалант хийдийн 1937 оны бүртгэлд монгол бичиг мэдэх 18, монгол бичигт суралцаж байгаа 120 гэсэн тоо байгаа нь сүм хийд сургалтыг эрчимжүүлж байсны баталгаа юм. Шашны захиргааны 9-р хурлын тогтоол дотор *“шашин номын хэргийг эрхэлсэн нэгэн хэсэг лам бид нар нь угаас монгол хүн болохыг хэрхэвч умартаж ул болох тул, өөрийн үндэс язгуур ба засаг төр хийгээд ардын үндэсний соёл боловсролыг дээшлүүлэх хэрэгт санаа зовнин туслалцах нь чухал хэмээн үзмүй. Ер ч үндэсний монгол бичгийг суралцах явдал нь монголын ард түмний соёл боловсролыг дээшлүүлэх ба тусгаар тогтносон засаг төрийг улмаар батжуулах явдалд хамгийн чухал нөхцөл мөн болмой”*¹¹⁹

¹¹⁸ Stephane Grivelet, 2001. “The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script”. Bloomington. P VI

¹¹⁹ “Лам нарын сэтгүүл”, 1936 (26) VIII. IX. № 3, 4, x 100-104



THE CULTURAL WAY

хэмээн тодорхой заасан байгаа болой. Лам нарыг бичиг үсэгт сургах болон лам нарын сэтгүүл гаргах цаг үеийн ямар шаардлага байсан бэ хэмээн асууж болох юм. 1928 оноос эхлэн тус орны зах зээлээс гадаадын капиталыг хүчээр хөөн гаргаж, чинээлэг аж ахуйг хавчин хязгаарлах феодалын болон томоохон аж ахуйг эдийн засаг улс төрийн талаар довтолж ангич бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ.

Энэ үед Монгол оронд гадаадын 1080 гаруй пүүс байсан бөгөөд 800 гаруй нь хятадын, үлдэх хувь нь Орос, Герман, Итали, Франц, Англи, Америк, Япон, Дани, Энэтхэг зэрэг олон орны пүүс байсан хийгээд мал сүргийн ихэнх нь чинээлэг ард болон сүм хийдийн жасын мэдэлд байв. Энэ хүчирхийлэл нь монголын өвөрмөц нөхцөлд тохирохгүй байсны улмаас ардын бослого тэмцэл өрнөж олон мянган өрх айл хил даван нүүж, МАН, ардын засгийн нэр хүнд унаж иргэний дайн гарах ирмэг дээр ирэв. Иймд ЗОУ-ын удирдлага арга буюу Монгол дахь үйл ажиллагаагаа түр зогсоож монголыг монголоор нь удирдуулах боломжийг олгожээ.¹²⁰ Лам нарын талаар анги ялгаварласан намын бодлогыг гажуудуулж лам нарыг нийтэд нь хавтгайруулан довтолсон зүүнтний гэм алдааг засаж лам нарыг ард түмний талд татах бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцсэн байна.

Нугалааны үед дунд лам нарыг эсэргүү хэрэгт элдвээр холбогдуулсан завхрал гарсныг хянан үзэж эсэргүү хэрэгт үл холбогдогсдыг суллан цагаатгав. Бас хар болсон лам нарт сонгуулийн эрх эдлүүлсэн байна. Лам нарыг албадан хар болгохыг зогсоож, албаар хар болсон лам нар хэрэв хүсвэл эргэж лам болохыг зөвшөөрчээ. 1932-1934 онд 27 мянга гаруй хүн эргэж лам болжээ.¹²¹ Сүм хийдийг албадан хаах, хууль бусаар нэгжих хурал номын үйл ажиллагааг зүй бусаар үймүүлэхийг хориглов. Сүм хийд өөрийн харьяа жасдаа бүрэн эзэн байх эрхийг хэтэрхий үгүйсгэж байсныг бас зассан байна.¹²² 1932-36 онд том жижиг сүм хийд, хурлын газар 840 гаруй¹²³ байсан бөгөөд тэнд 90 орчим мянган лам нар байжээ. Тэдний 18 мянга орчим нь сургуулийн насны хүүхэд байсан байна.¹²⁴ Дунджаар шашны хурал номын нэг газарт 900 орчим хүн, нэг ламд 10 хүн, гурван өрх оногдож байснаас ч үзсэн шарын шашин үлэмж нөлөөтэй оршсоор байсан нь илэрхий. Лам нарын хэрэгцээнд жилд дунджаар 31 сая төгрөгийн хөрөнгө зарагдаж байсан нь тэр үеийн ардын сургуулийн нэгэн жилийн зардлаас 16 дахин их

¹²⁰ С.Отгонжаргал, "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990), УБ, 2003, х 72-73

¹²¹ НАХ байгууллагын архив, 1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл

¹²² БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х 301

¹²³ МАХН-ын төв архив, ф-1 ХН.7 124-р тал

¹²⁴ МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл, боловсролыг хөгжүүлэхэд намаас тавих зорилгын тухай илтгэл, УБ, 1934, 13-р талд



THE CULTURAL WAY

байлаа.¹²⁵ Тийм болохоор Засгийн газар лам нарыг аль болохоор гэгээрүүлэн ухамсарлуулж хар болгон улсын хөдөлмөрт татан оролцуулахыг эрмэлзэж байв. Зөвхөн 1936 онд мал аж ахуй, үйлдвэр, тээвэр, худалдааны ажилд 10 мянга гаруй лам нар шилжин ажиллажээ.¹²⁶ Нийгмийн ашигтай хөдөлмөр хийхийг сонирхсон доорд лам нарт улсаас элдэв тусламж дэмжлэг үзүүлэх, бүх төрлийн татвараас хөнгөтгөх хэлтрүүлэх арга хэмжээ авав. 1936 онд аж ахуйд гарах доорд лам нарт зориулж улсаас 500 000 төгрөгийн зээллэгийн фонд гаргажээ. 1936 онд хөдөө аж ахуйд гарч ажилласан 200 гаруй лам нарт 114 000 төгрөгийн зээллэг өгчээ.¹²⁷ Лам нарыг нийгмийн ашигтай хөдөлмөрт татан оруулах чухал нэг хэлбэр нь доорд лам нарын артель байлаа.

МАХН, засаг доорд лам нарыг үйлдвэр, хамтын аж ахуйд татан оруулах ажлыг 1935 оноос туршиж үзсэний эцэст 1937-1938 онд лам нарын дотор өргөн хөдөлгөөн болгон зохион байгуулжээ. 1938 онд ядуу лам нарын гар үйлдвэрийн 120 артель байгуулагдаж, түүнд 5000 гаруй лам нар оржээ.^{128 129} Гэсэн хэдий ч олон улсын байдал ноцтой хүндэрч, ЗХУ болон коминтерний эсрэг Герман, Итали, Японы гурвын гэрээ байгуулагдаж, дэлхийн хоёрдугаар дайн дэгдсэн нөхцөлд Сталин Монгол орныг баттай ар талаа болгох бодлогоо шуурхайлж эхэлжээ. Тэрээр нам төрийн гол удирдагчид болох А. Амар, П. Гэндэн, Х. Чойбалсан нарыг удаа дараа тухайлбал, улсын ерөнхий сайд П.Гэндэнг таван удаа, А.Амарыг нэг удаа, Х.Чойбалсанг долоон удаа хүлээн авч уулзахдаа хар шар феодал, лам нарын үлдэгдлийг устгахыг шаардсаар байв. Энэхүү шаардлагыг П. Гэндэн, А. Амар нар боломжгүй хэмээн хүлээж аваагүйгээр барахгүй зүйл бүрээр эсэргүүцэж байв.

И.В. Сталингаас лам нараа ангийн дайсан хэмээн устгахыг шаардахад П. Гэндэн *"Манай улс хүн ам цөөтэй учир лам нараа хар болгож ажил хийлгэнэ"*¹³⁰ хэмээн эеэргүүцжээ. Мөн тэрчлэн П.Гэндэн *"... тус улсын гадаад байдал түгшүүртэй байх үед лам нарын асуудлыг хурцатгаж, тэд нартай тэмцэх гэсэн хүн бол хувьсгалын эсэргүү болно"*¹³¹ хэмээн лам нарыг хамгаалах талд тууштай зогсож байсан билээ. Яагаад Сталин ингэж лам нарыг ангийн дайсан хэмээн устгахыг

¹²⁵ БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х 342

¹²⁶ Намын амьдрал сэтгүүл, 1964 он, № 3 31-р тал

¹²⁷ МАХН-ын ТА, ф. 1, т. 6, хн. 51 81-р тал

¹²⁸ БНМАУ-ын гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар их хурлын илтгэл тогтоол, 1940 он, 33-35-р тал

¹²⁹ БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х 350

¹³⁰ С.Отгонжаргал, "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990), УБ, 2003, х 73

¹³¹ БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х 356



THE CULTURAL WAY

эрчимтэй эрмэлзэж байсан бэ гэвэл анхнаасаа 1911 оны үндэсний чөлөөлөх хөдөлгөөн болон 1920 оны Монгол Ардын Намын гишүүдийн ихэнх нь эрдэм чадалтай лам нар байсан бөгөөд мөн тэрчлэн Ардын засгийн анхны ерөнхий сайд нар бас л эрдэм төгс дээд лам нар байсан билээ.

Тэд нар шашин соёл, үндэсний онцлогоо ямагт хадгалахыг хичээж Монголоо монголоор удирдахыг хичээж, тэдний заавар журмыг тэр болгон дагахгүй, бодлогоо хэрэгжүүлэхэд нь том хаалт болж байсанд оршино. Улс төрийн нөхцөл байдал иймэрхүү байсан учраас лам нарыг ухамсарлуулах үндсэн дээр боловсролтой болгох, хар болгож, хөдөлмөрт татан оролцуулах ажлыг дэс дараатай хийж энэ хэрэгт сүм хийдийн захиргааг татан оролцуулж байсныг энэ сэтгүүлээс харж болох юм. 1936 оны сэтгүүлийн гарчгийг жагсаавал:

Оршил

1. Шашны захиргааны 9-р их хурлын тогтоол
2. Шашны захиргааны дүрэм
3. Лам нарын тухай засгийн бодлого
4. Сэтгүүлийн хашаанд орхисон нэргүй бичгийн хариу
5. Улсын дээд шүүхээс тасалсан нэгэн хэрэг
6. Лам нарын дотор үүсч буй үйлдвэрийн тухай мөн илтгэл ба тайлан
7. Дотоод монголоос оргож ирсэн нэгэн ламын ярьсан зүйл
8. Орлого бүхий лам нарт албан татвар ноогдсон тухай
9. Лам хүүхдийн бичиг үсгийн сургууль
10. Завханаас ирүүлсэн захидал
11. Завхан дахь сурвалжлагчаас бичсэн зүйл
12. Зарим хуурамч явдлыг илрүүлэн шүүмжлэх нь
13. Орон нутгийн тусламж ба захидалууд¹³²

1937 оны сэтгүүлийн гарчгийг жагсаавал:

1. Шашны захиргааны 9-р их хурлын тогтоолын явц
2. Үнэн худлын тодорхой ялгавар хэмээх оршвой
3. Лам нарт таниулах хэмээсэн товч өгүүлэл
4. Өлгийн ба Егзөрийн хийдийн хэсэг урвасан лам нарын хэргүүдийн тухай хоёр зүйл
5. Манай улсын доторхи олон хүрээ хийдийн дотор юу болж байгаа буй
6. Орон нутгийн сурвалжлагч нар ба бусад лам нараас бичсэн санал шүүмжлэлүүд
7. Болох эсэхийг бусдын анхааралд талбимуй

¹³² "Лам нарын сэтгүүл", 1936 (26) VIII. IX. № 3, 4, х 89



THE CULTURAL WAY

8. Орон нутгийн сайшаал ба тусламжууд ¹³³ гэсэн сэдвүүд байгаа болой.

Эдгээр сэдвээс харахад тэр үеийн засгийн бодлогыг тодорхой тусгаж байсан нь илэрхий харагдаж байгаа болой. Мөн энэ сэтгүүлийн хамгийн гол зорилго бол лам нарыг монгол бичигт сургах, худал ташаа мэдээллийг арилгаж үнэн зөв мэдээлэл лам нарт хүргэх зорилготой байсан байна. Энэ тухай сэдэв бүрээр задлан яривал маш урт зүйл болох бөгөөд энэ удаа тийм зорилго тавиагүй тул үүгээр товчилъё. Ер нь түүх бичлэгийн асуудалд лам нарын энэ сэтгүүлээс баримт болгон ашигласан зүйл туйлын хомс байдаг бөгөөд ганц хоёр мөрийг иш татсан зүйл мэр сэр тааралддаг. Энэ нь үзэл суртлын хатуу хүлээсийн улмаас уншиж ашиглах байтугай харах ч хориотой байсанд оршино. Социалист номлолын үед лам нарыг шашнаар мунхруулагчид хэмээн ухуулдаг байсан тул дунд үеийнхэн тэдний талаар туйлын ташаа ойлголттой байдаг болой. Тэд ямарч үед оюуны соёлыг түгээн дэлгэрүүлэгч, хөгжүүлэгч байсан гэдгийг энэ сэтгүүл болон түүхийн олон баримт нотолдог билээ.

ДҮГНЭЛТ

Энэ сэтгүүлийг үзээд дараах хэдэн дүгнэлт гарч байна.

1. Сэтгүүлийн бичвэрүүд нь 30-аад оны түүх бичлэгт чухал хэрэглэгдхүүн болох юм.
2. Тэр үеийн хүрээний лам нарын ярьж байсан аман аялгууг төвд үсгээр буулган бичсэн нь аялгуу судлалын хувьд үнэт хэрэглэгдхүүн болно.
3. Урьд өмнөх төвд үсгээр монгол хэлээр бичиж тэмдэглэж байсан туршлагаудыг нэгтгэн нэгэн мөр болгон төвд үсгээр бичих системийг үндсэнд нь тогтоож өгсөн гэж хэлж болох юм.

¹³³ "Лам нарын сэтгүүл", 1937 оны 1 ба 2-дугаар бөгөөд 5, 6 дугаар сэтгүүл, х 2



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

1. БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969
2. БНМАУ-ын гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар их хурлын илтгэл тогтоол, 1940 он
3. Bawden Charles, 1989[1968]. The Modern History of Mongolia. London:
4. С.Демдiesoiroeit, MoeIgo& oa Forea Joliye& oa DeIEJI Jegoa biliiet ForosibEI, Corpus Scriptorum Mongolorum, tomus XIV, FolegeebEgedo*, 1959
5. "Лам нарын сэтгүүл", 1936 (26) VIII. IX. № 3, 4
6. "Лам нарын сэтгүүл", 1937 оны 1 ба 2-дугаар бөгөөд 5, 6 дугаар сэтгүүл
7. МАХН-ын төв архив, ф-1 ХН.7
8. МАХН-ын ТА, ф. 1, т. 6, хн. 51
9. МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл, боловсролыг хөгжүүлэхэд
намаас тавих зорилгын тухай илтгэл, УБ
10. С.Отгонжаргал, "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990), УБ, 2003
11. Намын амьдрал сэтгүүл, 1964 он, № 3
12. НАХ байгууллагын архив, 1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл
13. Л.Чулуунбатар, "Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл", УБ., 2000, 2011
14. Stephane Grivelet, 2001. "The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script". Bloomington. P VI
15. Ye-šes-rdo-rje Bod-skad-kyi-brdah-gsar-rñin-dkan-ba sog-skad-dukah-li-sum-cuhi-rim-pas gtan-la-pheb-pahi-brdah-yig-mkhas-pa rgya-mcho-blo-gsal-mgul-rgyan-ces bya-ba-bžugs-so, Corpus Scriptorum Mongolorum, tomus IV, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1959 он
16. 総合文化研究 VOL. 8 (2004)



THE CULTURAL WAY

ABSTRACT

These journals published in 1936 and 1937. Those journals' names were "Journal of Lamas". Those journals did not studied widely and some scholars gave attention to these journals and mentioned in their publications. For example: Kaare Grønbech, scholar of Danish, A.M.Pozdnev and Aleksey Bobrovnicov who were scholars of Russian, T.Pagba, Ts.Damdinsuren8 B.Rinchin, L.Chuluunbaatar, scholars of Mongolian and Charles Bawde, who well known scholar of England. From the western scholars, Stephane Grivelet gave more attention and made brief study. These journals aim was to clear illiterate among the lamas. Therefore, those published both scripts Mongolian and Tibetan in Mongolian language. Texts of journals is valuably to the 30th years historical writings. Also, it is the valuable resources of 30s oral language. It was established that writing system of Tibetan script in Mongolian language.

**ИЛГЭЭЛТИЙН ШҮЛГИЙН АРГААР ЭНЭ ДЭЛХИЙТЭЙ ХУУЧИЛЖ БАЙСНЫ
УЧИР**

Р.Чойном, Л.Чулуунбаатарын уран бүтээлийн жишээн дээр

Л.Хасбаатар *

ХУРААНГУЙ

Монгол орны яруу найргийн сэдэв дотор зориулалт буюу илгээлтийн хэлбэрийн шүлэг найраг олон байдаг. Илгээлтийн шүлгийн гол сэдэвлэхүүн нь найз нөхөд, амраг хайрын тухай, эх орон, нутаг усны тухай, аав ээж ахмад дээдсийн тухай, үндэстэн угсаатны хөгжил бадрал, соёл түүхийн төлөөний санаашрал бодол зэрэг олон талыг агуулж байдаг. 20 дугаар зууны сүүлийн хагас зууны монгол яруу найрагчдын дотор төлөөлөгч болох хоёр найрагчийн шүлэг бүтээлийг харьцуулан өгүүлж тэдний үзэл бодлыг дэлгэн үзүүлэхийг зорьсон юм.

Түлхүүр үгс: Р.Чойном, Л.Чулуунбаатар, илгээлтийн шүлэг

Хүн төрөлхтний түүхэн цаг үе өөр өөрийн өнгө аястай хөгжиж байдаг. Тэрхүү цаг үед амьдарч байсан яруу найрагчид нь ч өөрийн үзэл бодол, урлахуй арга барилаар зохион туурвисаар нийгэм нийттэйгээ зохицолдон ирсэн ажээ. Тухайн нийгмийн тогтолцоо, цаг төрийн байдалтайгаа хэрхэн уялдаж холбогдох нь хүмүүсийн адил бус үзэл сэтгэлгээтэй ч шууд холбогдоно. Төр гүрний бодлого, ард түмэнд хандах зарчим, тэр дундах үйл ажиллагаанд янз бүрийн амжилт алдагдал зайлшгүй хардаг бөгөөд ухаант удирдлага буюу төр засаг нь болж буй алдаа дутагдлаа ард нийтийн санал шүүмжлэлээр амжиж засаж залруулдаг нь байх бөгөөд тэдний энэхүү арга хэмжээ бол алдаанаас амжилтад хүрэх оновчтой шийдвэр мөн. Харин зарим төр засаглал нь ард түмний ашиг тусын тулд үнэнчээр зорьж хийх нь байтугай гаргаж буй алдаа дутагдлыг нь шүүмжлэн хэлэлцэгчдийг шууд буруутган тэмцэх буюу их хэлмэгдүүлэлтийн торонд хийж олон тооны зөв үзэл бодлоо дэвшүүлэгчид, тухайн нийгэм төрийн суутан мөн бөгөөд тэдний дотор зохиолч найрагч заавал ч үгүй багтдаг нь зүй билээ. Яагаад гэвэл зохиолч найрагч нар бол тухайн нийгэм төрийн хамгийн эхний фронтод зогсох ажилчид билээ. Яг иймэрхүү үйл явдлын гэгээн ба сүүдэр талаас шалтгаалан уран зохиолын хүрээнд бүдэг, далд зохиолын хэлбэр гарч

* Монголын Үндэсний Их Сургуулийн ОУХС-ийн профессор



THE CULTURAL WAY

ирсэн бөгөөд тэдний дотор илгээлт, захидал чимээ, сургаал шүлгийн хэлбэр ч маш өвөрмөц аргаар хөгжин дэлгэрсэн нь буй. Гэхдээ бүх зүйлийн зорилго нь зөвхөн улс төрийн хардлага сэрдлэгээс шалтгаалагдсан бус, зарим үзэл баримтлалыг чухалчилан ойлгуулахын тулд илгээх аргаар бичигдэн гарсан шүлэг зохиол ч олон байдаг. Аль эртний энэтхэгийн Галидас-ийн “Үүлэн зардас”, тан улсын үеийн Ли Бай, Ду Фу, Бэй Зүй, И Жинь зэрэг зохиолчдын бүтээл нь байгалийн эрхэс гарагтай хэлэлцдэг шүлэг дууллын хэлбэрүүд бүр өөр өөрийн онцлог шинжийг агуулна.

Монголын уран зохиолын эртний хөгжлөөс өнөөг хүртэл илтгэх арга хэлбэрийн бичлэг ч үе дамжин уламжлагдсаар өнөөг хүрсэн. Өгүүлэн буй сэдвийн эзэд Р.Чойном, Л.Чулуунбаатарын яруу найрагт илгээлт буюу зориулалтын бүтээл нэлээд арвин буй. 1996 онд бичиж хэвлүүлсэн “Чойном судлал жич түүний шүлгүүд” бүтээлдээ түүний уран чадварын онцлог шинжийг өгүүлэхдээ тусгайлан нэг хэсэг илгээлтийн шүлгийн талаар өгүүлсэн болно. Энэхүү төслийн ажлыг биелүүлэх явц дунд энэ хоёр найрагчийн тус тусынх нь бүтээл дээр шинэ судалгааны сэдэв болгон арав гаруй өгүүллийг туурвиж байна. Энэ дунд Р.Чойномын “Захидлын нууц” хэмээх нэгэн өгүүлэл маань хуудасны хэмжээгээр ч, үсгийн тоогоор ч нэлээд ихийг багтаан өгүүлсэн билээ. Учир нь, Чойномын захидал чимээний талаар хоёр ч тусгай ном хэвлэгдсэн бөгөөд цаашид нэн өргөн дэлгэр цар хүрээтэйгээр түүний бусдад бичсэн, бусдаас түүнд зориулан илгээсэн олон захидлын цуглуулга ном гарах гэж буй тул Чойномын захидал чимээгээр түүний тухай олон шинэ шинэ зүйлүүдийг сөхөн гаргах байх гэдэгт итгэж байна. Энэ бол Чойном судлалын бас нэгэн шинэ хуудас болох шинжтэй хэмээн үзэж байна.

Энэ удаагийн өгүүлэлдээ тэдгээрийн тухай, гол нь Дулмаа ба Чулуунбазар хоёрт зориулан бичсэн тавь шахам захидлын талаар нэлээд нарийн ажиглалт хийж, хэсэг бүлэг болгон хуваан задлалт шинжилгээ хийхийг оролдсон болно. Онцлог нь эдгээр захидлуудын ихэнхийг Р.Чойном шоронд хоригдож байхдаа бичсэн өөрийнхөө тухай, өөр бусдын тухай, бүр урлаг соёлын тухай, хүн төрөлхтний оршин тогтнолын тухай бичсэн сонирхолтой захидлууд болох юм. Энэ нь мөн Чойном тухайн үед бүтээл найргаа чөлөөтэй хэвлэн нийтэлж хүн ардаа хүргэж чадахгүй байсных нь, нөгөө талдаа тухайн цагийн хатуу чанга хараа хяналтад байсан учраас өөрийн үзэл бодлоо ил болгон илэрхийлж болохгүй байсан тул хараа хяналтаас нууж далдлан бичсэн захиануудаа өөрийн найдвартай хэмээн үзсэн үнэнч хүмүүсээр өгч явуулдаг байсан түүхтэй олон учрууд буй. Иймийн учир Р.Чойномын илгээлт шүлгийг



THE CULTURAL WAY

энд товчхон жишээгээр өгүүлье. Ерөнхийд нь “Р.Чойномын захидлын нууц”-ыг шинжих тэрхүү өгүүлэлд түүний үзэл бодлыг илүү дэлгэн тоочсон учир энд товчлон тусгай хүмүүст зориулсан хэдэн шүлгээ нь эшлэе.

Нэг. Шүлэгч найрагчийн тухай

Арван есдүгээр зууны феодалын балар үеэс

Алт торгонд хучаастай ноён хутагтын суудлаас

Атомы энэ зууны эрдэмт хүмүүсийг биширүүлэх

Аугаа үнэнийг айлдсан уужим буурал өвөг мину¹³⁴

1970.11.18

Хүндэт шүлэгчийн хөшөө рүү

Хүмүүс баяр хөөртэй очсон юм

Хар халтар зэсийн цутгамалыг

Харж хараад гунигтай буцсан юм

...

Хөшөөний бие, өнгөн талдаа

Хөсрий мэт хөх саарал

Царцуу зузаан цемент суурь

Цаг үе шиг нь нүсэр хүйтэн¹³⁵

...

1979.3.31

Анх төрөхдөө чи охин хүүхдээс томгүй төрж

Амьдрахдаа олон түмнээс илүүгүй явж

Үхэхдээ харин Нацагдоржоос томоор үхлээ

Үлдээх хөшөө чинь ямархан хэмжээтэй бол доо, Гайтав минь¹³⁶

¹³⁴ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 34

¹³⁵ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 153

¹³⁶ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 154



THE CULTURAL WAY

1979.4.11

Өөрөө ухаантай байж хүний ухааныг ойлгоно

Өгөр модон дээрээс ногоон навч үл ургана

Ховдог нохойд хэсэг өл хаяваас

Хоолоо сүүлд нь алдахын тэмдэг¹³⁷

Дээр өгүүлж буй зориулалт шүлэгт нь голдуу монголын уран зохиолчдын өнгөрсөн ба орчин үеийн суут хүмүүсийн тухай шүлгүүд болно. Мөн өөрийн үеийнх нь ч багталцана. Үүнд гол нь яруу найрагчийн үнэний эрлийн төлөөнөө тэмцлийн зам мөрийг олж харах буюу тэдгээрийн харамсалтай хувь заяаны тухай эмзэглэн шимширч дурссан, түүх ба үнэний үр дүнд эцэст нь хэн нь зөв болж үнэлэгдэх тухай Д.Нацагдорж болон Ц.Гайтав хоёрын богино мөрийн дотор багтаан тоочиж буй. Хамгийн сонирхолтой нь найрагч маань нас барахаасаа 10-20 хоногийн өмнө Д.Нацагдорж болон Ц.Гайтавын тухай зориулж дуртгалын шүлгээ бичсэн байх юм. Түүнд ямар нэгэн зөн совин ч мэдрэгдэж байсан байх. Тэр мөртлөө Гайтавыг “үлдээх хөшөө чинь ямархан хэмжээтэй бол оо?” хэмээн асууж байгаа нь тухайн цаг төрийн өнгө байдал ба жинхэнэ яруу найрагчийн ард түмний дунд өнө мөнх үлдээх алдар гавьяа нь чухам аль нь үнэн байдал вэ? гэх маш хатуу асуулт тавигдаж байна. Энэ бол өнгөн талаас нь харахад нөхрийн тухай дурсамж ч юм шиг, яг үнэндээ нийгэм засгаас тулгаж асуусан хатуу асуулт болжээ. Мөн зохиолч шүлэгч болж эрвэн дэгдэж байсан сайхан цаг үе ба түүний үнэн мөн шинж, зорилгын тухай ч эргэн харж дурссан нь буй.

Эцсийн эцэст тэгээд, өөрөө өөртөө нөхөр

Эрслээд ирэх аюулд, өөрөө өөртөө үнэнч

Энэнээс бусад нь цөмөөр хуурамч байдгийг ухаарлаа

Эрх чөлөө гэдэг, хүнд биш өөрт байна

Харин ганцхан юм хэвээрээ үлдэнэ

Харанхуй шөнөөр очсон ч үүдээ яаран тайлж

Хан хорвоогийн чихэнд чимэг болгон барих

¹³⁷ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 303



THE CULTURAL WAY

*Халх шүлгээр би чинь, хэнийг ч гэсэн дийлнэ
Урьдын адил би, шүлэгтээ үнэнч явна
Үнэн бус хайрласных нь, шүлэгтэйгээ үхнэ
Уруулын тухай, сархадын тухай, хүний тухай бичнэ
Улсын тухай, засгийн тухай харин бичихгүй
Насан багын цагаас миний чиний хэлэхүй
Найраг хэмээх ээжийн нэгэн сүүгээр амилсан
Биеийн биш, сэтгэлийн ахан дүүс минь
Бишгүй их наргилаа, жинхэнэ шүлгээ бичье*

1970.11.20

*Яруу шүлгийнхээ үг үсэг бүхнийг
Явсан газрынхаа түүх сөхөм бүхнээс
Алдаа хөлс хоёрынхоо дэнчин тавьж бид
Ариухан залуу насаараа наймаалж авсан юм
Орчлонгийн ихэнх хүний сайхан зүүдэнд ч
Орж чадаагүй үгсийн яруу сайхнаар
Дуртай цагтаа бид хөл бөмбөг шиг тоглож
Дуулим хорвоод хүний ухаан үнэртсэн мөрөө үлдээж явлаа¹³⁸*

Р.Чойномын амьдралын хамгийн гол зорилго нь яруу найргийн төлөө амьдрал учир, түүний бүхийл насны үйл учрал найрал шүлэгтэйгээ маш нягт холбоотой мөн түүний шүлэг найргийн тухай зориулж бичсэн мөр бадаг цөөнгүй. Үүнийг урьдын судалгааны өгүүлэлд тусгай сэдвээр өгүүлж буй тул энд давтан нуршихгүй. Хамгийн гол нь түүний үерхэл найз андуудын хүрээ хэмжээнд урлагийнхан олон байдаг тул тэд нарынхаа тухай дурдсан зүйл олон буй. Түүний бичсэн Данзанямын том хүү Шагдарсүрэнгийн дурсгалд”, “Байрон”, “Нармандах”, “М.Гомбосүрэнд”, “Очирхуягт”, “Би”, “Миний үе”, “Шүлэг бид хоёр” зэрэг шүлэг найраглалуудад шүлэг найргийн тухай, дуу урлагийн тухай бүрэн бүтэн нэг насны замнал тэмцлээ бичин үлдээжээ. Энд цохон

¹³⁸ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 246-247



THE CULTURAL WAY

дурдууштай нэгэн зүйл “М.Гомбосүрэнд” гэх илгээлт дурсамжийн шүлгийг шаталсан хэлбэрээр бичжээ. Чойномын шүлэг найрагт шаталсан шүлгийн хэлбэр цөөн харагддаг, энд бүхийл шүлгийг яв цав шаталсан шүлгийн хэлбэрээр бичиж үлдээсэн байна. Энэ бол Чойномын 1954.7.16 Түмэнцогтын уурхайд байхдаа бичсэн анхны шүлгийн нэг нь юм байна. Тэгвэл Чойном эхэн үедээ шүлгийн шаталсан шүлгийн хэлбэрээр бичиж байсан нь тодорхой болж байна. Сүүл сүүлдээ хэлбэрийн чөлөөт байдалд эрх дураар бичих болсон юм.

Хоёр. Аав ээж ихэс дээдсийн тухай

Ренчиний Чойном энэ эх дэлхийн бүх юмсын тухай нарийн ажиглаж, тэр бүх нарийн зураглаж шүлэглэж байдаг бөгөөд нутаг орон, овоо толгод, гол ус, худаг рашаан, чулуу тосгонд хүртэл өөрийн хайр сэтгэлээ илтгэж нийт монгол нутгийн шүлэг үзэгдэл юмсыг өөрийн бие эрхтний бүрэлдэхүүн хэмээн сүжиглэн дээдэлж байдаг. Тэр дундаа хамгаас гол шүтээнээ эмэгтэй хүн буюу ээж хүн хэмээн шүлэгтээ олон бичиж үлдээсэн нь буй.

Би ээжийгээ шүтдэг

Би гагцхүү: би гэдэг дотоод ертөнцийг минь

Биеийг минь хүч чадлыг минь

Бишид итгэх итгэлийг минь бүтээсэн

Аугаа тэр уран хүнд

Амьд баримал, амьд зураг, амьд дууг бүтэээж

Бурхан багшаас ид чадлаараа давсан

Буурал үстэй бяцхан эмгэнд би сөхөрнөм¹³⁹

Р.Чойном хар багаасаа өнчин өрөөсөн өссөн учир энэ хүний амьдрал бүдгэрлийн бүх үйл дээр ээж хүн хэдий их ачааг үүрч энэ хүүгээ хүн болгосон бэ? гэдэг нь маш хэцүү, мэдээж хэрэг тэрхүү хэлмэгдүүлэлтийн хар шуурга дэгдэж хүн мал алийг нь ч амьд байхын баталгаагүй байсан үед аав нь хэлмэгдлийн манан дор дутуу насалсан билээ. “Р.Чойном хийгээд монгол эмэгтэйчүүдийн хувь заяаны тухай” өчүүхэн өгүүлэл 1996 оны 4 дүгээр хугацааны “Алтан гарди” сэтгүүлд нийтлэгдсэн тул энд бүсгүйчүүдийн тухай товч өгүүлэн үлдээе. Р.Чойном долоон настай байхдаа ааваа алдсан учир, багаасаа өнчин

¹³⁹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” I боть, ӨМСХХ 2014, х 370



THE CULTURAL WAY

өрөөсөн өсөх, бас хамаатан айлдаа өргөгдөж хэдэн жил хар ажлыг нялх багаасаа туулж үүрэглэж явсан болохоор түүнд аавын хайр даанч дутуу байжээ. Өрх гэрийн ноён нуруугаа алдсан айлын сүр сүлд ямар байсан, төр улс нь хүртэл ард иргэдийн амьдралын энгийн шаардлагыг ч хангаагүй, харин бүх нийгмээр улс төрийн хар шуурганд нэрвэгдэж байсан учир, хөдөөний ядуу тарчиг амьдралын байдалд иймэрхүү хүүхэд насны өсөлт бойжилт хатуу чанга шалгалтыг даван туулах зориг зүрхийг шаардана.

*Та харанхуйд одохдоо надад шингээж орхисон
Таны сэтгэлээр би яруу найраг сэтгэж байна
Таван настай байхдаа ад болж явсан
Таны гар шиг гараараа би уран зураг зурж байна
Аялгуу сайхан хөгжмийн утсыг ч дарж байна
Амилж босох барималын судсыг ч барьж байна
Алдрын минь зам хэчнээн ойртовч
Аав минь та хэзээ ч үзэхгүй
... Алдахгүй яах вэ дээ хүү чинь
Алхам тутамдаа алдаж явна
Асууж зөвлөмөөр юм зөндөө тааралдавч
Аяа би чинь хэнээсээ асуух билээ дээ
Хүмүүс гэдэг чинь аав минь
Хүнд хүчир амьдралдаа уцаарлан уурсаж
Хүчитний дэргэд хүчгүй нь буруутан болж
Хүрэл зуунаасаа долоон доор болжээ
Одоо миний хүү ертөнцөд мэндлэх гэж байна
Орчлонд би хүү биш, аав болох гэж байна
Олон жилийн өмнөх таныхаа замаар би ч явах байхаа
Онцын сайхныг хүүдээ хүссээр одох байхаа
... Хүүгийн минь үе минийхээс илүү болно гэж*



THE CULTURAL WAY

Хүсэн хүлээсээр орхисон чинь алдаа билээ

Хүн байгаль хоёр яс чанараа сольж

*Хүйтэн цэвдэг сэтгэл ширээний цаана дүүрчээ*¹⁴⁰

Энэ бол 20 дугаар зууны дэлхий нийтийн эмгэнэлт түүх, монгол улсын нийгмийн тогтолцоо, тусгаар тогтнолын явц яг л ингэж ЗХУ-ын шууд нөлөөлөл дор хэчнээн олон сайхан үндэстний бахархал болсон зүйлээ цөмийг алдаж явуулсан харамсалт эрин билээ. Бүх юм жам ёсны дагуу биш, хэсэг бүлэг хүмүүсийн харгис мэдлийн дор хэлмэгдүүлэл, алан хядлага, шорон хоригдлын хар хортой сэтгэлийн дор явагдаж байсны заалдлага болсон найрагчийн үнэн үгийн өчил тоочил энэ болов уу.

Гурав. Ахдаа бичсэн захидал – хот хөдөөгийн соёлын амьдралын ялгаа зөрөө

Р.Чойном төрсөн нутагтаа хайртай, төрөлх монгол нутагтаа зүрхний угаас хайртай, түүний бичиг зохиолд баларлаг хөдөөний амьдрал, үзэгдэл юмс, нуур гол, өвс ногоо, хад чулуу, хагархай аяганы хэлтэрхий, унаж боссон шороо довцог, бургас найлзуур ус нутгийнхаа бүхийл нэр нэгд нэгэнгүй шүлэг найрагтаа холбон уянгалуулж байдаг. Тэр мөртлөө хөдөөний бага насны найз нөхөд, хөөрхөн Дулмаа, хурга тугал гээд бүх зүйлийг нүдэнд үзэгдтэл зураглан бичихээр барахгүй тэдгээр амьд дүр зургууд нь бидний нүдэнд тодоос тод танил болон үлдсэн билээ. Иймээс тэрбээр хөдөө нутгийн тайван чөлөөтэй амьдралд зүрхний угаас хайртай. Хамгийн ойлгомжтой нэгэн жишээ нь шоронгоос суллагдан гарахдаа тэрээр нутагтаа нэгэн жижиг модон амбаар барьж амар жимэр айл болж амраг хань хүүхдээ тойруулан өөрөө тэдний дунд уран бүтээлээ чөлөөтэй оролдож, төлөвлөж байсан маш олон төлөвлөгөөгөө биелүүлнэ хэмээн тэмдэглэл буюу найз нартаа бичсэн захиандаа ахин дахин дурдаж байсан билээ. Гэвч амьдралын бодит хууль түүнийг ийм замаар явуулаагүй юм. Нэгэнт холбогдсон шүлэгчийн хувь заяаны эрэл хайгуул ба хараа хяналт дор тодорхой заасан газрын цэг дээр амьдарч байх шийдвэрийн дагуу тэрээр өөрөө юуг ч эрх мэдэн шийдэж чадаагүй байна. Хувь заяаны зам мөрөөр ах дүү хоёр өөр өөрийн замын дагуу зайлшгүй амьдрах болсны шалтгааныг түүний үгээр:

Хоёр жаахан амьтан чулуун тоглоом өрж сууснаа

Хоёр тийшээ шулуухан замаар салж одсон та бид хоёр

¹⁴⁰ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” II боть, ӨМСХХ 2014, х 61



THE CULTURAL WAY

Хорвоог өөр өөрийн нүдээр харж

Холдохоос эс ойртох өөр өөрийн замд үлдэв

Би орос үзгээр

Бичих шүлгийн яруу цэгийг хаяа ононо

Та япон винтотоор

Талын зээрийн амин газрыг алдалгүй ононо

Бичсэн шүлгээ нөхөддөө уншиж

Би пиво ууна

Талын зээрийг айлтайгаа хувааж

Та шөл ууна

Маргааш нь би шартана, та шартахгүй

Магад зуун жилийн хойно би дуулна, та дуулахгүй

Уулзаарай ах минь, ургийн холбоог

Урж би, цэц булаалдах гээгүй

... Таныг би дагавал

Тал нутгийн хатуу амьдралд

Эр биеийн эн татаж

Эхний өвөл хуга хөлдөнө

Өөрийг минь та дагавал

Өнөр хотын үймээнд хөл алдаж

Амтат цэнгэлийн дугараа хүнддэж

Анхны өглөө шартаж үхнэ

Энэ найраглалд, хэдийгээр ахдаа зориулж бичиж байгаа боловч яг үнэндээ нүүдэлчин монгол амьдралын 19 – 20 дугаар зуунд шилжин орж буй хот суурьшлын аж амьдралын тухай ялгаа зөрөөний асуудлыг дэлгэж үзүүлсэн байна. Монгол нутагт олон мянган жилийн нүүдэлчин оторчин замаар эх байгальтайгаа уян холбоотойгоор харилцан шүтэлцэн амьдарсаар ирсэн зан заншил, соёлын амьдралд гэнэтийн чанартай хувирал гарсан. ЗХУ-ын дайчилгаар дэлхий нийтээрээ нийгэм журамт



THE CULTURAL WAY

социалист тогтолцоог туршин мөрдөж ихэнх улс орнуудад сорилын чанар бүхий хот суурин, аж үйлдвэрийн том бүтээн байгуулалт болж буйн дунд монгол улс өөрийн эрхгүй хамрагдан орсон бөгөөд яг л Чойном, ах Төмөрбат хоёрын амьдралын бодит үзэгдэл мэт зүйл болж байв. Энэ нь нэг талаараа баларлаг хөдөөний амьдралын тайван амгалан амьдралын хэлбэр маяг болон нөгөө талаар хот суурин, бүтээн байгуулалтын шинэ соёлын уур амьсгалын зөрчил мөргөлдөөнийг ч гүйцэд харуулсан цаг үе болж билээ. Найраглалын зураглал нь хэдийгээр маш энгийн тоочилт хүүрнэлийн шинжтэй боловч түүний үг үсэг тутамд шинэ хуучин, хот хөдөөгийн амьдралын илэн далангүй зөрчлийг нэгд нэгэнгүй өгүүлж буй. Ах нь тэсвэр тэвчээртэйгээр хөдөөний айл хөрштэй амар жимэр амьдралын зам мөрийг хөөж байхад хотын борхон хүү болсон Чойном нь яруу найрагч хүний үнэн ёсны эрэл хайгуулын төлөө эцэж цуцашгүй, өөрөө аль байгаа зүйлээрээ золиослон тэмцэж явахын ялгаа зөрөө нь хэдий их вэ гэдгийг ч харуулж байна. Энэ байдлаар яруу найрагч гэдэг үнэн мөний эрлийн төлөө өөрийгөө зайлшгүй золиослогч бурхны элч мөн гэдэг нь зүйтэй дүгнэлт мөн ажээ.

Дөрөв. Охид хүүхдийнхээ тухай

Р.Чойномын зохиол бүтээлийн нэгэн их ертөнц бол бүсгүйчүүдийн сэдэв билээ. Энэ тухай тусдаа өгүүлэл бичсэн тул энд давтах чухалгүй. Тэрээр гурван бүсгүйтэй суусан түүх буй. Тэдгээрээс гурван охин нь өнөө болтол байгаа. Харамсалтай нь гэр бүлийн амьдралууд нь удаагүй, хоёр жил ч бололгүй салцгаасан билээ. Хэдийгээр хадам энэ тэрээс шалтгаан, Чойномын өөрийн үзэл бодлоос ч хамаарсан зүйл байх нь ч буй. Тэр охин хүүхдийнхээ хажууд удаан байж чадалгүй салсан учир тэдэндээ маш их харамсал, буруугаа тоочиж хэд хэдэн шүлэгтээ тодорхой өгүүлжээ. Тэрбээр зөвхөн охиддоо зориулж шүлэглэж байсан бус, бүрэн бүтэн ирэх зууны үр хойчдоо зориулж “Хорин нэгдүгээр зуун та” найраглалаа бичиж ирэх маргаашийн аж амьдрал, үндэстэн угсаатны өрнөл мэндэл, монголчуудын ирээдүйн тухай олон арвин санаа бодлоо дэлгэн тоочсон байдаг. Тэрбээр их зөнч мэргэн үзэл бодлыг агуулж хожмын өдөр хэрхэн амьдарч тэмцэх тухай ч маш нарийн зөвлөж заасан мөр бадгууд цөөнгүй байдаг. Энэ бол хүний амьдрах ёсны үнэн сэтгэлийн сургаал захиас бөгөөд зайлшгүй дайрч гарах бага залуу насны үеийнхний үйл учрал мөн бөгөөд түүнийг хэрхэн туулж гарах, тулж уулзах, тууштай шийдэх тухайгаа ч өөрийн үзэл бодлоор хэлж сургажээ. Яруу найрагчийн үүрэг хариуцлага бол үнэн мөн зүйлийг олж ухааран мэдэхээр барахгүй ирээдүй хойчдоо үнэн зөвөөр нь тушаан өгч тэднийг ухааруулан гэгээрүүлэх ёстой гэдгээ биелүүлж өгч байхын шинж бүлгээ.



THE CULTURAL WAY

Энэ зууныхаа гучин зургаан онд би мэндэлсэн юм
Эхний тань он гарахад би жаран дөрөвтэй байна
Би байхгүй ч байж магадгүй
Битгий та гайх
Биеийн минь амьд хэлтэрхий миний хоёр охин очно
Миний хоёр охин
Цалгих залуу насандаа би
Цагийн зүүтэй уралдан бүтээсэн
Цалин мөнгөн өргөө шиг шүлгүүдийн минь
Цагаан зандан хоёр багана нь билээ
Миний хоёр охин
Нар болсон намайгаа тойрон
Тэмцэж чадсан ард түмний нэгэн эс
Нараа тойрон
Тэнхлэгээ эргэх бөмбөрцөг минь
Хорвоог багтаасан хайр сэтгэлийн
Хоёр туйл минь билээ
Миний хоёр охин
Аугаа их үнэн хаана байвч
Аргамжаатай юм шиг дэргэд нь явах
Алтан гадас одны дагуул
Хоёр шарга хэмээх
Хурмастын ихэр одон билээ
Миний хоёр охин
Морин хуурын хоёр хялгас шиг
Монгол эх орныхоо тухай бичсэн



THE CULTURAL WAY

Холцорхон залуу найраглалуудын минь
Хоёр чавхдас билээ
Миний хоёр охин
Хорин нэгдүгээр зуунд алхаж хүрэх
Хоёр хөл минь билээ
Хорин нэгдүгээр зуунд хадаг барин золгох
Хоёр гар минь билээ
Миний хоёр охин
Би өөрөө билээ

...
Хорин нэгдүгээр зуун таны өнгөн дээр
Хорвоогийн юм бүхэн
Урагшлан хөгжих болно
Урьд үзэгдээгүй ихээр хөгжих болно
Тэр цагт яруу найраг бас
Урагшлан хөгжих гэж
Хорин нэгдүгээр зуун таны нэр дээр хөгжих
Хорин нэгдүгээр зууны босгон дээр тулаад
Би шүлгээ зогсоё
Бичих шүлгийнхээ уурхай
Биет нөөц хүдэр болсон
Өөрийнхөө үеийг явуулъя
Хорин нэгдүгээр зуун
*Та мэдтүгэй!*¹⁴¹

1968.1-3 сар

¹⁴¹ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” II боть, ӨМСХХ 2014, х 304-307



THE CULTURAL WAY

Энэхүү найраглал нь зуунаас зуун дамжсан дэлхий нийтийн түүхийг хайртай хоёр охиноороо төлөөлүүлэн хүргүүлж байхын нэгэн шинж бөгөөд мөн 20 дугаар зууны их хилэнцэт түүхийг ч гэсэн нуулгүй өчиж өгсөн мөр бадгууд буй. Ер нь хүн төрөлхтний амьдрал тэмцлийн түүх бол олж алдахын жинлүүр дээр хэмжигдэн төөрч будилсан нь ихтэй ч үнэн мөний эш зүйг олж мэдэрсэн ухаарал сэхээрлийн явц юм болов уу. Дэлхий нийтээрээ бид энэ их энэрэл хайраар дүүрэн замбуулин хорвоогоо үнэн сэтгэлийн угаасаа хайрлан хамгаалах нь цаашдын зуу зуун жилийн үргэлжлэл маань энх амгалан сайн сайхан байхын бэлгэдэл байж таарна. Тиймийн учир яруу найрагчдын унтах нойр, идэх хоолоо үл хайхран бясалган бодуулж ухааруулахын тулд дандаа эмзэглэн шаналж, уйдан ганцаарддаг байсан байх хэмээн өөрийн эрхгүй бодогдуулна. Түүхэн хугацаа үргэлжлэн хөгжинө, цаг хугацааны урт аянд хүмүүс байнгын сайн сайхныг эрэн хайж түүний төлөө бүхийл эрмэлзлээ тавьдаг ч гэсэн тийм шууд шулуун замаар хөгжиж байсан нь үгүй. Заавал ч үгүй ямар нэгэн цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан алддаг алдаа байнга гардаг бөгөөд засан авч чадахгүй хожим сүүлд нь амаа барьдаг учир олон байдаг. Заримдаа хүмүүс хоорондын эе эвийг эвдсэн бодлогуудаас шалтгаалдаг зүйл байсан нь үнэн юм.

Тэмцлийн сэлэм шиг ид насандаа би

Тэрэгний морь шиг мөрөөрөө гэлдэрч

Нутгархаг үзэл, эрдэмгүй бүдүүлгийн өмнө

Нуруу бөхийж өнгөрсөн би муу эр

Хэлгийчүүд бага ястны халдварт өвчин шиг

Хэвлэл, радио, сургуулийг гутааж

Үсэг бичгийнхээ мянган жилийн их соёлыг

Үгүйсгэж байхад тэмцэж чадаагүй би муу эр

Уянгат хөгжмийн оронд эстрад ханиалга халдаж байхад

Уран зургийн оронд эрээн шавардлага дэлгэрч байхад

Утга зохиол ганц хэвийн номлол болж байхад

Ус балгасандаа дуугүй явсан би муу эр хүн

Ийм эрчүүд миний үед их л байлаа, охин минь

Ирээдүй танаа үүний учир ичиж байна



THE CULTURAL WAY

Миний бие

Миний үе

Тэгэвч юм мэдэхгүйдээ ингэж дуугүй байсан юм биш ээ

Тэвчээр минь алдсан цагаа алдсан юм

Зэвсэг онилж хил өнгөрсөн дайсандаа дийлддэггүй

Зэрэгцэн сууж хундага өргөсөн дампууралдаа бид дийлэгдсэн юм

Хүн төрөлхтний ядуурал тэмцлийн их сургууль

Хөрөнгөт нийгмийг алгассан минь гай, нэн дампуурал

Магадгүй та нартай цуг бас хэлгий хийсээр боловч

*Майлах мэт дуулж ёолох мэт бүжиглэж байхыг хэн байг гэх вэ дээ*¹⁴²

Энэ бол ууган охин Эрдэнэномдоо бичсэн захиа билээ. Энэ зөвхөн охиндоо бичиж байгаа боловч түг түмэн охид хүүхдүүдэд захин хэлж буй эцгийн үеийн алдаа дутагдал юм. Энэ дутагдлыг зөвхөн зэрэгцэж суусан хэдэн нөхдөөс болж алдаагүй нь үнэн, их бага үндэстэн ястны хоорондох зайлшгүй буй болох ашиг хонжооны асуудал үүн дотор буй. Яг эцгийн энэ үед ийм зүйл болсон бөгөөд үүний эсрэг хэчнээн олон суут ухаантан босон тэмцэж хэлмэгдэн унаж байсныг түүх гэрчилнэ. Р.Чойном мөн өөрийн отгон охин Хуландаа зориулж “Охиндоо үлдээх захидал” найраглалдаа:

Яаж ч чи гоёж гангаллаа гэсэн

Яс угсаагаа далдартал гоёод хэрэггүй

Ямар ч ном, олон хэл сурлаа гэвч

Яруу сайхан монгол хэлээ мартаж болохгүй

Энэ хэлээр аав чинь

Эхнийхээ шүлгийг хэлсэн юм

Энэ л хэлээр аав чинь бас

Эцсийн шүлгээ хэлхэж болно

¹⁴² Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” II боть, ӨМСХХ 2014, х 399



...

Гарцаагүй сайн сурах ёстой

Гажиг бүхэнтэй нь тэмцэх ёстой

Ганцхан үүнийг чамаас хүснэ

*Газар доороос ч гэсэн хүссээр байх болно*¹⁴³ хэмээн шүлэглэжээ. Түүнийхээр бол ямарваа зүйлд маш нарийн чимхлүүр хандах хэрэгтэй. Яг эцэст нь хүртлээ сайн ойлгохгүй юм бол ерөөс түүнийг сурсан ч хэрэг алга, дутуу турьхан зүйл хүнийг дандаа ялагдалд учруулдаг хэмээн сургасан бөгөөд үндэстэн ястны үг хэл үсэг бичгийг өөрийнхөө нүдний цөцгий мэт хайрлан хамгаалаарай гэсэн анхааруулан захисан байна. Тиймийн учир өнөөдрийн Чойномын хүүхэд үеийнхэн бүгд энэхүү сургаалыг машид хичээн сурч уламжлан дэлгэрүүлж явах нь зүй ёсны хэмээн бодох учиртай билээ. Үе дамжин сургаал хүмүүжил үлдээнэ гэдэг нэг талаар монголчуудын эрт дээдсээс уламжлан ирсэн “гэрийн сургаал”-ын маш чухал нэгэн хичээл мөн бөгөөд нөгөө талдаа өөрийн чинь үе дахиад ирээдүй хойч үедээ өөрийн цаг үеийн ололт алдааны талаар ч нарийн гүнзгий сургаал захиас болгон үлдээж өгөх нь зөвхөн монголчуудын ч биш дэлхий нийтийн хүн төрөлхтний уламжлалт сургаал хөгжил мөн байх учиртай юм.

МУСГЗ, АУЗ яруу найрагч Б.Лхагвасүрэн гуай: “Ертөнцийн соёлыг эрт мэдэрсэн, хол харж холоос уншиж, бие сэтгэлээ гэрэлтүүлж чадсан нэгэн байсан ...” гэж Л.Чулуунбаатарын бүрэн зохиолын оршилд бичиж өнгөрчээ. Энэ бол түүний яруу найрагч Чулуунбаатарын ур авьяасын тухай чин сэтгэлийн үнэлэлт бөгөөд түүний ур чадварыг онож хэлсэн гайхалтай үг болой. Л.Чулуунбаатар найрагч нь хэдийгээр маш богино цаг хугацаанд зохион туурвиж явсан боловч түүний үлдээж өгсөн нандин өв хөрөнгөөс нь ард олонд бодууштай, сэтгүүштэй олон зүйл үлдээжээ. Түүний бичсэн шүлэг найраг бүрт нь өөр өөр өнгө аяс тодрох бөгөөд заавал онож хэлэх гэсэн санаагаа олон талаас нь гэрэл таттал нь нотлон ярьдагт буй. Дээр бид нэлээд хэдэн төлөөлөгч бүтээлүүдийг нь сонирхон задлан тайлахдаа хэд хэдэн шүлгийн санааг нь нэлээд дэлгэрэнгүй хүүрнэж үзлээ. Энд түүний илгээлтийн буюу зориулалтын шүлэг бүхий хэдэн шүлгээс нь эшлэж Р.Чойномын шүлэг найргийн утга сэдэвтэй адилсах тал ажиглагдана.

Тав. Аав ээж нутаг усны тухай уянга

¹⁴³ Б.Дамдинсүрэн. “Р.Чойномын шүлэг зохиолын хураангуй” II боть, ӨМСХХ 2014, х 241



THE CULTURAL WAY

Төрсөн газар нутаг, угаасан рашаан усны тухай ямар ч найрагч уянга найргаа бичиж баяр талархлаа илэрхийлдэг нь тэдний хамтын нэгэн онцлог шинж мөн. Амь насны анхны бүрдэл буюу энэ дэлхийд хүний тавилангаар заяагдан төрснөө хэн бүхэн маш олзуурхан бахархдаг. Тэр мөртлөө ээжийн алтан хэвлий, эх нутгийн зөөлөн шороогоо өөрийн амь насны анхны өртөө буудал болгон уянгалан шүлэглэдэг. Тэгээд ээж аав, нутаг нуга, ус гол, овоо толгод, өвс ногоо, таван хошуу мал зэрэг зүйлсээр дамжин дэлхийтэй танилцдаг анхны дүр дүрслэл зайлшгүй бадаг мөрт нь шингэн уусдаг байна. Л.Чулуунбаатар “Ав хан” шүлэгтээ:

Онгон буурал үртэст минь

Ийм нэртэй овоо буй

Одоо би түүнийгээ

Ээж шиг ээ санах юм¹⁴⁴ гэх буюу “Гандарьт өргөх дуу” шүлэгтээ:

Алтан гандарь аа зүглэн өлгийтэй

Аавын хүү энэ нутгаас

Эр болж төрдөг

Алтан гандарь аа зөөлөн нуруутай

Адуун унаа энэ орноос хүлэг болж өсдөг¹⁴⁵ хэмээн төрсөн нутгийнхаа эрч хүч, энерги сайтай орон бөгөөд энэ нутгаас төрж гарсан хүн, хүлэг нь маш идэрхэн эчнээ холыг зорьсон хүсэл мөрөөдөл ихтэй амь ахуйг бүрэлдүүлдэг гэж дам илтгэж байна. Түүний нутаг орон, аав ээжийн тухай мөчлөгүүд дан ганц нэгэн зүйл дээр тогтдог бус, дандаа нутаг ус хүн ардын органик уялдаа холбоон дээр нэгдэн ууссан санаа ахуйг зураглал гарна.

Саалийн зэлээс

Нисэн ирдэг

Ээжийн өгсөн

Дугтуй захиаг

Шүтэн хүргэгчийн

¹⁴⁴ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, х 54

¹⁴⁵ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, х 51



THE CULTURAL WAY

Ногоон богцоос

Гүйгээд гүйгээд

Тусдаг шиг

Сайхан соёлын

Дархан мөрөөр

Санаа цайлган

Нөхөдтэйгээ

Шамдан шамдан

Хөөж билээ

Шалгаад шалгаад

*Сурч билээ*¹⁴⁶

Л.Чулуунбаатарын шүлгийг уншиж байхад уран зураг сонирхох буюу тайзны жүжиг үзэж буй мэт бодол төрнө. Түүний шүлэгт дүр зураг маш амьдлаг илэрч байдаг бөгөөд Р.Чойномын бор зураглалын хүүрнэлтэй ижилсэх бөгөөд монгол шүлгийн дотор амьд дүрүүд шуун босгож бас нэгэн оролдлого болж онцлогддог. “Монгол ээжийн хүү” шүлэг бол монгол улсын шүлэг найраглалаас маш сайн сурч байсан нэгэн жишээ бөгөөд энэ шүлгийн төгсгөлийн хэсэг нь их Нацагдоржийн “Алс газар сурахаас явагч” шүлэгтэй өнгөн нэгэн болж харагддаг. Энэ бол түүний шүлгийн нөлөө судлалтай холбогдох маш тодорхой нэгэн жишээ шүлэг болно. Аавын тухай түүний хэдэн шүлэг буй. Тэр арваад насандаа аавыгаа хар шуурганы улмаас алдсан учир аавын тухай дуртгал нь дандаа сэтгэл гонсойлгосон, үгүйлсэн санаа илэрч байдаг. “Миний аав архинд дуртай юм”, “Амьдралд би өргүй байна”, “Арван оны дуртгал”, “Урьд шөнийн зүүд” зэрэг шүлгүүдэд цагийн өнгө, тайван бус амьдралын дүр зураг, үнэн ёсноос гажсан доголдол үйл учрын тухай маш эмзэглэн бичсэн нь буй. Цаг үеийн уршиг алдаа, зүй бус үйл ажиллагааны тухай нэгд нэгэнгүй тоочин нээсэн зүйл алга гэвч энэлэл шаналалыг буй болгосон буруу зам үйлийн тухай уурлан хилэгнэж буй санаа ахуй нь илхэн харагддаг. Ерөөс түүний шүлгийн ээж аавын тухай дуртгал гэдэг нь нутаг нугын тухай дурсамж мөрөөдөл ба бахархлын санаа ахуй, нөгөө талдаа цаг төрийн үймээнт үеийн тухай шүүмжлэлийн

¹⁴⁶ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, x 22



THE CULTURAL WAY

санаа тодхон агуулагдаж байдаг. Р.Чойном ч гэсэн долоохон насандаа аавыгаа хэлмэгдүүллийн гарт алдан өнчирсөн учраас түүний аавын тухай дурсамжийн шүлгүүд нь мөн адилхан нээсэн, асуусан үл нэгдэх санаагаар цаг үеийн алдааг зэмлэн шүүмжилсэн шүлгийг олон бичсэн байдаг. Энэ хоёрын бага насны өсөн торнитл бол яг нийгмийн гаж буруу ноёрхож байсан цаг эрин болж байсан тул өнчрөл ганцаардлын уянга энэхүү сэдэвт илүүтэй ажиглагдана.

Зургаа. Урлаг гэгч юу вэ?

Л.Чулуунбаатарын зохиол бүтээлд шүлэг ба шүлэгч, урлаг ба уран сайханчийн тухай тусгай зориулсан шүлгийн нэлээд буй.

- Босож чадахгүй болтол нойр алдвал сая бусдаар уншуулах тийм шүлгийг бичиж чадна.

- Болжмор мярайсан муурыг санаж байна уу, тэр муур гэдэг нь шүлэгч байх юм, болжмор нь сэрэл байлтай, биеэ атируулан хурааж байгаад чавганы чулуу шиг дайрч үсэрсэн муур, болжморыг нисэж завдахаас нь өмнө байж амждаг билээ, энэ нь яг хэлбийж өнгөрөх сэрлийг шүлэгч хүн гэнэт барьж авсантай адилхан.

- Шүлгийн дүрийг олон таван юм бодож, тал талаас нь босгох хэрэгтэй.

- Шүлэгч өнөөгийн амьдралыг бичих боловч ихэнхдээ маргаашийн төлвөөс нааш нь харж бичдэг.

- ... Шүлэг бүхэн бүр асуулт байж болно, харин хариулт байж болохгүй.

- Шинжлэх ухаан, шүлэгч хоёр эгээ адилхан үүрэгтэй.

- Үндэстний онцлог гэдэг нь хонь, ямаа, хоргол, аргалд байх биш, харин хүний оюун санаанд буй, ур чадалд буй.

- Хүнд ойлгогдох юм гээд бид шүлгээ холбоо болгоод бичиж болохгүй, хүнд ойлгуулах юм гээд бид шүлгийнхээ уран санаа, далд утгыг ойшоохгүй байж болохгүй, хүнд ойлгуулах юм гээд шүлгийн уран дүр бүтээхээс залхуурч болохгүй, уншигчийг басаж үл болно.

- Тэнгэрийн солонго долоон өнгөтэй, талын цэцэг далан өнгөтэй, шүлэг ч ийм. Олон янзын хэлбэр төрхтэй, олон янзын хэв маягтай, өөр өөрийн дуу хоолойтой шүлгүүдийг бичиж нийтэлбэл манай шүлгийн өнөр цэцгүүд өнгө булаалдах бус уу?



THE CULTURAL WAY

- Дуу хөгжим, яруу найруулал ба бусад урлаг нь сэдэвт нягт холбоотой ... одоогоор дууны өнгө гэдэг нь ч ёстой нэг хойд эхийн хүүхэд болж байна аа¹⁴⁷.

Энэ бол түүний дэлхийн сонгодог дээж бичгээс суралцаж олзуурхан авсан сургамж юм. “Яруу найргийн тухай гүйлгэн бодол” хэмээх гучин нэгэн хэсэг ойлголтдоо тэрээр яруу найргийн тухай маш олон зүйлийг сурч, сэрж мэдсэнээ хуваалцан ярьжээ. 20 дугаар зууны 80-аад он бол манай үеийн урлаг, уран зохиолын тухай хамгийн хөгжөөнтэй, аархалтай, баяр баясгалантай үе байсан гэж бодогдоно. Бид тэр үед уран зохиол, яруу найргийн тухай маш олон шинэ зүйлийг мэдэж эхэлсэн, гадаадын урлагийн гоо сайхны үзэл, гүн ухаанч бодрол шинжийн зүйлсийг чөлөөтэй амтархан уншиж болох болсон гэгээрлийн үе байсан гэж хэлж болно. Энэ үеэр манай уран зохиол урлагийн тухай хүмүүсийн үйл ажиллагаа эрс шинэ уур амьсгалтай болж, хүмүүсийн аливаад хандах хандлага үзэл хийгээд өөрчлөгдөн хувирч уран бүтээлийн оролдлого ч олон янзын хөг аясад шилжин орж билээ. Юу гэвэл, өнгөрсөн зуунаас өнөөг хүртэл урлаг, уран зураг, дуу хөгжим, баримал сийлбэр, уран зохиолын тухай хэзээч болж байгаагүй шинэ агаар тэр үед бүрэлдэж бид шүлэг найраг бичих гэж хорхойсож, хаана ямар сэтгүүл сонин дээр хэн гэдэг хүний шүлэг найраг, өгүүллэг тууж уран сайхнаар бичигдсэн байна хэмээн өөр хоорондоо захиа чимээгээр ч болов нэвтрэлцэж, шагшин магтаж шүүмжилж байсан халуун яриатай үе байжээ. Одоо бодоход бид гадаад дотоод, эрт эдүгээгийн уран зохиолын тухай цоо шинээр ярьж эрж хайж байсан үе билээ. Ийм үеэр олон сайхан найрагч мэндэлж гарсны нэг нь Л.Чулуунбаатар өөрөө байж таарна. Тэр бас олон шүлэг урлаач найз нөхөддөө зориулж шүлэг бичиж, тухайн үеийн найз нөхдийнхөө амжилт буюу урлаг дуу яруу найргийн ур чадварын хөгжлийн тухай өөрийнхөө үзэл бодлоо дэлгэж байжээ.

Баатар хүнд сэлэм байдаг

Түүнийгээ нааш, надад

Баатар хүнд цөс байдаг

*Түүнийгээ нааш, бидэнд*¹⁴⁸

Энэ бол дугуйлангийн хөдөлгөөний ахлагч Өлзийжаргал гуайн мэндэлсэн 115 жилийн ойд зориулан бичсэн шүлэг болно. Мэдээж тус

¹⁴⁷ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть II, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, x 392-400

¹⁴⁸ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, x 255



THE CULTURAL WAY

шүлэгт нэг нутгийнхаа газар шороогоо хамгаалах тэмцэл жич нутгийн атга шороо, дусал усаа өөрийн амь шиг ээ хайрласан үзэл бодлын магтуу болно. “Бетховен” хэмээх шүлэгийн тухай нэгэнт дээр тусгай өгүүлэл бичиж монгол шүлэг хөгжмийн нэгдлийн тухай нарийн дурсаж ярьсан учир энд давтахгүй.

Санааны үзүүрт сараа дайсан

Сайхан цагаан тайгын шөнө

Хүлээн авагч чиний дууг

Хөх хотоос хүргэн ирлээ

Дуулах увдисыг чинь гайхан бахархаад

Баярлаж байна, анд чинь би

Дууг чинь сонсоод баярлахдаа

Бардаж байна, алсад би¹⁴⁹

Дуучин Л.Лхасүрэнд зориулан бичсэн энэхүү шүлэг монгол дууны минь гайхамшиг, дуу хөгжмийн аугаа том хүч чадлыг хүмүүсийн ой тойнд чээжлүүлэм сайхан бичжээ. Үүнд үндэстний шинж, урлагийн шинж тэрбээр зогсохгүй монгол нутгийн уужим сургаал, өндөр сүрлэг байгалийн баян бардам байдал ба хүн ардын бодол сэтгэлгээний уужуу тайван байдал нь дэлхийн өөр хаана ч байж боломгүй эрхэм нандин онцгой нутаг хүний нэгдлийг бахархан дуулсан дуулал болж байна. Түүний бичсэн “Шуурган эгшиг” шүлэгт монголчуудын морин хуур хөгжмийн гайхалтай сайхан домог ба үнэн бодит амьдралын зураглал нь ч маш сайн шүлэг болж чадсан билээ. Соёл боловсрол, сурган хүмүүжлийн сайн сайхан ач тус ба соёл соён гэгээрүүлэгч багш нарынхаа амин хувийн биш үзлээр нийт хойч үеийнхнийхээ бүхийл сурган хүмүүжүүлсэн ач гавьяаг “Эрлийн дуунил” шүлгээрээ багш Далантайдаа баярлаж талархан бичсэн нь буй. Энд багш хүний бусдын төлөө асаж үрэгдсэн лааны гэрэл шиг ач энэрлийг бодол бодролын шинжээр уянгалуулан бичжээ. Шүлгийн эрэл хайгуул, шинэ сураг чимээний дохио занги, эчнээ холыг гүнзгий бодон тунгааж хүмүүсийн хүсэл мөрөөдлийн шинж болохуйц яруу шүлгүүдийг туурвих ухааныг “Ноломсаран танаа” шүлэгтээ амьд хөрөг зургийн шинж байдлаар дүрслэн үзүүлсэн байна. Ноломсаран бол 80-аад оны шүлэг бүтээлтийн нэгэн онцгой тал байсан бөгөөд харь гадаад онцгойлон энэтхэгийн шүлгийн өвөг Тегур олон

¹⁴⁹ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, x 236



THE CULTURAL WAY

арвин шүлгийг монгол хэлнээ орчуулан буулгаж бичсэн сайхан шүлэгтэй байдаг билээ. Мөн “Алтан харгуй” шүлэгтээ шинэ шүлгийн эрэл хайгуулын төлөө цуцаж шантрашгүй зүтгэх явахын тухай Т.Сэцэн найрагчид зориулан хэлсэн захисан санаанууд нь буй.

Хайрын сүүдэр

Хилэн мөн

Шүлгийн сүүдэр

Хэлбэр мөн¹⁵⁰ гэдэг шүлэг буюу “Шүлэгч”, “Богино мөрт шүлэг”, “Шүлэг бичдэг нь олон ч шүлгээ бясалган боддог нь цөөн байлаа”, “Яргуйг бидэнд үлдээгч”, “Нууц товчоон”, “Урлагч гэгч юу вэ?” зэрэг шүлгүүддээ тухайн цаг үеийн шүлгийн шинэчлэлийн гал аян дунд зарим өнгөрөх хэлбэрийг хүссэн, үгийн ур дарх муудсан, байнга нойрсох болгон ярьдаг шүлгийн хэдэн тогтсон хэл, нэг нэгийгээ дууриан бичигч, чанар муутай ч чадалтай олон сэтгэл дээр дандаа нийтлүүлж байдаг улиг болсон шүлгүүдийн тухай зад шүүмжлэн хэлж байсан бөгөөд ерөөсөө хэдэн сонин сэтгүүлийг өмчирхөн эзэгнэгч хэдэн хүмүүсийн гарын үсгээр зөвшөөрөгддөг шүлэг найраглалын хар бараан талуудыг ч гэсэн илэрхий шүүмжлэн няцааж урлаг, уран зохиол, яруу тансаг найргийн үнэ цэнэ, өөрчлөлт шинэчлэлтийн тухай бодлуудаа үргэлж багтаан тоочиж байсан нь тод ажиглагдана. Ренчиний Чойном, Л.Чулуунбаатар ч гэсэн амьд ахуй насандаа өөрийнхөө нэртэй төлөөлөх бүтээлүүдээ ерөөс хэвлүүлж чадаагүй, хавчигдах, нүд үзүүрлэгдэх, хэвлэж өгөхгүйн харгислалыг адил эдэлж байгаад нас барсныхаа хойно сая сайн сайхан бүтээлүүд нь ар араасаа нийтлэгдэж хүмүүсийн анхааралд хүрч өнөөдрийн хэмжээнд тусгай судлагдахуун болж чадсан учир энэ болой.

¹⁵⁰ Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014, x 197-198



THE CULTURAL WAY

ДҮГНЭЛТ

20 дугаар зууны монголын яруу найргийн хөгжлийн үе нь 1960-80-аад оны үеийн хөгжилтэй маш нягт холбоотой юм. Хүмүүсийн үзэл сэтгэлгээ, ертөнц дэлхийг үзэх үзэл, амьдралын тухай бодлогошрол, үндэстэн ястны хөгжил бадралын төлөөний сэтгэлгээ, үндэстний соёл түүх, урлаг уран бүтээл, нутаг нугын зураглал хийгээд түүнтэйгээ холбогдож буй хүн ардын амьдрал тэмцлийн хувь заяаны тухай сэтгэгдэл мөрөөдлийг говь нутгийн ар өвөрт амьдарч явсан хоёр найрагчийн шүлэг бүтээлүүдээс тодорхой олж уншина. Яруу найрагч болгон шүлэг бүтээлдээ хэдий өнөөдрийг харан бичиж байгаа ч тэдний үзгийн доорх амь амьжирлалын утга сэдэв нь үргэлж ирээдүй хойчсынхоо төлөө зорин тэмүүлдэг учир зөнч мэргэн санаа бодол буюу ирээдүйн тухай санаашрал мөрөөдөл байдаг ажээ. Энэ тухай тэдний зохиол бүтээлүүдийг нарийн уншиж үзвэл бүрэн төгөлдөр ойлгож ухаарах юм.

НОМ ЗҮЙ

(1) Өгүүлэл

1. Хуан Жинь. “Орчин үеийн монгол шүлгийн судлал”, докторын зэрэг хамгаалах өгүүлэл.
2. Хүүзаяа. “Монгол улсын орчин үеийн уран зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1980-1990)”, ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
3. Дүүтуул. “Өвөр Монголын уран зохиол дахь Р.Чойном үзэгдэл”, магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2015
4. Жан Рүншя. “Монгол улсын орчин үеийн утга зохиолын дундад улс дахь нөлөө судлал (1946-1979), ӨМИС-ийн магистрын зэрэг хамгаалах өгүүлэл, 2011

(2) Ном

1. С.Энхбаяр. “Утга зохиолын онол”, УБ., 2011
2. Эрдэнэхад. “Органик зохицонгуй туурвихуй ухаан”, ӨМСХХХ, 2001
3. С.Урсгал. “Монгол шүлэг зүйн түүхэн түүхэн тогтолцоо”, ӨМСХХХ, 2000
4. Баяуд Оюунбилэг. “Шинэ эриний монгол шүлгийн гоо зүй”, ӨМСХХХ, 2007
5. “Д.Нацагдорж”, ӨМАХХ, 1981
6. Н.Өлзийбат, Б.Осор, Лигдэн. “Өнөр цэцгийн 50 жил”, ӨМСХХХ, 2005
7. Буяндэгжрэх. “Монгол ард улсын утга зохиолын тойм”, ӨМСХХХ, 1988



THE CULTURAL WAY

8. Г.Буянбат. “Н.Сайнцогтын ойлбор”, ӨМАХХ, 1986
9. Б.Буянхишиг. “Ерэн есөн хар ямаа”, ӨМБХХХ, 2006
10. Б.Бүрэнбэх. “Зөн мэдрэхүй шүлэг зүй”, ӨМАХХ, 2001
11. Б.Бүрэнбэх. “Уянгын эрэлчний тэмдэглэл”, ӨМАХХ, 2001
12. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть I (Ойн дугараа), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
13. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть II (Зүүдэн цагаан туулиан), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
14. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть III (Хан сасарын үүл), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
15. Солонгод Л.Хурцбаатар, Л.Хасбаатар. “Л.Чулуунбаатарын бүрэн зохиол”, боть IV (Зүүдэнд минь хоноосой), Герман ImoFiF Elians e. V. Publisher 2014
16. Солонгод Л.Хасбаатар. “Р.Чойном, Л.Чулуунбаатар”, Герман ImoFiF Elians e. V. Publisher 2015
17. Л.Хасбаатар. “Р.Чойном судлал жич түүний шүлгүүд”, ӨМСХХХ, 1996
18. Л.Хасбаатар. “Цагийн жаварт бөхөөгүй зул”, УБ., 2009
19. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх”, I, ӨМАХХ, 1985
20. П.Хорлоо, С.Лувсанвандан, Д.Мөнх, Д.Цэнд. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэл”, ӨМСХХХ, 2004
21. Хайрхан. “Монгол шүлгийн эдүгээч хувьсалтын судлал”, ӨМАХХ, 2014
22. Хайрхан. “Өнөөгийн монгол шүлгийн ерөнхий судлал”, ӨМСХХХ, 2010
23. Хангай. “Дундад улсын орчин үеийн уран зохиолын түүх”, ӨМИСХХ, 2000
24. Ван Мандаа. “Монголын орчин үеийн уран зохиолын судлал шүүмжлэлийн хураангуй”, ӨМСХХХ, 2000
25. Т.Сайнбаяр. “Дундад улсын монгол үндэстний өнөөгийн утга зохиолын түүх”, ӨМСХХХ, 2003
26. Н.Сайшаалт. “Монгол шүлгийн айзмын судлал”, ӨМАХХ, 1981
27. Сүег. “Утга уянгын тольт”, ӨМАХХ, 1998
28. Ш.Сүрэнжав. “Сүмтэй бударын чулуу”, УБ., 1989
29. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть I, Өвөр Монголын соёлын дуу хөгжим дүрс шингээлтийн хэвлэлийн хороо, 2019



THE CULTURAL WAY

30. О.Дашбалбар. “Хүн ертөнц”, боть II, Өвөр Монголын соёлын дуу хөгжим дүрс шингээлтийн хэвлэлийн хороо, 2019
 31. Х.Дамбийжалсан. “Өвгөн хайлсны шуугиан”, ӨМАХХ, 2003
 32. Дорнотэнгэр. “Орон нутгийн түүх, иргэний хараас, соёлын уламжлал”, ӨМАХХ, 2015
 33. Л.Чулуунбаатар. “Ойн дугараа”, ӨМАХХ, 2000
 34. “Р.Чойномын амьдрал уран бүтээл”, Чойномын мэдэлсний 70 жилийг ойг тэмдэглэх эрдэм шинжилгээний хурлын бүтээл, УБ., 2006
 35. М.Жалфунгаа. “Үр өнөөгийн монгол уран зохиолын түүхэн найруулал”, ӨМСХХХ, 1987
 36. Хайрхан. “Шүлгийн ухааны тайламж”, ӨМИСХХ, 2020
 37. С.Баянжаргал. “Монгол хөгжимдхүйн бүрэн бичиг”, ӨМАХХ, 2017
 38. С.Баянжаргал. “Монгол язгуур урлаг – хөгжимдхүй дууны 365 нэрс”, ӨМАХХ, 2017
 39. Ц.Цолмон. “Их тамучийн тэнгэр”, ӨМАХХ
 40. Ц.Цолмон. “Орчлонтой яригч дорнодахины яруу найрагч”, Чэнь Ганлун, С.Урсгал. “Д.Нацагдоржийн сонгодог тайламж”, ҮнХХ, 2009
 41. 王宁: 《管或乐法基础教程》，高等教育出版社，2008 年
- (3) Сонин сэтгүүл
1. Алтангадас. “Монгол ардын аман зохиол хорь гучаад оны монгол улсын шинэ шүлгийг нөлөөлсөн нь”, БХҮИСЭШС, 1993 №3
 2. Ч.Эрдэнэбаяр. “Монголын орчин үеийн эх орон сэдэвт яруу найргийн хөгжлийн товч”, ӨМИСЭШС, 2000 №1
 3. Б.Энхтүвшин. “Их Нацагдорж – 20 дугаар зууны монголын соён гэгээрүүлэгч, их зохиолч”, Дундад улсын монгол судлал, 2007 №4
 4. Ц.Хасбаатар. “Монгол улсын шүүмж судлалын өнөөгийн байдал”, ӨМИСЭШС, 2000 №4
 5. С.Хас-Өлзий. “Б.Лхагвасүрэнгийн шүлгийн нууцлал – үйлт уран дүр”, Алтан түлхүүр, 1994 №1
 6. Лагсагмаа. “Дундад улс дахь монгол улсын орчин үеийн уран зохиолын судалгаа”, ДУМС, 2008 №5
 7. Кань Хай Ин. “Диваажингийн элчийн зөн мэдрэхүй”, ӨМИСЭШС, 2020 №1
 8. Ц.Дамдинсүрэн. “Монголын уран зохиолын товч өгүүлэл”, Монгол түүх хэл бичиг, 1958 №6
 9. Т.Дэлгэрсан. “Халхын удам нутгийн гайхамшигт зураг – миний нутаг – Д.Нацагдоржийн Миний нутаг гэх шүлгийг дахин сонирхоод”, Монгол судлал, 2009 №1

ЧИН УЛСЫН ШИНЭ ЗАСГИЙН БОДЛОГО ХЭРЭГЖИЖ ЭХЭЛСЭН НЬ

А.Ариунболд *

ХУРААНГУЙ

Нэгэн цагт дэлхийн түүхийг бичилцэж явсан Монголчууд 17-р зуун болоход хүч нөлөө нь нэгэнтээ буурч шинээр мандан гарч ирсэн Манж чин улсын эрхшээл нөлөөнд орж эхэлсэн билээ. 1636 онд Өвөр монгол, 1691 онд Халх монгол, 1758 онд Ойрд монголчууд залгаа залгаагаар Манж чин улсын харьяалалд орж эзлэгдсэн бөгөөд энэ л үеэс Манж нар Монгол газар орныг хамааран захирч, өөрийн өвөрмөц бодлогоор үе улиран захирч иржээ. Ийнхүү Монголчууд 1636 аас 1911 онд тусгаар тогтнолоо дахин олох хүртэл 275 жил Чингийн захиргаан доор явж ирсэн ба энэ түүхэн хугацаанд Монголчууд бид унаж босож, эрх чөлөөнийхөө төлөө тэмцэж байсан олон арвин түүхүүд байдаг билээ.

Түлхүүр үгс: Чин улс, шинэ засгийн бодлого, Монгол орон, Сандо амбан.

XIX зууны сүүлийн хагаст Монгол орон Манж чин улсын зах бөглүү хязгаар болж, Манжийн төр Монгол орныг гадаад ертөнцөөс тусгаарлагдмал байлгаж, хилийн халхавч болгон ашигласан хэвээр байв. Улмаар тухайн үеийн дэлхийн олон улсын байдал, тэдний явагдуулж байсан бодлогоос үүдэн Манжийн төрөөс Монголыг захирах талаар баримталж ирсэн уламжилалт бодлого өөрчлөгдсөн юм. Энэ нь 1901 оноос хэрэгжиж эхэлсэн **“Манжийн шинэ засгийн бодлого”** гэгч байлаа.

XIX зууны сүүлчээр буюу 1899-1901 оны хооронд хойд Хятадад гадаад ба дотоодын дарлагч дайснуудыг эсэргүүцсэн Ихөтуаны (**Yihetuan 义和团**) **“Шударга эв нэгдэлийн баг”** бослого гарсан бөгөөд түүнийг Англи, Япон, Америк, Герман, Франц, Хаант Орос, Итали, Австри-Унгар зэрэг найман улсын холбоот цэрэг бут цохин, 1901 онд Чин улсад дайны төлбөр хэмээн түрэмгий гэрээ тулган хүлээлгэж, 4 дүнчүүр мянган түмэн лан мөнгийг 30 жилийн дотор төлөх бөгөөд

* ШУТИС-ийн Байгалийн Ухаан Хүмүүнлэгийн Сургуулийн багш, доктор (Ph.D)



THE CULTURAL WAY

хүүтэйгээ нийлбэл 9 дүнгүүр 8000 гаруй лан мөнгөний өрөнд унагасан байдаг¹⁵¹.

Тус түүхэн үйл явдалыг бага зэрэг дэлгэрүүлэн бичвэл: Өрнөдийн гүрнүүд Чин улсын газар нутагт хүч түрэн орж ирсэн тэр цагаас эхлэн Чин улсын дээд давхрагынхан болоод энгийн иргэд гадаадын хүмүүст таагүй ханддаг байв. Тухайлбал Хятадын хот тосгодын жирийн оршин суугчдын барууны эсрэг үзэл санаа нь гол төлөв тэдний дунд ажиллаж буй Христийн шашин дэлгэрүүлэгчдийн эсрэг чигэлдэг байлаа. Энэ үед Хятадад 2000 гаруй гадаадын шашин номлогчид ажиллаж амьдарч байжээ. Зарим хуврага санаваартан нарын муйхар зан авирч тэдний байдлыг улам дордуулдаг байсан байна. Ган гачиг болон байгалын гамшиг зовлон тохиолдход уурлаж бухимдсан тариачид хур борооны бурханыг доромжилж биднийг өлсгөлөнд нэрвэгдүүлээ хэмээн тэдэнд уур хилэнгээ гаргах явдал нилээд гардаг байв. Харин шашин номлогчдын үйл ажиллагааг өрнөдийн байлдааны хөлөг онгоцууд хамгаалж байсан юм. Хэрэв шашин номлогчдын амь насанд халдсан элдэв хэрэг гарвал Чин улсад анхааруулга өгч хүн ардыг алж хядах мөн байшин барилга хот тосгодыг галдан шатааж анхааруулга өгдөг байжээ. Энэ байдал нь суларч доройтсон Чин улсад маш их дарамт шахалт болдог байлаа.

Үүний улмаас орон нутгийн албан тушаалтнууд альваа асуудлыг загалмайн шашинтнуудын зөв ч бай бурууч бай хамаагүй, гагцхүү тэдний засгийн газартай муудахгүй байх, өөрийн ахиж дэвших замыг хаахгүйн тулд ямагт тэдний талд шийдвэр гарах болно хэмээн өөр шашин мөргөлийн зарим хүн хатуу итгэдэг байжээ. Энэ байдал нь жирийн Хятад иргэдийн уур бухимдлыг хүргэн, үймээн самуун болон хувирдаг байв. Цыши хатан загалмайн шашинтан оролцсон хэрүүл тэмцлийн үед “Хэнийх нь ч талд орохгүй чиг шудрага” шийдэхийг ямагт тушаадаг байжээ. Чингийн засгийн газар загалмайн шашинтнуудын эсрэг чиглэсэн үймээн самуун дэгдэхэд хатуу ширүүн арга хэмжээ авдаг байсан бөгөөд ийм нөхцөлд хурдан шуурахй ажиллаж зохицуулаагүй, зарим тохиолдолд бүр даамжруулсан түшмэдийг шийтгэдэг байсан байна¹⁵².

¹⁵¹ Лю Цзиньсо. Монголын хураангуй түүх. Хөх хот. 1985, 320 тал.

¹⁵² Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 394 тал.



THE CULTURAL WAY

1899 оны хавар Герман улс Шандуны (**Shandong 山东**) үймээнийг эцэс болгохоор аялан байлдах цэргийн ангийг хэд хэдэн Хятад тосгон руу илгээжээ. Цэргүүд олон зуун байшин барилга шатааж, оршин суугчдыг олноор нь алсан байна. Энэхүү харгис ажиллагааны дараа Ихөтуан (**Yi he tuan 义和团**) буюу “Шудрага ёс, Эв нэгдлийн нударга”

(**Баг**) хэмээх нэрд гарсан бүлэглэл асар их нэр хүндийг олж хэдэн зуун мянган талархан дэмжигчидтэй болсон байна. Энэхүү нийгэмлэг нь улс орны хамаг муу муухай хийгээд амьдарлынхаа зовлон зүдгүүрийг гадаадынханд тохож тэднийг Хятдын нутгаас хөөн зайлуулах тангараг өргөжээ. Шандун (**Shandong 山东**) нутаг нь тулааны урлаг нилээд хөгжсөн газар бөгөөд тэрхүү нударган зодоон нь бокстой төстөй учир гадаадынхан тэднийг “**Боксерууд**” хэмээн нэрлэж байлаа. Хүмүүс янз бүрийн шалтгаанаар боксеруудтай нэгдэж байв. Тухайлбал орон гэрийг нь сүйтгэсэн Германчуудыг үзэн ядаж, зарим хүн загалмайн шашинд орсон Хятад хөрштөйгөө өс хонзонтой болсноор, нөгөө хэсэг нь хураасан ургац нь хүрэлцэхгүйн улмаас бухимдсандаа... гэх мэт шалтгаанаар элсэн орж байв. 1899 оны 12 сарын 30 өдөр боксерууд илжиг унан загалмайн шашинаа сурталчилан дэлгэрүүлж явдаг Англи номлогч С.М.Брүүкс ламыг боксеруудыг бишрэн шүтдэг тонуулчин цэргүүд барьж алсан хэрэг мандав. Мөн загалмайн шашны арваад байшин савыг сүйтгээд зогсохгүй загалмайн шүтлэгтнүүдийн 328 байшинд дайран орж, уг шашинд орсон 23 Хятад хүний амийг бүрлэгэсэн байна¹⁵³. Энэ үед Боксерууд Чин улсын Жили (**Zhi Li 直隶-одоогийн Хөбэй Hebeisheng 河北省 муж болно**) болоод Шандун (**Shandong 山东**) хоёр мужид идвэхтэй үйл ажиллагаа явагдуулж байсан юм.

Цыши хатан С.М.Брүүкс ламын амь насыг хөнөөсөн явдалд “**Гүнээ харамсан гунихарч**” байгаагаа илэрхийлээд Генерал Юань Шикайд гэмт хэрэгтнүүдийг барьж хүндээр шийтгэхийг тушаасан байна. Боксеруудын зарим нь дээрэмчин болж тонууль хийн амьдарч, Бээжинтэй (**bei jing 北京**) хил залгаа Жили (**Zhi Li 直隶-одоогийн Хөбэй Hebeisheng 河北省**) мужийг үймүүлж түйвээж байв. Иймээс 1900 оны 2 сарын 19 ний өдөр Цыши хатан Жили (**Zhi Li 直隶-одоогийн Хөбэй Hebeisheng 河北省 муж болно**) болоод Шандун

¹⁵³ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 396 тал.



THE CULTURAL WAY

(**Shandong** 山东) мужид Боксерын хөдөлгөөнийг цаазлан хориглож, бүх дээрэмчин тонуулчдыг “Хатуу шийтгэх” зарлиг буулгав. Энэ байдалд гадаадын элчин яамд сэтгэл ханасангүй. Гол төлөв Их Британи, Америк, Герман, Итали, Франц зэрэг улсууд Боксеруудыг нэг мөсөн оргүй устгах ёстой хэмээн үзэж байлаа. Чингийн төр барууны улс гүрний эсрэг өрнөсөн тэмцэл хөдөлгөөнийг хатуу гараар нухчин дарж байгаа мэтээр олон түмэнд харагдаж байсан ч яг үнэндээ гадаад гүрнүүдийн утсан хүүхэлдэй болж байгаадаа туйлаас гутарч байжээ.

Их Британы элчин ноён Клод Макдональд Чингийн төрийг Боксеруудын эсрэг доривтой арга хэмжээ авахгүй байгаад сэтгэл дундуур байгаагаа илэрхийлээд 1900 оны 4 сарын 12 ний өдөр Чингийн засгийн газарт Боксеруудыг 2 сарын хугацаанд дарах нөхцөл тавьсан байна. Ингэхгүй юм бол Английн цэрэг бусад холбоотнуудтай орж ирэн дарах ажлыг гартаа авна гэж сүрдүүлжээ. Тэгээд сүрдүүлгээ бататгаж байлдааны хөлөг онгоцуудаараа Таку бэхлэлтийн өмнө сүрт жагсаал хийлгэжээ¹⁵⁴. Үнэндээ Чин улс 1895 онд Японтой хөнөөлт дайн явуулж найрамдсаны дараа “Нэгэн жишиг загвар” тогтсон байна. Тэр нь юу бэ гэхээр “Гадаад улс гүрнүүд шаардлага тавьж, хүч хэрэглэхээр занал хийдэг”, Бээжинч тэдний хүссэнийг нь нэн дариу биелүүлдэг ийм л загвар тогтсон юм. Энэ байдалдаа тэсвэр алдсан Чин улсын төр машид хилэгнэж, гадаад гүрнүүдтэй эрэгчин эмэгчнээ үзэх гэж урьд уридынхаасаач илүү шийдвэр төгөс болоод байсан юм.

Хэрэв өрнөдийн гүрнүүдтэй дайны байдалд хүрэх юм бол Чин улсын тэнгисийн Флот нь устаж үгүй болсон, цэрэг арми нь хүч дорой, шинэ зэвсэг байхгүй учир ялагдах нь тодорхой байлаа. Тэгвэл ийм нөхцөл доор Боксеруудыг ашиглан гадны халдаар ирэгчидтэй “Ардын дайн” хийж болох юм бишүү гэх төлөвлөгөө бий болсон байна. Учир нь Боксерууд бол гадны хүмүүсийг туйлаасаа үзэн яддаг болохоор эрэлхэгээр байлдах байлаа.

1900 оны хавар Шандун (**Shandong** 山东) болон Бээжингийн (**bei jing** 北京) орчим нутгаар бороо хургүйгээс болж их ган болсон байна. Иймд хийх ажилгүй болж, өлсөж үймж түгшсэн хүмүүс юу ч хийхэд бэлэн байлаа. Хүнд байдалд орсон тариачид, Боксерууд Бээжин руу бөөн бөөнөөрөө очиж, гудамж талбайгаар хэдэн арван мянгаараа нөмрөн орж

¹⁵⁴ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 398 тал.



THE CULTURAL WAY

иржээ. Тэд толгойдоо улаан алчуур зүүж, улаан цамц өмсөж, өргөн бүс зүүгээд урт хутга болон сэлэмээ эргүүлэн явж байжээ¹⁵⁵. Боксерууд “**Гурван сарын дотор гадаадынхныг бүгдийг нь хүйс тэмтрэхийг**” уриалсан зурагт хуудсаа Бээжингийн гудамжуудаар наасан байв. 1900 оны 5 сарын 31 нд Цыши хатан гадаадын элчин яамдыг хамгаалуулахаар Тяньжин хотоос өрнөдийн 400 цэргийг нийслэл Бээжинд (**bei jing 北京**) оруулах зөвшөөрсөн зарлиг гаргав. Үүнийг нь элчингүүд хангалтгүй гэж үзэж байсан тул 1900 оны 6 сарын 10 нд Чингийн нутагт байрлаж байсан Британийн тэнгсийн цэргийн командлагч Эдвард Сэймүрийн удирдсан 2000 цэрэг Тяньжинаас 120 километрийн зайд буй Бээжин рүү төмөр замаар хөдөлсөн байна. Үүнийг зөвшөөрөгүй тул элчингүүдийг цэргээ буцаа хэмээн ятгахыг дипломатууддаа тушаажээ. Гэвч элчингүүд цэргээ татахаас татгалзсан байна. Тиймээс нилээд олон Боксеруудыг дайчлан Ангилчуудыг тосон байлдуулав. Энэхүү тэмцэл нь байдлыг хүндрүүлсэн байна. 1900 оны 6 сарын 11 нд нийслэл Бээжинг хамгаалж байсан лал сүсэгтнүүд давамгайлсан арми гудамжаар зорчиж явсан Японы элчин яамны бичиг хэргийн дарга Сугияма Акирагийн амь насыг хөнөөв. Боксерууд төмөр замын шугам, галт тэрэг, цахилгаан мэдээний холбоог эвдлэн сүйтгэж эхлэв. Мөн Бээжин дэх гадаадынхны сүм дугана, байшин барилгыг галдан шатааж, тэдний оршуулгын газрыг сүйтгэж, шарлын чулуу хөшөөг эвдлэн хэмхлэн, цогцос хүүрийг авснаас нь гарган ирж жадаар сүлбэн шатааж байв¹⁵⁶. Бүх зүйл хяналтнаас гарч бужигнаж байх хооронд барууны орнуудын байлдааны хөлөг онгоц бүхий томоохон флот Чин улсын далин эрэгт буугаад олон мянган цэрэг замдаа яваа мэдээ ирсэн байна. 1900 оны 6 сарын 16 нд Цыши хатан их зөвлөлийн гишүүд, сайдуудыг цуглуулан онцгой өргөн хэмжээний хурал зарлаж тухайн нөхцөл байдлыг ярилцжээ. Гэвч тодорхой шийдвэрт хүрч чадаагүй бололтой. Эндээс бид юуг ойлгож болох бэ? Гэхээр Чин улсын төр бүхэл шатандаа эмх замбараагүй болж, нэгдсэн удирдлага байхгүй, гаргаж байгаа шийдвэрүүд нь нэгэнт тухайн нийгмийнхээ шаардлагыг хангахгүй болсон байжээ.

Гэтэл энэхүү өдөр нь Боксерууд Бээжингийн (**bei jing 北京**) хүн ам ихэд хөлхдөг худалдааны нэгэн дүүрэгт дотоод хотын хаалганы яг дэргэд

¹⁵⁵ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Мооннцагаан) Улаанбаатар. 2015, 401 тал.

¹⁵⁶ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Мооннцагаан) Улаанбаатар. 2015, 403-404 тал.



THE CULTURAL WAY

байх барууны эм тан зардаг байсан нэгэн эмийн сан болон мөн барууны бараа худалддаг дэлгүүрийг галдаснаас болж их хэмжээний түймэр дэгдэж ховор нандин торго дурдан, үс арис, тавилга, үнэт эрдэнэс, эртний ховор эдлэл, үнэлж барашгүй Хятад гар урлалын бүтээлүүд сүйдэж, бас түүний ойр орших Алдарт Чамингийн их хаалганы цамхаг түймэрт өртсөн байна. Газраас дээш 30 метр өндөр тус хаалга нь Бээжингийн бүх хаалганаас хамгийн бахархамаар сайхан нь байв. Тэрхүү дэгдсэн түймэр нь Бээжинд (**bei jing** 北京) 200 жилд тохиогоогүй хамгийн гамшиг үзүүлсэн түймэр байжээ. Бээжинд түймэр дэгдсэн тэр шөнө нь Орос, Япон, Англи, Франц, Америк, Герман, Итали, Австри-Унгар зэрэг найман улсын хамтарсан хамтарсан цэрэг Тяньжин, Бээжин хотуудыг далайн зүгээс ирэх аюулаас хамгаалж байдаг Таку бэхлэлтийг довтлов. 6 цаг үргэлжилсэн жируун тулааны дараа Таку бэхлэлт эзлэгджээ. 1900 оны 6 сарын 20 нд Бээжид сууж байсан Германы элчин Клэмэнс фон Кэттэлэрийг Гадаад явдлын яамруу явах замд нь буудан алсан хэрэг дахин гарав. Ийнхүү Чингийн төр буцах замгүй болж, маргааш нь буюу 6 сарын 21 өдөр Цыши хатан **“Бидэнд улс орноо царан дээр тавиад харийн түрэмгийлэгчдэд барих, эсвэл эцсээ хүртэл тэмцэх хоёр л зам байна”** хэмээн хэлээд харийн бүх булаан эзлэгчдэд дайн заралжээ¹⁵⁷.

Дайн зарласны дараа Боксеруудыг хуульчилж, тэдэнд талтай ханддаг хунтайжуудын удирдлаган дор зохион байгуулалтанд оруулжээ. Нийслэл Бээжинд хунтайж Дуаны удирдлагад 250000 мянга орчим Боксер байв. Тэд тус бүр 200 хүнтэй 1400 орчим анги нэгтгэл болон зохион байгуулагдсан байна. Тэндээс 100000 мянга гаруй нь хааны байнгын армитай зэрэгцэн нийслэл Бээжин хотыг 20000 мянган хүнтэй олон улсын зэвсэгт хүчнээс хамгаалж байв. Чингийн цэрэг Тяньжин хотын дэргэд болсон тулалдаанд эрэлхэг зоригтой тулалдаж гадаадын армийг ихээхэн сандрагасан байна. Чингийн бүдүүн баараг хоцрогдсон жад, сэлэм, хутгаар зэвсгэлсэн цэргүүд өрнөдийн холбоотон цэргүүдийн орчин үеийн зэвсэг техникийн өөдөөс амь биеийг үл хайрлан тэмцэж хурдан буу, сум шүршигчийн галанд эгнээ эгнээгээрээ хяран унаж байжээ¹⁵⁸. Тус дайн 1900 оны 6 срын 20 оос 8 сарын 14 хооронд нийт 55

¹⁵⁷ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 407-409 тал.

¹⁵⁸ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 410-411 тал.



THE CULTURAL WAY

хоног үргэлжилсний эцэст холбоотон гүрүүдийн цэрэг Бээжин хотыг эзлэн авчээ. Бээжинд байсан гадаад улсуудын элчингийн хороолд барууны 68 хүн амь үрэгдэж, 159 хүн шарахдсан байна¹⁵⁹. Гэтэл хоцрогдсон зэвсэгтэй Чингийн цэргүүд болон Боксерүүд хэдэн мянгаараа амь үрэгдсэнийг хэн ч тооцоолоогүй юм.

Холбоотон гүрнүүд Бээжинг эзэлснээс хойш нэг жилийн дараа 1901 оны 9 сарын 7 нд Чин болон холбоотон гүрнүүд гарын үсэг зурснаар дайн албан ёсоор дууссан байна. Холбоотнууд Боксеруудын харгис бурангуй үйл ажиллагааны хариуцлагыг угсаа залгамжлагчын эцэг, Боксеруудыг хамгийн ихээр дэмжэн тэтгэж байсан хунтайж Дуаныг гол буруутан хэмээн үзэж алах ял заасан боловч хэрэв эзэн хаан түүнийг өөрийн гэр бүлийн хувиар өршөөвөл хэлтрүүлэх нөхцөл тавьсан байна. Ингээд хунтайжыг Шинжаан руу бүх насаар нь цөлөх ялаар шийтгэжээ. Ингээд ихэс дээдэс хийгээд сайд түшмэд нараас 6 хүнийг болон бусад олон холбогдох хүмүүсийг ямар ч нөхцөлгүйгээр цаазлах ял оноожээ. Мөн Таку бэхлэлтийг нурааж, хойшдоо гадаадынханд дайсагнагч холбоо, нийгэмлэгүүд байгуулахыг хуулиар хориглов. Дээрх гэрээ протколын бас нэг чухал зүйл нь дайны нөхөн төлбөрийн талаарх зүйл заалт Чингийн төрд хүндээр тусав. Нийт 450 сая лан болсон байна. Халдан түрэмгийлэх ажиллагаанд оролцсон бүх улсуудын шаардлага нийлээд ийм болжээ. Тэд өөрсдийн цэргийн ажиллагааны зардал хийгээд өөрсдийнх нь харияат иргэдэд учирсан хохирлыг нэмэн тооцсон байна. Ер нь бол улс орон бүр өөрийн үзэмжээр тооцож байв. Хамгийн их хэмжээний төлбөрийг Манжуур дахь төмөр зам нь дайн байлдаанд сүйдсэн Орос улс шаардав. Орос нийт төлбөрийн 29 хувийг авна хэмээн шаардав. Удаах байранд нийт төлбөрийн 20 хувийг шаардсан Герман улс оров. Түүний хойноос Франц, Их Британи улсууд орсон байна. Нийтдээ 462560614 сая лан болсныг тэгшитгэж 450 сая болгосон байдаг. Энэ дунд зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд орсон эсэхээс үл хамааран дээрэнгүй байдлаар дайны төлбөр нэхсэн улсууд байжээ. Тухайлбал: Орос:133316000 сая лан, Герман:91287043 сая лан, Франц:75779250 сая лан, Их Британи:51664029 сая лан, Япон:35552540 сая лан, Америк:34072500 сая лан, Итали: 27113927 сая лан, Бельги:8607750 сая лан, Австри-Унгар:3979520 сая лан, Нидерланд:800000 лан,

¹⁵⁹ Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Мооннцагаан) Улаанбаатар. 2015, 414 тал.



THE CULTURAL WAY

Испани:278055 лан, Швед: 110000 лан, Португали: төлбөр шаардаагүй, бүгд нийлээд: 462538116 сая лан болж байжээ¹⁶⁰.

Иймд дотоодын дайн дажин, харь улсуудын түрэмгийлэл нь Чин улсын ноёрхолыг хүчтэй ганхуулсан бөгөөд улирч хоцорсон улсаа засах уламжлалт бодлого өөрчлөх мөн гаднаас өнгөлзөх улс орнуудын түрэмгийллээс газар нутгаа хамгаалах төдийгүй өрнөдийн улсуудад төлөх дайны төлбөрийг төлж барагдуулах тулд “Шинэ төрийн”, “Шинэ засгийн” бодлогыг зайлшгүй хийж явагдуулах шаардлага гарсан байна. Ингэж Мөхлийн даваанаас мултран гарахын тулд Чин улсын хаан Ши Ань (**Xian 西安市**) хотод байхдаа 1901 оны 1 сарын 29 өдөр хуулийг өөрчлөн, “**Шинэ засгийн бодлого**” хэрэгжүүлэх дээд зарлигийг нийтлэн гаргажээ¹⁶¹. Гол утга нь “Өрнөдөөс суралцах” гэсэн үг байлаа. Үүнийг жаахан тодруулбал гадаад улсуудын давуу зүйлийг авч байж Чин улс тааруу дутагдалтай зүйлсээ засч залруулах явдал байв. Энэ удаа улс орноо өөрчлөн шинэчлэхэд бусад улс орныг баян хүчирхэг болгосон бүх зүйлийг чухалчилсан ба тэдгээрийн тоонд “Удам дамжсан хаант төр, үндэсний уламжлал, засаглах арга барил, хүмүүсийн амьжиргаа, боловсрол, цэргийн хэрэг, санхүүгийн ажил үйлийг тоочсон байв. Энэ хооронд холбоотнууд Тяньжин хотыг маш ихээр өөрчлөн шинэчлэж жишээ үзүүлсэн юм. Тус хот дундад зуунаас шууд орчин цагт дэвшсэн байна. Өрнөдийнхөн орж ирж байгаа орлого болон зарлага болгонд данс хөтлөх төдийгүй Тяньжин хотод гудамжны гэрэлтүүлэг тавьж, мөн усан хоолой, трамвай, телефон утас, хэрэглэдэг болов. Хуучны тус хотод их цэвэрлэгээ хийж, муу усны зайлуулах хоолой хүртэл тавьж өгөв. Ингээд хотын гудамжаар хөглөрч байдаг хог новш алга болжээ. Энэ дундаас хийсэн хамгийн чухал шинэчлэл нь олон нийтийн бие засах газар байгуулж өгсөн явдал болов. Бас хот дотор барууны маягийн цагдаа хот дотрох олон нийтийн хэв журам сахиулах болжээ¹⁶². Энэ мэт нүдэнд

¹⁶⁰ Н.В.Морс, The International Relations of the Chines Empire. 3-р боть, 352 тал.

¹⁶¹ Шарнууд Содбилэг. ӨМИС-ийн багш, Профессор. Чин улсын сүүлч үеийн манж, хятад сайд нарын дэвшүүлсэн монголыг засах айлтгал бичгүүдийн тухай. Proceedings of the Second International Conference. Past and Present of the Mongolic peoples, Олон улсын хоёрдугаар чуулган, Монгол туургатны эрт ба эдүүгээ, August 28-30, 2007., Ulaanbaatar, Mongolia. Edited by. Tokusu Kurebito, Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo University of Foreign Studies. 2009., 128

¹⁶² Юн чан. Цыши хатан, (Герман хэлнээс орчуулсан : Д.Моононцагаан) Улаанбаатар. 2015, 462 тал.



THE CULTURAL WAY

харагдах өөрчлөлтүүд нь Чин улсын дээдэс төдийгүй эгэл жирийн ардуудад өрнөдийг дуурайх нь хэрэгтэй зүйл болохыг ойлгож ухаарчээ.

Дараа нь “Шинэ засагтай холбогдох, холбоо бүхий хууль болоод дүрмийг” үргэлжлүүлэн гаргасан байна. Энэ дундаас бидийн гол болгон судалж буй Монголтой хамаа бүхий айлтгалуудыг тухайн үед Чингийн зарим дэвшилтэт үзэлтэй захирагч сайд нараас хаанд өргөн барьж байлаа. Тухайлбал: Жан Жидун болон Лю Кунь нар 1901 онд “**Цаазыг өөрчилж, Өөрсдөө хүчжье**” гэдэг айлтгалдаа Монголчууд нүүдлийн мал аж ахуйг гол болгон амьдардаг бөгөөд сүүлийн хэдэн арван жилийн дотор үгээгүй ядуу болж, зэргэлдээ чийрэг Хаант орос улсын халхавч болгоход муудаж байгаа тул байдлыг харгалзан арга сүвэгчлэхгүй бол болохгүй¹⁶³ хэмээжээ. Энэ зарлиг бичиг нийтлэгдсэн явдал нь Монгол мэтийн гадаад аймгуудад хэрэгжүүлж байсан, хуучин хууль дүрмийг хувьсгаж, шинэ бодлогыг хэрэгжүүлэхэд түлхэц болов.

Ингээд 1902 оны 1 сарын 5 нд¹⁶⁴ Монгол газар шинэ засгийн бодлогыг ажил болгон хэрэгжүүлэхээр цэргийн журганы зүүн жигүүрийн сайд Бээжингийн Манж найман хошууны томоохон түшмэл Игү (**YiGu 贻谷**) хэмээгчийг эхлээд Хол дахиныг амаржуулагч (**Хөх хот. А.А**) хотноо томилон ирүүлж¹⁶⁵, Монгол хошуудыг хагалбарлах хэргийг тусгайлан шийтгүүлжээ. Энэ үеэс эхлэн хамгийн түрүүнд Өвөр монголын олон хошуудын бэлчээр нутаг их хэмжээгээр хагалбарлагдсан билээ. “**Иргэдийг нүүлгэн, Хязгаарыг бэхжүүлэх**” гэсэн зорилго бүхий, Монгол газрыг хагалбарлах ажил Өвөр монголд ид хүчтэй явагдаж байх энэ хугацаанд, Чингийн зарим сайд нар Ар монголд нэг адилаар атар хагалбарлан тариа тарьж, хязгаарыг бэхжүүлэх явдалыг сэдэх буюу дээд газарт айлтгаж байлаа.

Хэдийгээр Чингийн “**Шинэ засгийн бодлого**” нь хоцрогдсон Монгол оронд шинэ зууны олон дэвшилтэд өөрчлөлтүүдийг авч ирэх

¹⁶³ Монгол тулсын түүх 5-р боть, Улаабаатар. 2004, 42 тал.

¹⁶⁴ 李桔松: 从《可园诗抄》看三多任库伦办事大臣前后之心路历程, 《中国边疆史地研究》, 2016年6月第26卷第2期, 84 тал.

¹⁶⁵ Шарнууд Содбилэг. ӨМИС-ийн багш, Профессор. Чин улсын сүүлч үеийн манж, хятад сайд нарын дэвшүүлсэн монголыг засах айлтгал бичгүүдийн тухай. Proceedings of the Second International Conference. Past and Present of the Mongolic peoples, Олон улсын хоёрдугаар чуулган, Монгол туургатны эрт ба эдүүгээ, August 28-30, 2007., Ulaanbaatar, Mongolia. Edited by. Tokusu Kurebito, Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo University of Foreign Studies. 2009, 129



THE CULTURAL WAY

байсан боловч Монгол үндэстний хувьд олон мянган жилийн төлөвшиж тогтсон соёл уламжлал, хэв маяг, тусгаар байдлыг нь устгаж, Хятадын дотоод муж болгох, дөрвөн зүйлийн малаа адгуулан аж төрөх язгуурын амьдралын хэв заншлийг нь алдагдуулах, Хятад соёл, күнзийн сурталд автагдуулан Хятадчилагдах, Монгол газар үй олон Хятад тариачидыг гэр бүлийн хамт ирүүлж, суурьшуулах цаашлаад улс төр, эдийн засаг, соёлын хувьд бүрэн эзлэгдэж, үндэстнийх нь хувьд бүрэн уусгаж мөхөөх аюулт бодлого байв. Цаашлаад үндсэн хуульт засаг байгуулах сэдвийг сөхөн тавьж, Монголын хан, ван ноёд, дээд лам нарын эрх ямбанд халдах болсноор тэдний улс төрийн эрх алдагдах аюул тулгарч хойшид орших уу? Эс орших уу? гэдэг асуудал тулгарсан юм.

Шинэ засгийн бодлого нь олон талын арга хэмжээгээр илэрч байсан учир түүний мөн чанар, хор хөнөөлийг ухаж ойлгох Монголын ноёд, лам нарын танин мэдэхүйн чадвар, үнэсний ухамсар, эх оронч үзлийн хэр хэмжээ нь харилцан адилгүй байснаас Чингийн шинэ засгийн бодлогод хандах хандлага өөр өөр байжээ. Монголын ноёд, лам нарын дотор шинэ засгийн бодлогыг хэрхэн үзэх, яаж харилцах талаар хэд хэдэн хандлага бий болсон байв.

Эхний хандлага нь Монголын сэхээрсэн зарим хүмүүс шинэ засгийн бодлогыг ашиглан түүний хүрээнд Монголын хөгжлийн хоцрогдолыг арилгах, эдийн засаг, соёлыг өөд нь татах улс төрийн шаардлага тавьж “**Өөртөө засах**” эрхийг зарим талаар олж авахыг эрмэлзэх болсон аж. Ийм хандлага Өвөр монголын ноёд, лам нарын дунд нилээд үзэгджээ. 1901 онд Харчин зүүн гарын өмнөд хошууны ван Гончиг шашин шүтэхийг болиулж, мухар сүсгийг арилгах, сургууль байгуулах, ард иргэдийн оюуныг нээх, цэргийг сургаж, хил хязгаарыг бататгах, атар газрыг тариалж, аж байдлыг сайжруулах санал гаргаж байжээ¹⁶⁶. Мөн Харчин ван Гүнсээноров Монголд банк байгуулах, цаасан мөнгөн тэмдэгт гаргах, төмөр зам тавих, Монголын тариалан үйлдвэрийг хөгжүүлэх, Монгол цэргийг шинэчлэн байгуулах, шинэ цагийн сургууль байгуулах, Монгол хошуудын улс төрийн эрхийг өргөтгөх зэрэг санал тавьж зарим талаар хэрэгжүүлж байв. Эдгээр саналууд нь Монгол орныг хөгжил дэвшлийн зүг хөтлөх гэсэн Монгол хүний шинэтгэлийн эх оронч үзэлийн шинэ хэлбэр үзэгдэл байлаа.

¹⁶⁶ Л. Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн (1911-1913). Улаанбаатар. 1992, 6 тал.



THE CULTURAL WAY

Хоёр дахь хандлага нь “Язгуурын ёсыг журамлах” шашин шүтлэгээ хамгаалах уриатай Халх монголын хан, ван ноёдуудын хэсэг байлаа. “Язгуурын ёсыг журамлах” гэдэг нь Манжийн төрийн түшмэг байж, Монголын уламжлалт эзэн харьяатын харилцаа, дэг журмыг хуучин хэвээр хадгалах, Монгол орон Хятадаас тусгаар явж ирсэн байдлаа хадгалах, уламжлалт аж ахуй, соёл, шашин шүтлэгээ хадгалан үлдэх зорилго бүхий утга агуулжээ¹⁶⁷. Тэд шинэ засгийн бодлоготой зохицож соёлын салбарт хийх шинэчлэлтүүдийг нь хүлээн зөвшөөрч харин бусдыг нь зогсоох бодлого баримтлав. Эдгээр хүмүүсийн дотроос хожим үндэсний үзэлтнүүд төрөн гарч, улс орноо тусгааралсан юм. Энэ тухай манай Академич, гүн ухаантан Ч.Жүгдэр гуай бичихдээ: “Эртний түүхтэй Монгол үндэстний үзэл санаа нь Монголын феодалуудын үндсэрхэг үзлийн үндэс болж байв” Монголын феодалууд өөрийн ашиг сонирхолыг ухаарч эхэлсэн үед феодалын үндсэрхэг үзэл бий болсон бөгөөд тэр үзэл бий болоход Монгол орон Манж чин улсад эзлэгдсэн явдал шийдвэрлэх нөлөө үзүүлсэн байна¹⁶⁸ гэжээ. Монголын үдэсний үзэлтнүүд өөрсдийн ашиг сонирхолоо хамгаалах явцадаа урьдын хүчирхэг явсан үеэ эргэн санагалзаж, улс үндэстнээ баян чинээлэг, хүчирхэг улс болгохыг мөрөөдөх болсон юм. Энэ үзэл нь яваандаа үндэсний тусгаар тогтнолоо сэргээх үйл хэрэг болж, Богд гэгээнтнийг тойрсон Манжийн ноёрхолыг эсэргүүцсэн Монголын ноёд, лам нарын хүчин бүрэлдэх үндсийг тавьж өгсөн байна¹⁶⁹.

Ингээд 1902 онд Хорчины зүүн гарын дундад хошуунд Жоу (тойрог), 1903 онд Түмэд болон Хорчин хошуунд тус бүр нэг нэг Сянь (хошуу), 1904 онд Жалайд, Хорчин баруун гарын хошуунд Тин, Фу¹⁷⁰ зэрэг Хятад засаг захиргаа байгуулав. Мөн Монгол орныг шатлан эрхшээн захирахдаа байгуулсан “Гадаад монголын төрийг засаг явдалын яаманд” зарим нэг өөрчлөлт хийсэн байна. Тухайлбал: 1906 онд Гадаад монголын төрийг засаг явдлын яамны харьяанд байцаах товчоо,

¹⁶⁷ Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, Г.Дашням, Ж.Болд, Ч.Баяржаргал, С.Туяа, Б.Баттөмөр. Монгол улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун). Улаанбаатар. 2008, 13 тал

¹⁶⁸ Ч.Жүгдэр. “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм, улс төр, философи сэтгэлгээний хөгжил” Улаанбаатар. 1972, 42 тал.

¹⁶⁹ Г.Дашням. “Ар монголд манж чин улсын ноёрхолыг эсэргүүцсэн улс төрийн хүчин бүрэлдсэн нь” Монголын үдэсний хувьсгалын түүхийн судлал. Улаанбаатар. 2002, 39 тал.

¹⁷⁰ Монгол тулсын түүх 5-р боть, Улаанбаатар. 2004, 42 тал.



THE CULTURAL WAY

найруулах товчоог нэмж байгуулсан байна¹⁷¹. Энэхүү түүхэн үйл ажиллагаа нь үнэн хэрэгтээ 1905 онд явагдсан Орос, Японы дайнаас сэргийлж Монгол газрын хойд хил болон Хөлөн буйр ба Хар мөрөн зэрэг хилийн хязгаар нутаг дахь Монгол харуулуудыг Хятад цэрэг, харуулаар сольж, Хятад иргэдийг үй олноор нь суурьшуулан, гадны түрэмгийллээс сэргийлэх төдийгүй суларч доройтсон эдийн засгаа сэргээх үйл ажиллагаа, бодлого байсан юм. Ингээд Халх монгол орны хилийн дээс, захын харуулын нэр, харуулын тоо, хошууны захын овоо, хошууны хилийн дээс, харуулд суусан түшмэл болон цэргийн тоо, сэргийлэн суух цэргийн тоо, нийгмийн байдал, хүн ам зүй, байгалийн баялаг, хаана ямар ашигт малтмал, ан амьтан, мод ургамал байна. Мөн нуур болон гол мөрөн хаана байх, түүнд загас байдаг эсэх, давс хужиртай нуур байгаа юу зэрэг олон судалгааг Халх дөрвөн аймаг төдийгүй Чин улсын бүх хязгаар нутгуудаас байцаалган гаргуулж авсан байдаг. Энэ судалгааны үндсэн дээр 1907 онд Бянь Цзян Фан Чжи (Хязгаар нутгийн ойллого 边疆方志 А.А) хэмээх олон боть зохиолыг хэвлүүлсэн байна. Тус зохиолын 23 дугаар боть нь Яо Мин Хуй хэмээх зохиогчтой Мэнгү Чжи (Монголын ойллого) хэмээх нэрээр гарсан ажээ. Тус ойллого бичигт: Монгол орны уул ус, газар орны нэр, засаг захиргаа, хүн ам, зан заншил, шашин шүтлэг, гэгээрэл боловсрол, худалдаа арилжаа, байгалын баялаг, төмөр зам, харилцаа холбоо, санхүү зэрэг сэдвийг хамарсан гурван дэвтэр нийт 600 орчим хуудас материал болно¹⁷². 1906 онд Гадаад монголын төрийг засах явдлын яам, Цэргийн явдлын яам хамтран Өвөр монгол болон Халх монголын олон чуулганы хошууны эдийн засаг, байгалын баялаг, цэрэг, сургуулийн хэргийг байцаах саналыг эзэн хаандаа айлтган зөвшөөрүүлжээ¹⁷³. Дараа жил нь буюу 1907 оны хавар гадаад засаг олон Монгол аймгийн чуулган дарга нар болон Хотон аймгийн ван гүн нарт тушааж 14 зүйлийг байцаалгасан байна. Түүний агуулгыг сийрүүлбэл:

Нэгэн зүйл (1) : Хятад иргэд ба монголчуудын тарианы газрын хэмжээ, тарьдаг тариа, атаршсан газрыг сэргээж хагалбарлавал болох эсэх, сул газрыг тодорхойлох.

¹⁷¹ Лю Цзиньсо. Монголын хураангуй түүх. Хөх хот, 1985, 252 тал.

¹⁷² Л. Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн (1911-1913), Улаанбаатар. 1992, 22 тал.

¹⁷³ МУУТА, Данс- 1, фм-9, хн - 3992



THE CULTURAL WAY

Нэгэн зүйл (2) : Нэрт их ууланд ямар мод ургадаг, хөндлөн гулд хэдэн газар, түүнийг яаж өсгөн тарих, тэр модоор юу үйлдэж болох, хашаа тээвэрлэн худалдаж байгаа эсэх.

Нэгэн зүйл (3) : Тайж харц ардын адуулан тэжээж байгаа дөрвөн зүйлийн мал хэд хичнээн, бэлчээр нь хэдэн газар болох, мал адгуулан бордох аргыг тодорхойлох.

Нэгэн зүйл (4) : Ой мод, уул нуруунд олон зүйлийн гөрөөс бий эсэх, ямар ямар хүмүүс тэдгээрийг агандаг. Тэргүүлсэн хүн байдаг уу, ангаас олох орлого хэр зэрэг, агнах аргыг тодорхойлох.

Нэгэн зүйл (5) : Малын арьс шир, унгас ноос, яс эвэр зэргийг ашиллаж, боловсруулах үйлдвэр нэвэл ямар.

Нэгэн зүйл (6) : Ямар зүйлийн ашигт малтмал хаана байдаг, түүнийг ашиглаж байгаа эсэх, цаашид яаж ашиглах.

Нэгэн зүйл (7) : Аль нуурт ямар төрлийн загас байдаг, хятад монголчууд агнадаг эсэх, түүнийг хэрхэн өөр аргаар агнуулах.

Нэгэн зүйл (8) : Давст нуур бий эсэх ямар төрлийн давсыг хашаа тээвэрлэн худалдах, давст нуурын талбай хэчнээн газар, хятад монгол хүмүүс ашигилдаг бол ямар үнэ гаальтай байдаг.

Нэгэн зүйл (9) : Олон хошууны цэрэг, зэвсгийн тогтоосон тоо хэд, ямар зүйлийн зэр зэвсэгтэй, яаж сурган боловсруулдаг, цэрэг цалин авдаг эсэх, цаашид хэрхэн тэгшитгэн шийтгэх.

Нэгэн зүйл (10) : Сургууль бий эсэх, шинээр сургууль байгуулсан газар хэд, юуг баримталж байгуулсан, сургагч багш, сурагч хэд, цаашид яаж төлөвлөж байгаа.

Нэгэн зүйл (11) : Аймаг хошуудад хэдэн өртөө байдаг, тэдгээрт ажилдаг хүмүүсийн тоо, зардал сүйтгэл хэчнээн.

Нэгэн зүйл (12) : Аймаг хошуудын нутгийн зах зааг, хашаа ямар газраар зах нийлдэг, гадаад улстай зах нийлдэг.

Нэгэн зүйл (13) : Худалдааны иргэд хэд, хашаа хүрээ буй эсэх, ямар газар гадаадын хүмүүс голлон худалдаа хийдэг, цаашид худалдаачдыг хэрхэн ирүүлэх.



THE CULTURAL WAY

Нэгэн зүйл (14) : Хятадын аль мужаас худалдаачин, цэрэг иргэн ирэхэд тохиромжтой их зам буй, яаравчлан төмөр зам барьвал хаанаас залгаж тавих зэргийг байцаажээ¹⁷⁴. Мөн оны сүүлээр Чин улсын төр Өвөр монгол, Халх монголын олон засаг хошуу 14 зүйлт байцаалтыг хэрхэн явагдуулж байгааг газар дээр нь биечлэн хянах түшмэдийг анги хуваан мордуулсан байна¹⁷⁵. Мөн 1907 онд Монголын аймаг хошуудын газрын зургийг зуруулан авч бэлтгэл ажлыг бүрэн хангасны дараа¹⁷⁶ Чин улсын хаан тус ондоо Монгол нутгийг хагалбарлаж тариа тарих зарлиг буулгажээ¹⁷⁷. Гэвч Халх монголын олон хошуу дээрх 14 зүйлийн байцаалтыг гаргаж өгөхгүй удааж, элдэв шалтаг тоочиж худал байцаалтуудыг гарган өгч, Чин улсын “Шинэ засгийн бодлогыг” эсэргүүцэж байжээ. Тухайлбал: Халхын Түшээт хан аймгийн засаг тэргүүн зэрэг тайж Лувсандовын дээш өргөсөн нэгэн бичигт: *“Нэгэн зүйл: ...Харьяат захирсан газрын дотор тариалан эрхлэж буй болон эрхлэхэд тохиромжтой газар буй үгүй, аль газар буйг нээх ба одоо хэрхэн шийтгэхийг тодорхойлсугай хэмээснийг хянабаас манай хошууны нутагт тариаланг ядуу иргэд бага сага эрхлэх боловч тариа тарихад тохиромжтой газар үгүй. нэгэн зүйл: ...Харьяат захирсан газрын дотор ямар зүйлийн уурхай буй үгүй, аль газар буйг нээх ба одоо хэрхэн шийтгэхийг тодорхойлсугай хэмээснийг хянабаас манай хошууны нутагт нээж шийтгэх нэг ч уурхай үгүй. Мөн ...Захын дотор давст нуур буй үгүйг тодорхойлсугай хэмээснийг хянабаас манай хошууны нутагт давс гарсан нуур нэг ч үгүй”*¹⁷⁸. Гэх мэтчилэн нийт Халх монгол даяараа 14 зүйлийн байцаалтыг эсэргүүцэж байлаа.

Чин улсын төр засаг нэгэнт хувиран өөрчлөгдөж байгаа цагийн аяс, улс орныхоо суларч доройтсон байдлыг чангатган сайжруулахын тулд, улсынхаа хүч чадлын чухал нэгэн хэсэг болсон цэрэг армия өрнөдийн хэв загвараар засаж цэгцлээд, цэргүүддээ бариулах буу зэвсгийг шинэчлэн сайжруулах арга алхам авч эхэлсэн байна. Тухайлбал 1907 оны 11 сарын 16 нд Чин улсын хаанаас буу зэвсэг худалдан авах дүрэм хэмжээг чангатгах тухай зарлиг нийтлэн гаргажээ.

¹⁷⁴ МУУТА, Данс- 1, фм-9, хн – 3987., МУУТА, Данс- 3, фм-9, хн - 8379

¹⁷⁵ Л. Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн (1911- 1913). Улаанбаатар. 1992, 23 тал.

¹⁷⁶ МУУТА, Данс- 1, фм-9, хн – 3987.

¹⁷⁷ Л. Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн (1911- 1913). Улаанбаатар. 1992, 24 тал.

¹⁷⁸ МУУТА, Данс- 3, фм-9, хн - 8379



THE CULTURAL WAY

Буу зэвсэг худалдан авах дүрэм хэмжээг чангатгах тухай Манж хааны зарлигт:

Зарлигаар зарсан Улиастайн жанжны тамга хэргийг түр сахисан хувийн сайдуудын бичиг: Цэцэн хан аймгийн чуулган дарга нарт илгээв.

Мөнөөхөн Гадаад Монголын төрийг засах явдлын яамнаас хүргэж ирсэн Хятад үсгийн бичигт: *“...Гадаад дотоод олон засгийн дотор эр үржиж сум зохиох ба эсвээс хуучирсан цэргийн зэвсгийг нөхөн засаж буй аваас харьяат засаг худалдан авах цэргийн зэвсгийн тоог тодорхойлон журганд мэдүүлээд, уламжлан хуурай замын цэргийн журганд явуулаад нөхөж бичсэн тэмдэгт бичиг өгч зарилгийг гуйн худалдан авхуул, хэрвээ тэмдэгт бичгийн дотор тооноос илүү хэмээн нотлогдвоос засаг ба засаг бус ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж, тавнан боловоос 6 сарын пүнлүүг нь хасах. Сул тайж, хошуу захирах зангиаас доош орлон хөөгчөөс дээш бол нижгээд есөн малаар торго, харц хүн болвоос 80 ташуур занчи, илүү авсан цэргийн цэвсгийг албанд оруул, бас зургаан чуулганы дарга тус чуулганы олон хошууны цэргийн сав хар зэвсгийг байцаан үзэхдээ нэг газарт нарывчлан тоолон байцаа, хэрвээ дутуу дулимаг, хуучирсан газар байх аваас засгийн 1 жилийн пүнлүүг хасаж, пүнлүүгүй тайж, тавнан, хошууг захирах занги нарыг хоёр ба есөн малаар торго. Хуяг тэмдэгт бүс эс хадсан ба цэргийн зэвсэг юмны дор тэмдэггүй, моринд тэмдэг хадсангүй, тэмдэгт мод зүүсэнгүй, их зэв дор нэргүй боловоос засгийн 6 сарын пүнлүүг хасах, пүнлүүгүй тайж, тавнан, хошуу захирах занги нарыг нэг есөн малаар торго. Зүй нь манай явдлын яамнаас тогтоосон хуулийг тодорхойлон гаргаж, тушаан явуулаад мөрдөн дагаж сахиулбаас зохимой. Одоо олон харьяат Монгол хошуу гадаад улсын бууг эрж худалдан аваад, цэрэг боловсруулж цөм газар орныг хамгаалан харгалзах нь чухал болов. Олон далайн боомтоос гаргах цэргийн цэвсэг дарыг зөөн хүргүүлэхэд нэн болгоомжилвоос зохимой”*¹⁷⁹ гэжээ.

Дээрх баримтаас үзвэл тухайн үеийн Чин улсын цэрэг арми бүтэц зохион байгуулалтын хувьд тэр үеийнхээ дэлхийн ертөнцийн шинэ дэвшилээс хол хоцорсон байжээ. Яг үнэндээ бага сага болхи бүдүүлэг цахиур буу, үхэр буу байсан авч, их төлөв өнөөл хуяг дуулга, нум сум, сэлэм жадтайгаа зууралдсан хэвээр байв. Гэтэл Чин улсад түрэн орж ирсэн өрнөдийн улсуудын цэрэг арми шинэ цагийн хурдан буу, их буу,

¹⁷⁹ МУУТА, Данс- 2, фм-31, ХН – 5235.



THE CULTURAL WAY

шүршигч буу хэрэглэхээс гадна, аялан байлдах арга тактик нь ихээхэн хувирсан байлаа. Иймээс энэ байдал доор найман улсын цэрэгт ялагдсан Чин улс цэрэг армидаа “Шинэ засгийн бодлого”-ын хүрээнд шинэчлэлт хийж эхэлсэн юм.

Чингийн төрөөс “**Шинэ засгийн бодлого**” –ын хүрээнд хийсэн бас нэгэн ажил бол 1908 оноос Хар мөрөн мужийн захиргаанаас “Бүгдийг захирагч сайд амбан нарын тушаалаар”, “**Монгол үгийн бодорол**” хэмээх сониныг сард нэг удаа хэвлэн гаргаж байлаа. Сонины эхийг Хятад хэл дээр бэлдэх боловч Монгол хэлдээр орчуулж, дугаар бүр нь 700 хувь хэвлэгдэн Ар монгол, Өвөр монголын аймаг хошуудад үнэгүй тараагддаг байжээ. “Монгол үгийн бодорол” сонинд Чин улсын “Шинэ засгийн бодлого”-ба түүний үйл ажиллагааг сурталчилан бичихийн зэрэгцээ Манж чингийн төрд үнэнчээр хүмүүжүүлэх, бусад улс орны зүгээс Монголд нөлөөлөх замд нь саад учруулах зорилго бүхүй ухуулан сэхрүүлэх сонин байжээ¹⁸⁰.

Энэ түүхэн цаг үед харь гүрнүүд Монголын газар нутагруу өнгөлзөх нь улам ихсэж, тэр дундаа Орос, Чин улсын хооронд байгуулсан худалдааны гэрээ, хэлэлцээрийн дагуу Монголд Орсын худалдаа дэлгэрч, Монголчууд Оростой ойртох зам нээгдэв. Иймээс түүнийг сэргүүлэн Чингийн засгийн газар Монгол дахь Хятадын худалдааг аль болох өргөжүүлэх бодлого баримтлан өрсөлдөж байв. Мөн XIX зууны сүүлчээр Хятадын тариалангийн олон газар хүчтэй үер бууж, бас ган гачиг болсноор олон зуун мянган тариачид ядуурчээ. Иймээс бухимдсан тариачид гадаадын капиталист (**Хөрөнгөтөн**) гүрнүүд хийгээд өөрийн улсынхаа хаад, ноёдыг эсэргүүцэн удаа дараалан босон тэмцэж байлаа.

Уур хилэн нь бадарсан олон зуун мянган тариачдын бослого тэмцлээс айсан Чин улсын төр засаг тэднийг тайвшруулж номохруулахын тулд эзэнт гүрний дотрох аль сул чөлөөтэй газар суулгахаас өөр аргагүй болж байжээ¹⁸¹.

Түүхэн энэ цаг үед Монгол оронд шинэ засгийн бодлогоог хэрэгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн түүхэн хүний нэг бол Манж амбан сайд Сандо яах аргагүй мөн юм. Учир юу гэвэл Халх монголд Чин улсын “**Шинэ засгийн бодлого**” энэ хүнтэй хамт явагдаж бас энэ хүнтэй хамт дуусгавар болсон түүхтэй юм.

¹⁸⁰ Г. Дэлэг. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. Улаанбаатар 1965, 6-7 тал.

¹⁸¹ Хэрээд Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919) . Улаанбаатар. 2010, 34 тал.



THE CULTURAL WAY

НОМ ЗҮЙ

Судалгааны бүтээл:

1. Лю Цзиньсо. Монголын хураангуй түүх. Хөх хот. 1985
2. Монгол тулсын түүх 5-р боть, Улаабаатар. 2004
3. Юн чан. Цыши хатан. 2015
4. Л.Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн (1911- 1913). Улаанбаатар. 1992
5. Ж.Болдбаатар, Ч.Дашдаваа, Г.Дашням, Ж.Болд, Ч.Баяржаргал, С.Туяа, Б.Баттөмөр. Монгол улсын хөгжлийн бодлого, үзэл баримтлал: хувьсал, өөрчлөлт (XX зуун) . Улаанбаатар. 2008
6. Ч.Жүгдэр. “XIX-XX зууны зааг дахь монголын нийгэм, улс төр, философи сэтгэлгээний хөгжил” Улаанбаатар. 1972
7. Г.Дашням. “Ар монголд манж чин улсын ноёрхолыг эсэргүүцсэн улс төрийн хүчин бүрэлдсэн нь” Монголын үдэсний хувьсгалын түүхийн судлал. Улаанбаатар. 2002
8. Г. Дэлэг. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. Улаанбаатар 1965
9. Хэрээд Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919) . Улаанбаатар. 2010
10. Н.В.Морс, The International Relations of the Chines Empire. 3-р боть

Эрдэм шинжилгээний өлүүлэл:

1. 李桔松：从《可园诗抄》看三多任库伦办事大臣前后之心路历程，《中国边疆史地研究》，2016年6月第26卷第2期
2. Шарнууд Содбилэг. ӨМИС- ийн багш, Профессор. Чин улсын сүүлч үеийн манж, хятад сайд нарын дэвшүүлсэн монголыг засах айлтгал бичгүүдийн тухай. Proceedings of the Second International Conference. Past end Present of the Mongolinc peoples, Олон улсын хоёрдугаар чуулган, Монгол туургатны эрт ба эдүүгээ, August 28-30, 2007., Ulaanbaatar, Mongolia. Edited by. Tokusu Kurebito, Research Institute for Languages and Cultures of Asia and Africa, Tokyo University of Foreign Studies. 2009



THE CULTURAL WAY

Архивын баримт:

1. МУУТА, Данс- 1, фМ-9, ХН – 3992.
2. МУУТА, Данс- 1, фМ-9, ХН – 3987.
3. МУУТА, Данс- 3, фМ-9, ХН – 8379.
4. МУУТА, Данс- 2, фМ-31, ХН – 5235.

ABSTRACT

This article traces the history of the new government policy pursued by the Qing Dynasty since the late 19th century, including how the history of the new government in Mongolia was based on historical archival documents. . Since the middle of the 19th century, the Qing Dynasty has been plagued by many foreign and domestic wars, and the country's internal situation has worsened. , has made many statements to the emperor.

Therefore, the Qing emperor issued an edict urging officials and officials to submit statements and thoughts on the importance of acceptance and reform. At that time, there were a lot of suggestions from below for reforms to be made in the country, but there were a lot of suggestions related to Mongolia. For example, many proposals have been made, such as relocating citizens, strengthening the borders, improving the living conditions of the steppe, eradicating superstitions, establishing schools, opening the minds of the people, training the military and preventing the border. Based on these statements, the Qing government formally announced the new government's policy in 1901.

ОРДОСЫН ТЭЛЭНГҮД ОВОГ ХИЙГЭЭД ДУУДАГЧИЙН ТУХАЙ

Солонгод Л.Хурцбаатар *

ХУРААНГУЙ

Тэлэнгүд овог бол аль эртний ойн иргэдээс үүсэлтэй язгуур монгол түрэг овгийн нэг болно. Тан улсын үед Сэлэнгэ, Туул голын сав газраар нүүдэллэж, арван гуравдугаар зуунд Чингисийн олон зуун овог аймгийн түмт мянгатын цэргийн бүрэлдэхүүний нэг болж, сүүл хожмын үед Ордос нутагт нүүдэллэн иржээ. Тэлэнгүчүүд бол угаасаа атаа мөнх тэнгэрийн “аянган тэнгэр”-ийн элчийн хувиар тэнгэр догшуулгад бороо, салхийг хариулах, “дуудагч” үүрэгтэй байжээ. 601 онд бичигдсэн “Хүйс толгойн бичээс”-ний хамгийн эртний өвөг монгол хэл, монгол брахми бичгээр “Хири Хэргин Барго Пахирухачи” гэж “дуудагч” гэдгийг “пахирухач-бархирагч” гэж бичиж байв. Тэлэнгүсчүүд аль эртнээс бөө мөргөлийн тэнгэр сүнсний дуудагч бөгөөд оточ эмч байжээ.

Түлхүүр үгс: Тэлэнгүс, Тэлэнгүд, Төлөнгүс, Төлөнгүд, дуудагч, пахирухачи – бархирагч, эмч оточ

Тус өгүүлэл нь Солонгод Л.Хурцбаатарын судлал бүтээлийн цуврал танилцуулга №.06 бөгөөд “МОНГОЛ СУРВАЛЖ БИЧИГ”-ийн судлалын агуулгаас эшлэн бичигджээ.

“Хүйс толгойн бичээс”-ийг гол сурвалж болгон тууриривжээ.

Өгүүллийн бүтэц:

1. Тэлэнгүд овгийн үүсэл гарал
2. Тэлэнгүд овогтны онцгой үүрэг хариуцлага
 - 2.1 Бархирагч буюу дуудагч
 - 2.2 Эмч буюу домчийн үүрэг хариуцлага

* Герман улсын ОУ-ын Кино чуулган хэвлэлийн нийгэмлэг, ОУ-ын Монгол Брахми судлалын нийгэмлэгийн тэргүүн.

2021.01.08


Хуульчилсан төсвийн зардалын тухай хууль

— «2021 оны төсвийн зардалын тухай хууль»-ийн 601-дүгээр зүйл
«Хуульчилсан төсвийн зардалын тухай хууль»-ийн 601-дүгээр зүйл

«Хуульчилсан төсвийн зардалын тухай хууль»-ийн 601-дүгээр зүйл

Хуульчилсан төсвийн зардалын тухай хууль No.06

1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 1-1955 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 2-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 3-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 4-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 5-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 6-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 7-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 8-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 9-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 10-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг.



1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 1-1955 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 2-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 3-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 4-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 5-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 6-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 7-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 8-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 9-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг. 10-1955-1957 оны үйлдвэрлэлийн үр дүнгийг харуулсан зураг.

10. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
9. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
8. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
7. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
6. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
5. « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
4. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
3. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
2. « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд
1. Үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд « үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд

Төгсгөлөөр :

« үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд » үндэстний төлөө үйлдсэн үйлдлийн үр дүнд

**“СОЁЛЫН ЖИМЭЭР” эрдэм шинжилгээний сэтгүүлд
ӨГҮҮЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ**

Ерөнхий шаардлага:

- Урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Монгол судлал ба түүх, соёлын чиглэлийн асуудлыг хөндсөн байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, шинэлэг үзэл санаа дэвшүүлсэн байх
- Судалгааны логик уялдаа, дэс дараалал тодорхой байх

Техник шаардлага:

- Кирил үсгээр бичигдсэн байх (үүний хамт гарчиг, товч агуулга, түлхүүр үг зэргийг англи хэл дээр бичих)
- Хэл зүй хийгээд найруулга зүйн ямар нэг алдаагүй байх
- Үг үсгийн алдаагүй байх
- Цаасны хэмжээ В5
- Үсгийн өндөр 12
- Эшлэл зүүлтийг тухайн хуудсанд хийх эсвэл АРА форматаар бичсэн байх (үсгийн өндөр 10)
- Нүүрийн тоо – 8-15

Судалгааны ажлын бүтэц:

Гарчиг

- Гарчиг англи хэл дээр (content)
- Судлаачийн овог нэр, эрдмийн цол зэрэг, эрхэлж буй ажил, и-мэйл хаяг, утасны дугаарыг бичих
- Товч агуулга
- Товч агуулга англи хэл дээр (abstract)
- Түлхүүр үг
- Түлхүүр үг англи хэл дээр (key word)
- Судалгааны үндсэн хэсэг
- Дүгнэлт
- Ном зүй
- Дагалдуулал (хэрвээ шаардлагатай бол үйлдэх)

Өгүүлэл хэвлэгдэх явц:

- Өгүүлэл хүлээн авна.
- Өгүүллийг редакцийн гишүүд шүүн хэлэлцэнэ.
- Хэвлэх ба үл хэвлэхийг шийднэ.
- Хэвлэгдэх боломжтой засварлах, өөрчлөх зүйлс буйг мэдэгдэнэ (тодорхой хугацаа өгнө).
- Өгүүлэл хэвлэгдэнэ.

8-15 – גילום למחקר -

(10 מקומות למחקר)

מקומות למחקר APA גורמים לרוב מקומות למחקר

12 מקומות למחקר -

B5 מקומות למחקר -

מקומות למחקר למחקר מקומות

מקומות למחקר למחקר מקומות למחקר

מקומות למחקר למחקר מקומות

מקומות למחקר למחקר מקומות למחקר

מקומות למחקר :

מקומות למחקר למחקר מקומות

מקומות למחקר למחקר מקומות למחקר

מקומות למחקר למחקר מקומות למחקר

מקומות למחקר למחקר מקומות

מקומות למחקר :

מקומות למחקר למחקר מקומות למחקר

- אלקטרוניקה ..

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר • אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר (מערכת מיקרוקונטראולר) ..

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר ..

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר ..

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר ..

אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר :

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר (מערכת מיקרוקונטראולר)

- אלקטרוניקה

- אלקטרוניקה

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר (key word)

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר (abstract)

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר

אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר • אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר • E-mail

- אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר (content)

- אלקטרוניקה

אלקטרוניקה ופיתוח מערכת מיקרוקונטראולר :